# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2022 оны жилийн эцэс/

2023 оны 01 дүгээр сарын 23

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.**

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.**

Монгол Улсын хууль, Улсын Их Хурал болон УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гарсан шийдвэр, зүйл, заалтыг хяналтад авч, яамны нэгжүүдийн 2022 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг удирдлага болгов.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн цахим хуудсанд байршуулсан шийдвэр, зүйл, заалтын хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 5 дугаар хавсралтын дагуу гаргуулав.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.**

2022 оны жилийн эцсийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим системд байршуулсан нийт 114 шийдвэрийн 258 зүйл, заалтыг дээр дурдсан салбар чиглэлээр ангилж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг **85.33** хувийн биелэлттэй гэж дүгнэв.

Нийт 114 шийдвэрийн 258 зүйл, заалтын 16 зүйл, заалтад үнэлгээ өгөөгүй бөгөөд хэрэгжилтийг дүгнэсэн 242 зүйл, заалтын 146 зүйл, заалт буюу 60.3% нь "бүрэн хэрэгжсэн" 100 хувийн биелэлттэй, 80 зүйл, заалт буюу 33.0% нь "хэрэгжих шатанд" 70 хувийн биелэлттэй, 15 зүйл, заалт буюу 6.1% нь "хэрэгжилт хангалтгүй" 30 хувийн биелэлттэй, 1 зүйл, заалт буюу 0.4% нь "хэрэгжээгүй" 0 хувийн биелэлттэй байна.

## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ
### /Хууль тогтоомжийн төрлөөр/

Хүснэгт-1

| | | Бүгд | Монгол Улсын хууль | Улсын Их Хурлын тогтоол | УИХ-ын Байнгын хорооны тогтоол | Ерөнхийлөгчийн зарлиг | ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | Засгийн газрын тогтоол | Ерөнхий сайдын захирамж | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | Засгийн газрын албан даалгавар | Ерөнхий сайдын албан даалгавар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хяналтад авагдсан шийдвэрийн тоо | | 113 | 8 | 11 | 7 | 4 | 2 | 33 | - | 44 | 4 | - |
| Заалтын тоо | | 258 | 55 | 32 | 25 | 6 | 2 | 42 | - | 88 | 8 | - |
| Үүнээс | “бүрэн хэрэгжсэн” 100% | 146 | 49 | 20 | 14 | 6 | 1 | 22 | 0 | 30 | 4 | 0 |
| | “хэрэгжих шатанд” 70.0% | 80 | 1 | 9 | 9 | 0 | 1 | 12 | 0 | 44 | 4 | 0 |
| | “хэрэгжилт хангалтгүй” 30.0% | 15 | 0 | 1 | 1 | 0 | 0 | 4 | 0 | 9 | 0 | 0 |
| | “хэрэгжээгүй” 0% | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 |
| | Үнэлгээ өгөөгүй | 16 | 5 | 2 | 1 | 0 | 0 | 4 | 0 | 4 | 0 | 0 |
| | Үнэлгээ | 85.3 | 99.4 | 88.6 | 85.8 | 100.0 | 85.0 | 83.2 | 0 | 75.6 | 85.0 | 0 |

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг төрлөөр нь авч үзвэл:

- Монгол Улсын 8 хуулийн 55 заалтын хэрэгжилт – 99.4%;
- Улсын Их Хурлын 11 тогтоолын 32 заалтын хэрэгжилт – 88.6%;
- УИХ-ын Байнгын хорооны 7 тогтоолын 25 заалтын хэрэгжилт – 85.8%;
- Ерөнхийлөгчийн 4 зарлигийн 6 заалтын хэрэгжилт – 100.0%;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2 шийдвэрийн 2 заалтын хэрэгжилт – 85.0%;
- Засгийн газрын 33 тогтоолын 42 заалтын хэрэгжилт – 83.2%;
- Засгийн газрын хуралдааны 44 тэмдэглэлийн 88 заалтын хэрэгжилт – 75.6%;
- Засгийн газрын 4 албан даалгаврын 8 заалтын хэрэгжилт – 85.0%

**Дөрөв. Дүгнэлт**.

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан 113 шийдвэрийн 258 зүйл, заалтын 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийг **85.33** хувийн биелэлттэй гэж дүгнэлээ.

2. Нийт 258 зүйл, заалтын 16 зүйл, заалтад үнэлгээ өгөөгүй, 146 зүйл, заалт “бүрэн хэрэгжсэн” 100 хувийн биелэлттэй, 80 зүйл, заалт “хэрэгжих шатанд” 70 хувийн биелэлттэй, 15 зүйл, заалт “хэрэгжилт хангалтгүй” 30 хувийн биелэлттэй, 1 зүйл, заалт “хэрэгжээгүй” 0 хувийн биелэлттэй байна.
3. Засгийн газрын хуралдааны 2021 оны 36 дугаар тэмдэглэл “X.1.4 заалтын хэрэгжилтийг “хэрэгжээгүй” 0 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн. Уг тэмдэглэлээр Тогтоол хүчингүй болгох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов. 2. Энэ тогтоолоор хүчингүй болгосон тогтоол, тогтоолын заалтын үр дүнд аж ахуйн нэгжүүд, эдийн засаг, төсөвт үзүүлж буй нөлөөллийг нэг жилийн хугацаагаар үнэлж дүгнэн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа 2022 оны 2 дугаар улиралд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт”-ээр даа даалгасан боловч одоог хүртэл хүчингүй болсон тэмдэглэл ирээгүй гэсэн тайлан ирүүлсэн байна.
4. Нийт 15 зүйл, заалтын хэрэгжилтийг “хэрэгжилт хангалтгүй” 30 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн бөгөөд үүнийг салбар чиглэлээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:
    - Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн түүний нөөцийн бодлого – 4;
    - Уул уурхайн бодлого – 6;
    - Хүнд үйлдвэрийн бодлого – 2;
    - Нийтлэг асуудал – 3;
5. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа боловч хэрэгжилтийг тайлагнахдаа ажлын гол үр дүнг товч тодорхой (тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаан), баримт нотолгоонд суурилсан байдлаар тайлагнах шаардлагатай байна.

**Тав. Зөвлөмж.**

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Шинэ сэргэлтийн бодлого" зэрэг баримт бичгүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлттэй уялдуулан тайлагнах;
2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн “Хэрэгжилтийг хангах, үр дүнг сайжруулах тухай” 03 дугаартай албан даалгаварын хэрэгжилтийг хангаж ажиллах;
3. Төрийн захиргааны удирдлагын газраас хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг (дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудаас гаргуулж) нэгтгэн боловсруулахдаа тухайн зүйл, заалтаар өгөгдсөн үүрэгт хамаарах хэрэгжилтийг оновчтой, тодорхой байдлаар (тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаан) гаргуулах,

холбогдох тушаал, шийдвэр болон албан бичгүүдийн огноо, дугаарыг тодорхой бичүүлэх, үг үсэг, утга найруулгын алдааг засах;

4. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын нэгдүгээр хавсралтад зааснаар Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 02 дугаар сарын 15, 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ЗГХЭГ-т хүргүүлдэг тул энэ хугацаанаас ажлын 5 хоногийн өмнө нэгтгэн боловсруулсан тайланг албажуулж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэх;
5. “хэрэгжээгүй” 0 хувь, “хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувийн биелэлттэй дүгнэгдсэн, хэрэгжилтийн явц удаашралтай байгаа ажлуудыг эрчимжүүлэх, он удаан жил хэрэгжилт хангагдахгүй байгаа холбогдох шийдвэрийн зүйл, заалтыг хүчингүй болгуулах, дараагийн шийдвэрийг гаргуулах талаар тодорхой арга хэмжээг авч ажиллах.

Жич: Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хийсэн үнэлгээний тайлан, нэгтгэлийг хавсаргав.

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга [signature] Т.Баасанпүрэв

Үнэлгээ хийж, танилцуулга боловсруулсан:
ХШҮДАГ-ын шинжээч [signature] Д.Болортуяа

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР БАТЛАГДСАН
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
/2022 оны жилийн эцсийн байдлаар/

2023 оны 01 дүгээр сарын 23-ний өдөр

| *№* | *Шийдвэрийн дэс дугаар* | *Зүйл, заалтын дэс дугаар* | *Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга* | *Хэрэгжилтийн явц* | *Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)* | *Тасарсан болон удааширч байгаа шалтгаан* |
|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| | | | **1.а. Монгол Улсын хууль** | | | |
| 1 | 1 | 1 | **Цөмийн энергийн тухай**<br>**2009-07-16**<br>**Дугаар 2009.07.16**<br>28.10. Энэ хуулийн 28.9-д заасан мөнгөн хөрөнгийн хэмжээг нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд учирч болох эрсдлийг харгалзан геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, байгаль орчны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтран гаргасан саналыг үндэслэн Засгийн газар тогтооно. (28.9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх үүргээ биелүүлэх баталгаа болгон Төрийн санд мөнгөн хөрөнгө байршуулна.) | Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 21 дүгээр захирамжаар уурхайн нөхөн сэргээлт, хаалтын үйл ажиллагаанаас тусдаа зөвхөн гэнэтийн аюул, осолтой холбогдон нийгэмд бий болох хохирлыг /эрүүл мэнд, байгаль орчин, аюулгүй байдал/ арилгахад шаардагдах мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтооход чиглэсэн Уул уурхайн сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгээс гаргасан дүгнэлтийн дагуу Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Зөөвч овоо ордын ашиглалтын MV-018915 дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч "Бадрах энержи" ХХК-ийн ураны ордын технологийн туршилт явуулахтай холбогдуулан Засгийн газрын 2018 оны 371 дүгээр тогтоол гарсан. Тогтоолын дагуу Төрийн санд мөнгөн хөрөнгө байршуулах гэрээний төслийг УУХҮЯамнаас боловсруулан СЯ, БОАЖЯ, МХЕГ, ЦЭК, АМГТГ-аас холбогдох саналыг авч тусгасан. Гэрээг 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр УУХҮЯамны Төрийн нарийн бичгийн дарга, Бадрах Энержи ХХК-ийн гүйцэтгэх захирал нар байгуулсан. Бадрах энержи ХХК нь Цөмийн энергийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.9, 28.10-т тус тус заасны дагуу 2019.11.20-нд тус яамны тусгай сангийн дансанд 900000/есөн зуун мянга/ ам.долларыг байршуулсан байна. Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт 192.2 мян.тн ураны геологийн нөөц байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар ураны хайгуулын 6, ашиглалтын 8 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. | 100% | |
| 2 | 1 | 2 | 15.2. Дараах үйл ажиллагааг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ: 15.2.1.цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх; 15.2.2.цацраг идэвхт ашигт | 2019 онд Олон улсын атомын энергийн агентлагт "Ураны үйлдвэрлэлийн талбайд үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээ" авах хүсэлтийг Монгол Улсын Цөмийн Энергийн Комиссоос тавьж 2022 оны 05 дугаар сарын 09-20-ны өдрүүдэд Бадрах энержи ХХК-ны Зөөвч-Овоо, Дулаан-Уул төслүүдийн газарт очиж ажилласан. UPSAT-ийн зөвлөх үйлчилгээний баг Монгол Улсын Засгийн газарт цацраг идэвхт | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | малтмал ашиглах; 15.2.3.цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах болон цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх. | ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох, хууль, хяналтын үйл явц зэрэг эрх зүйн зохицуулалтын дэд бүтцийг боловсронгуй болгох, хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт 16 зөвлөмж, 14 санал, эрх бүхий төрийн байгууллага болон оператор компанийн нэвтрүүлсэн 4 сайн туршлагыг тусгасан тайланг эцэслэн энэ оны 9 сарын 27-нд ирүүлсэн. Цөмийн энергийн комиссоос /UPSAT/ үнэлгээний багийн хийсэн үнэлгээнээс хэрэгжүүлэх арга хэмжээ, холбогдох төсвийн саналыг авахаар ирүүлсний дагуу саналыг боловсруулж ЦЭК-ийн мэргэжилтэн Э.Нямжавд албан бичгээр хүргүүлсэн.<br>Цөмийн Энергийн Комиссын Ажлын албанаас ирүүлсэн албан бичгийн хүрээнд ОУАЭА-ийн төлөөлөл зөвлөх үйлчилгээний бэлтгэлийг хангах "Ураны боловсруулалтын талбайн үнэлгээний баг"-тай Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Зөөвч овоо, Дулаан уул цацраг идэвхт ашигт малтмалын ордын үйл ажиллагаатай танилцахаар 2022 оны 05 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд газар дээр ажилласан.<br>Ашигт малтмал, газрын тосны газар болон Бадрах энержи ХХК-ны хооронд байгуулсан орд ашиглах гэрээний хэрэгжилтийн хүрээнд тус компаниас 2022 оны 11 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд "Уран ба газар дор уусган олборлолт" сэдэвт сургалтыг зохион байгуулсан ба Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, УУХ, КХ, АМХХ, ТУЗГ-аас нийт 12 холбогдох мэргэжилтэн уг сургалтад хамрагдсан.<br>Цөмийн энергийн комиссын 2022 оны хуралдаанаар хэлэлцэх асуудалд Цөмийн энергийн тухай хуулийн 15.2.3. "цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах болон цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх" тусгай зөвшөөрөл боловсруулах ажилд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах саналыг 2022 оны 01 дүгээр сарын 25 ны өдөр e.nyamjav@nea.gov.mn email-ээр ирүүлсэн. Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын үе шат:<br>1. 2022 оны эцсийн байдлаар Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын 5 тусгай зөвшөөрөл /XV-021700, XV-018243, XV-018247, XV-007856, XV-012685/-ийг эзэмшигч 3 аж ахуйн нэгж /Монгол ураниум ресурс, Зараяа холдингс, Алкалли метал монголиа/ байх ба 2021 онд голчлон баганат өрөмдлөг, цооногийн каротаж, талбайн геофизик, лабораторийн шинжилгээ зэрэг ажлуудыг нийт 690 орчим сая төгрөгийн зардал гаргаж хийж гүйцэтгэсэн байна. | | |
| 3 | 2 | 3 | **Хог хаягдлын тухай /Шинэчилсэн найруулга/<br>2017-05-12<br>Дугаар 2017.05.12** | Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журмын төслийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн "Журам батлах тухай" А/87 дугаар тушаалаар батлуулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу холбогдох | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 8.6.Хог хаягдлын талаар уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>8.6.2. Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам батлаж, хэрэгжилтэд хяналт тавих; | материалуудыг нэгтгэн боловсруулж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсний дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 4797 дугаарт бүртгүүлсэн. | | |
| 4 | 3 | 4 | **Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01**<br>55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Нийгмийн баталгааны хөтөлбөрийн хугацаа дуссан. 2023-2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн төслийг боловсруулан ажиллаж байна. Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/44 дүгээр тушаалаар батлагдсан "Агентлагийн ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг боловсруулан батлуулсан. Уг хөтөлбөрийн хүрээнд жил бүр төлөвлөгөөг боловсруулан батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/46 дугаар тушаалаар батлагдсан "Ашигт малтмал, газрын тосны газрын албан хаагчдын 2021-2023 хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөр"-ийг 2 дугаар хавсралтаар боловсруулан батлуулсан. Уг хөтөлбөрийн хүрээнд жил бүр төлөвлөгөөг боловсруулан батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% | |
| 5 | 4 | 5 | **Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 Дугаар 2020.04.29**<br>8.1.4.. Дамжин өнгөрөх болон улс хоорондын ачаа тээвэр, эрдэс баялгийн экспортын хүрээнд ачаа тээврийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох журмыг батлах; (8.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар Улсын онцгой комисс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:) | Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын 2020.04.30-ны өдрийн тушаалаар "Хилийн автозамын боомтоор улс хоорондын ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам"-ыг баталсан. Энэхүү журмын 1.4.-д "Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг Онцгой нөхцөл байдалд зохион байгуулах" тухай асуудлыг тусгуулсан. | 100% | |
| 6 | 5 | 6 | **Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/** | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/81 тушаалаар "Геологи, уул уурхай, газрын тос болон хүнд үйлдвэрийн салбар"-ын 2020-2024 оны стратеги төлөвлөгөөг батлуулсан. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 06 | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **2020-05-07**<br>**Дугаар 2020.07.01**<br>13.3.. Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан хэрэгжүүлнэ. | дугаар сарын 21-ний өдрийн А/170 тушаалаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020-2024 оны стратеги төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. | | |
| 7 | 5 | 7 | 21.5. Салбарын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтын биелэлтийг жил бүр тогтоосон хугацаанд Засгийн газарт ирүүлнэ. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж (нийт 174 шийдвэрийн 303 зүйл, заалтын биелэлт 85.1%-тай дүгнэгдсэн), үнэлгээний дүнг яамны Удирдлагын зөвлөлийн 2022.06.29-ний өдрийн 06 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн, 2022.07.01-ны өдрийн "Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт хүргүүлэх тухай" 01/1892 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын ХШҮ-ний мэдээллийн цахим санд хэрэгжилтийг оруулж баталгаажуулсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 2022 оны I улирлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж (нийт 52 шийдвэрийн 132 зүйл, заалтын биелэлт 81.7%-тай дүгнэгдсэн), 2022.05.24-ний өдөр Засгийн газрын ХШҮ-ний мэдээллийн цахим санд биелэлтийг оруулж баталгаажуулав. -УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ (70.0%) хийж, Удирдлагын зөвлөлийн 2022.01.17-ны өдрийн 01 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн, 2022.01.18-ны өдрийн "ХШҮ-ний тайлан хүргүүлэх тухай" 01/131 дугаартай албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Засгийн газрын ХШҮ-ний мэдээллийн цахим санд биелэлтийг оруулж баталгаажуулсан. -Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж (17 зорилт, 72 арга хэмжээ 77.7 хувьтай дүгнэгдсэн), | 100% | |
| 8 | 6 | 8 | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>**2021-12-17**<br>**Дугаар 2022.05.01** | Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг эмх цэгцтэй, ойлгомжтой байдлаар байршуулан цаг тухай бүрт нь тогтмол шинэчилж, баяжуулалтыг хөтлөн явуулж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | | | |
| 9 | 6 | 9 | 8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны https://mmhi.gov.mn/ цахим хаяг болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам гэсэн нийгмийн сүлжээний хаягаар үйл ажиллагаагаа иргэд, олон нийтэд сурталчлан таниулж байна. | 100% | |
| 10 | 6 | 10 | 8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | Байгууллагын үйл ажиллагааны нэгдсэн тайланг байгууллагын цахим хуудсанд 2015-2021 он дуустал ил тод байдал хэсэгт байршуулсан. Мөн жил бүрийн дотоод аудитын төлөвлөгөө, тайланг байршуулсан. | 100% | |
| 11 | 6 | 11 | 8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан; | Одоогоор ямар нэг хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлсэн үнэлгээний ажил холбогдох байгууллагуудаас хийгдээгүй. | /-/ | |
| 12 | 6 | 12 | 8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд салбарын үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн төслүүд Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх хуулийн төслүүдийн хэрэгжилтийн явцыг нэгтгэн боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яаманд сар бүр тайлагнасан. | 100% | |
| 13 | 6 | 13 | 8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн санд бүртгэлтэй, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нийт 34 захиргааны хэм хэмжээний акт байна. | 100% | |
| 14 | 6 | 14 | 8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | Яамны цахим хуудсанд ажилтан, албан хаагчдын хариуцсан ажил, холбогдох утасны дугаар мэйл хаяг бүхий танилцуулгыг оруулсан болно. | 100% | |
| 15 | 6 | 15 | 8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | Монгол Улсын Засгийн газрын 2005 оны "Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" 67 дугаар тогтоолын дагуу УУХҮЯ, АМГТГ, ҮГА-нд 2022 онд иргэдээс төрийн байгууллага , албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг тухай бүр шийдвэрлэж , улирал бүр тайлан мэдээг ЗГХЭГ-т хүргүүлж ажиллаа./Нийт ирсэн өргөдөл гомдол -716,шийдвэрлэсэн-694,хяналтанд байгаа-22/ | 100% | |
| 16 | 6 | 16 | 8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | Уул уурхай, хүнд үйлдвэр яам нь аж үйлдвэрийн салбар (уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн)-ын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, экспорт, импорт, улсын төсвийн орлого болон биет хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (нийгэм, эдийн засагт үзүүлэх | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | нөлөөлөл) зэрэг мэдээллийг өмнөх жилийн мөн үетэй харьцуулан боловсруулж сар бүр www.mmhi.gov.mn цахим хуудас болон www.opendata.gov.mn цахим хуудсаар, мөн Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)-аас Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн статистик мэдээ, Геологийн статистик мэдээ, Уул уурхайн статистик мэдээ, Газрын тосны статистик мэдээ, Хүнд үйлдвэрийн статистик мэдээ, АМГТГ-аас улсын төсвийн төвлөрүүлэх орлого болон төвлөрүүлсэн орлогын мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар боловсруулж сар бүр www.mrpam.gov.mn цахим хуудас болон www.opendata.gov.mn цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод, хүртээмжтэйгээр хүргэж байна. | | |
| 17 | 6 | 17 | 8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг өөрийн вэб сайт, фэйсбүүк хуудсаар олон нийтэд хүргэдэг ба өнгөрөгч 2022 онд дээрх хоёр сувгаар нийт 330 гаруй мэдээлэл нийтэд ил тод, мэдээлэгдсэн байна. Үүнд: уулзалт, арга хэмжээ, хурлын 270 гаруй мэдээлэл, 7 хоног тутмын салбарын статистик мэдээлэл, сар тутмын статистик мэдээллийг хураангуйлж, яамны газар, хэлтсүүдээс иргүүлсэн хурал, уулзалт, хэлэлцүүлгийн зар мэдээ, журам, хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлалд санал авах мэдээлэл, бусад зарлалын мэдээлэл багтаж байна Олон нийтийн арга хэмжээний мэдээллүүд сайтын мэдээ мэдээлэл цэс болон сошиал хуудсаар тухай бүрд орж шинэчлэгддэг. https://mmhi.gov.mn/засгийн-газрын-үйл-ажиллагааны-хөтөл/ Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр. https://mmhi.gov.mn/ сайтны Мэдээ, мэдээлэл цэсний https://mmhi.gov.mn/мэдээ-мэдээллүүд/ https://mmhi.gov.mn/ярилцлага/ https://mmhi.gov.mn/хэлэлцүүлэг/ https://mmhi.gov.mn/сургалт-2/ https://mmhi.gov.mn/imarc/ https://mmhi.gov.mn/wp-content/uploads/2022/10/IMARC1-2.pdf https://mmhi.gov.mn/2022/12/26/ашигт-малтмалын-баялаг-ордын-нөөцийн-2/ | 100% | |
| 18 | 6 | 18 | 8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | Сул орон тооны талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулж байна. УУХҮЯ-нд 2 ажлын байр, харьяа агентлаг болох АМГТГ-т 5, ҮГА-нд 2 ажлын байранд тус тус сул орон тоо гарч холбогдох хууль, журмын дагуу Төрийн албаны зөвлөлтэй хамтран сонгон шалгаруулалтыг зарлан тусгай шалгалт зохион байгуулж сул ажлын байрыг нөхсөн. 2022 оны жилийн эцсийн байдлаар тус яаманд нийт 3 ажлын байр сул байна. Үүнд: Сайдын зөвлөх, Төрийн нарийн бичгийн даргын туслах, Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн шинжээч | 100% | |
| 19 | 6 | 19 | 8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журмыг байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулж байна. 2022 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлөөс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | тосны газар, Үндэсний геологийн албаны нийт 9 ажлын байр зарласнаас 7 албан хаагчийг сонгон шалгаруулж томилох эрх бүхий этгээдэд тогтоолыг хүргүүлсэн. Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад журмын дагуу сул ажлын байрны захиалга бүрийг зохион байгуулж ажиллаж байна. | | |
| 20 | 6 | 20 | 8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд Төрийн захиргааны 70, төрийн үйлчилгээний 7 ажилтан, албан хаагчид ажиллаж байна. Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн байгууллагын үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээлэлд Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг мөрдлөг болгон ажиллаж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ёс зүйн зөвлөлд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээлэл ирээгүй бөгөөд Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн зөрчилтэй холбоотой ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх асуудал 2022 онд хэлэлцэгдээгүй болно. Төрийн албаны зөвлөлөөс НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь" төслийн хүрээнд "Төрийн албаны үнэт зүйл ба стратегийн баримжаатай хүний нөөцийн удирдлага" сэдэвт сургалтыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан хаагчдад зориулан 2022 оны 08 дугаар сарын 19-ны өдөр зохион байгуулсан ба уг сургалт нь Төрийн албан хаагчдын зарчимч, шударга байдлыг нэмэгдүүлэх, хувь хүний ёс зүйн манлайллыг дэмжих, төрийн албаны үнэт зүйлсэд суурилсан ёс зүйн чиг баримжааг бүтээхэд дэмжлэг үзүүлэх болон төрийн албан хаагчийн цогц чадамжийг илрүүлэх, үнэлэх, хөгжүүлэх арга зүйн талаар мэдлэг, мэдээлэл өгөх зорилго бүхий үр дүнтэй сургалт болсон.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | |
| 21 | 6 | 21 | 8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; | Төрийн албан хаагчийн хүний нөөцийн стратеги, бодлогыг Төрийн албаны зөвлөлөөс нэгдсэн байдлаар боловсруулж байгаа бөгөөд түүний төсөлд холбогдох саналаа хүргүүлсэн. | 70% | |
| 22 | 6 | 22 | 8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | Яамны ажилтан, албан хаагчдын мэдээлэл, сул орон тооны мэдээллийг тухай бүр нь яамны вэб сайтад байршуулдаг бөгөөд холбогдох хууль , журмын дагуу тухай бүр сонгон шалгаруулалтыг зарлан сул орон тоог нөхөн ажиллаж байна. Яамны хүний нөөцийн мэдээллийг www.mmhi.gov.mn вэб хуудсанд газар хэлтэс хариуцсан ажлын чиг үүргийг оруулсан. | 100% | |
| 23 | 6 | 23 | 8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу ТНБДаргын 2022.11.17-ны өдрийн А/105 дугаар тушаалаар УУХҮЯ-ны албан хаагчийн гүйцэтгэлийн тайланг үнэлэх эрх бүхий "Байгууллагын үнэлгээний баг"-ийг байгуулсан. Үнэлгээний баг 2022.12.16-ны өдөр хуралдан УУХҮЯ-ны нийт албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг үнэлж хурлаас гарсан нэгдсэн саналыг ТНБДаргад хүргүүлсэн. Үүний дагуу Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.10, 9.8, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам", Сангийн сайдын 2012 оны 238 дугаар тушаалаар баталсан "Төсвийн урамшуулал олгох хувь, хэмжээ, шалгуур үзүүлэлт, түүнийг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам", Хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар хэсгийн 8.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТНБДаргын 2022.12.20-ны өдрийн А/110 тушаалаар мөнгөн урамшуулал олгох тухай тушаал батлуулан хэрэгжүүлсэн. | | |
| 24 | 6 | 24 | 8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын болон Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, 2022 оны 1-12 дугаар сарын төсвийн гүйцэтгэл, 2023 оны төсвийн төслийг хуулийн хугацаанд шилэн дансанд байршуулан ил тод байдлыг хангаж ажилласан | 100% | |
| 25 | 6 | 25 | 8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; | УУХҮСайдын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд гаргаж холбогдох байгууллагад хүргүүлж, шилэн дансанд байршуулсан. | 100% | |
| 26 | 6 | 26 | 8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | УУХҮСайдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд ҮАГ-аар аудит хийлгэж ЗГ-ын нэгтгэсэн тайланд нэгтгүүлсэн. Тайланг шилэн дансанд байршуулж ил тод байдлыг хангаж ажилласан. | 100% | |
| 27 | 6 | 27 | 8.4.4. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; | Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээний мэдээллийг шилэн дансанд сар бүр байршуулан ажилласан | 100% | |
| 28 | 6 | 28 | 8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; | УУХҮСайдын багцын төсвийн гүйцэтгэлийн мэдээг тайлбар тодруулгын хамт сар, улирал, жилээр гарган шилэн дансанд байршуулан ажилласан. | 100% | |
| 29 | 6 | 29 | 8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; | Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг ил тодоор сар бүр шилэн дансанд байршуулан ажилласан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 30 | 6 | 30 | 8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт; | цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт тухай бүр нь холбогдох баримтын хамт шилэн дансанд байршуулан ажилласан. | 100% | |
| 31 | 6 | 31 | 8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; | бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан тухай бүр нь шилэн дансанд байршуулан ажилласан | 100% | |
| 32 | 6 | 32 | 8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын байгууллагуудад шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг 2022 оны 9 сарын байдлаар гаргуулан авч ҮАГ-т хүргүүлэн ажилласан. | 100% | |
| 33 | 6 | 33 | 8.4.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; | 1. УУХҮ-ийн сайдын багцын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор, тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор шилэн дансанд байршуулсан. 2. Худалдан авах ажиллагаатай холбоотойгоор зохион байгуулагдсан тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан зэрэг мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд сар бүр буюу 12 удаа шинэчлэн оруулсан. 3. Тайлант онд УУХҮ-ийн сайдын багцын 3 байгууллагын хэмжээнд нийт 31.8 тэрбум төгрөгийн 40 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөн ажилласнаас 31.5 тэрбум төгрөгийн 40 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. | 100% | |
| 34 | 6 | 34 | 8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт; | Тайлант хугацаанд худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт 2 гарсан бөгөөд тухай бүр шилэн дансны цахим хуудсанд нээлттэй байршуулсан.<br>Үндэс: 1. Сангийн яамнаас УУХҮ-ийн сайдын багцын 2021 оны худалдан авах ажиллагаанд хийсэн хяналт, үнэлгээний тайлан; 2. ХШҮДАГ-аас УУХҮ-ийн сайдын 2021 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хийгдсэн дотоод аудитын тайлан. | 100% | |
| 35 | 6 | 35 | 8.4.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн | УУХҮ-ийн сайдын багцын хүрээнд, захиалагч байгууллага болох УУХҮЯ, АМГТГ, ҮГА-ны худалдан авах ажиллагааг зохион байгуулахад тухай бүр шаардлагатай зөвлөгөө, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл; | | | |
| 36 | 6 | 36 | 8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн; | Төсвийн хөрөнгөөр 2022 онд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн нэгжийн үйл ажиллагааны зардалд 443.9 сая төгрөг батлагдсан. 2022 оны 04 дүгээр сард 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 141.8 сая төгрөгөөр бууруулж 302.1 сая төгрөг болгон баталсан ба 2022 оны гүйцэтгэлд 284.1 сая төгрөг зарцуулсан. -Төсвийн хөрөнгөөр 2022 онд Олборлох үйлдвэрлэлийнил тод байдлыг бэхжүүлэх төслийн нэгжийн үйл ажиллагааны зардалд төслийн нэгжийн үйл ажиллагааны зардалд 181.6 сая төгрөг батлагдсан. 2022 оны 04 дүгээр сард 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 37.5 сая төгрөгөөр бууруулж 144.1 сая төгрөг болгон баталсан ба 2022 оны гүйцэтгэлд 135.8 сая төгрөг зарцуулсан.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | |
| 37 | 6 | 37 | 8.4.27. мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан; | УУХҮ-ийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/238 дугаар тушаалаар ЭШСА-ын жагсаалтыг шинэчлэн батлуулсан. Нийт 193,3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 багц тендер шалгаруулалтыг зарлан, тендерт шалгарсан оролцогчидтой нийт 184,3 сая төгрөгийн гэрээ байгуулан судалгааны ажлыг гүйцэтгүүлсэн. Судалгааны ажлын тайлан, үр дүнг актаар хүлээн авч, санхүүжилтийг 2022 оны 12 дугаар сард багтаан олгосон. | 100% | |
| 38 | 6 | 38 | 8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:) | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын болон харьяа төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн 2021 оны худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланг нэгтгэн боловсруулж, Сангийн яаманд 2022.01.14-ний өдрийн 03/99 дугаартай албан бичгээр хүргүүлэн тайлагнасан. - Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний аж ахуйн нэгж, байгууллагуудын 2021 онд дотоодын үйлдвэрүүдээс худалдан авсан бараа, бүтээг-дэхүүний тайланг нэгтгэн боловсруулж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 2022.02.09-ний 01/288 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын хэмжээнд 2021 онд нийт 74,5 тэрбум төгрөгийг дотоодын үйлдвэрүүдэд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн худалдан авахад зарцуулсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой бүх төрлийн мэдээллийг шилэн данс, байгууллагын цахим хуудас болон төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д тухай бүр байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна | 100% | |
| 39 | 6 | 39 | 8.5.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.10.2, 15.10.15, УУХҮСайдын 2018 оны А/105 дугаар "Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд хавсаргах баримтын жагсаалт | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл; | батлах тухай" тушаал, Засгийн газрын 199 дугаар "Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай" тогтоолын 14.1.3. "төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл олгоход 200 000 төгрөг", 14.1.5. "үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл олгоход 800 000 төгрөг"-д тус тус заасны дагуу Төрийн сан банкны 100200700941 /ЧД.Улсын тэмдэгтийн хураамж/ тоот дансанд тушаасан баримтыг, материалын хамт ирүүлж, шаардлага хангасан аж ахуй нэгжид тухайн үйл ажиллагаатай нь холбоотойгоор Үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх эсвэл Төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг олгодог. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/08 дугаар тушаалаар баталсан "Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам"-ын дагуу бүх төрлийн шатахуун болон шингэрүүлсэн шатдаг хийг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус яамнаас олгодог. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой хүсэлтийг 2022 оны 3 дугаар сараас эхлэн www.license.mn цахим системээр хүлээн авч шуурхай шийдвэрлэж байна. Тус яамны цахим хуудас болон тусгай зөвшөөрөл шийдвэрлэлтийн www.license.mn хуудсуудад тусгай зөвшөөрлийн төрөл, шийдвэрлэх журам, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, тусгай зөвшөөрөлтэй ААН, байгууллагын мэдээллийг тухай бүр шинэчлэн нийтэлж, олон нийтэд мэдээлэл хүргэж байна Тэсэрч, дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд заасны дагуу Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрлийг 76 аж ахуйн нэгж 86 тусгай зөвшөөрлийг эзэмшиж байна. Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн төлбөр 3.250.000 төгрөг байна. | | |
| 40 | 6 | 40 | 8.5.2. тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа. | Хүнд үйлдвэрт хамаарах Төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх ба Үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлт 2022.01.31-ний өдрөөс 2022.11.17-ны өдрийн хооронд нийт 24 ААНБ-аас албан бичгээр болон цахим системээр ирснээс 20 ААНБ-д тусгай зөвшөөрлийн олголт, сунгалтыг 3 жилийн хугацаатай хийж, 3 ААНБ-ын хүсэлтийг буцааж, 1 ААНБ-аас ирүүлсэн хүсэлтийг цуцалсан. 2022 оны 12 дугаар сарын 30-ны байдлаар Газрын тосны бүтээгдэхүүний импортын зөвшөөрөлтэй 97 аж ахуйн нэгж, бөөний худалдаа эрхлэх зөвшөөрөл бүхий 101 аж ахуйн нэгж, жижиглэн борлуулалтын зөвшөөрөлтэй 118 аж ахуйн нэгж, үйлдвэрлэл эрхлэх 7 аж ахуйн нэгж байна. | 100% | |
| 41 | 6 | 41 | 8.6.1. олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, | Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийн хэлэлцүүлгийг салбарын мэргэжлийн холбоод болон аж ахуйн нэгжүүдийн дунд 2022 оны 5 дугаар сард тус бүр 14 хоногийн хугацаатай зохион байгуулсан. Тэсэлгээчний эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмын төсөлд | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал; | 2022 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн төсөлд 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдөр, Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын шинэчилсэн найруулгын төсөлд 2022 оны 2 дугаар сарын 01-ний өдөр санал авахаар тус яамны цахим хуудсанд тус тус байршуулсан. "Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам"-ыг боловсруулж бусад яамд болон холбогдох бусад байгууллагаас 2022.12.01-ний өдөр 01/3180 дугаар албан бичгээр санал авч нэгтэн, журмын төсөлд тусган Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 466 дугаар тогтоолоор журам батлагдсан. | | |
| 42 | 6 | 42 | 8.6.2. эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт; | Эзэмшиж байгаа оюуны өмч байхгүй болно. | /-/ | |
| 43 | 6 | 43 | 8.6.3. хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл; | 2024 онд Төрийн захиргааны байгууллагуудыг Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг Хөшигтийн хөндий рүү нүүлгэн шилжүүлэх тухай тогтоолын төсөлд холбогдох саналыг боловсруулан хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төвөөс хамтран боловсруулсан "Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийн хэлэлцүүлэгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2023 оны 01 дүгээр сарын 13-ний өдөр зохион байгуулсан бөгөөд энэхүү хөгжлийн төсөлд салбар яамны зүгээс холбогдох саналыг нэмж тусгуулахаар ажиллаж байна. | 100% | |
| 44 | 6 | 44 | 8.6.4. мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл; | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд өөрийн эзэмшлийн ямар нэгэн барилга байгууламж болон газар байхгүй болно. | /-/ | |
| 45 | 6 | 45 | 8.6.5. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг; | Байгууллагын нэр, хаяг, үйл ажиллагааны чиглэлийн мэдээллийг www.mmhi.gov.mn цахим хуудсанд оруулсан. | 100% | |
| 46 | 6 | 46 | 8.6.6. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад | Байгууллагын удирдлагын мэдээллийг www.mmhi.gov.mn цахим хуудсанд оруулсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл; | | | |
| 47 | 6 | 47 | 8.6.8. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл; | ТӨБЗГазрын 2022.05.20-ны өдрийн А 1/999 дугаар албан бичгийн дагуу яамны балансад бүртгэлтэй нийт 4 ширхэг тээврийн хэрэгслээс "Тоёота лексус-570" маркийн 0131 УНҮ, 2300 УБЯ улсын дугаартай 2 ширхэг Жип ангиллын машин, "Соната хьюндэй-VII" маркийн 0384 УБҮ дугаартай суудлын автомашинуудыг актаар хүлээлгэн өгч мэдээллийг шилэн дансанд байршуулсан болно. | 100% | |
| 48 | 6 | 48 | 8.6.10. мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл; | Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж нь төслийн Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг Байгаль орчны үнэлгээний тухай хуульд заасны дагуу төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ, нарийвчилсан үнэлгээ зэрэг баримт бичигт тусгаж, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж батлуулж, хэрэгжилтийг хангаж байна. Технологи дамжуулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэгт "технологийн түвшний үнэлгээ хийх журам, үнэлгээний хэмжээг тогтоох аргачлалыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно" гэж заасны дагуу "Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх журам, үнэлгээний хэмжээг тогтоох аргачлал"-ыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын "Журам, аргачлал батлах тухай" 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/135 / А/200 дугаар хамтарсан тушаалаар баталж, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4 дэх хэсэгт заасны дагуу улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр ажиллаж байна. Тус журам аргачлал батлагдсанаар хүнд болон хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн технологийн түвшнийг үнэлэх боломж бүрдэх юм. Байгальд орчинд ээлтэй, хүний эрүүл мэнд болон биологийн олон янз байдалд сөрөг нөлөөгүй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлэх Байгаль орчинд ээлтэй, нийгмийн үр ашигтай тээвэрлэлтийн нөхцөл бүрдүүлэх зорилгоор Бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон-Уул 19 дүгээр талбайн үйлдвэрлэлийн баазаас Баянхошуу-Өвдөгийн хилийн боомт чиглэлийн 210,7 км хатуу хучилттай авто замыг 4 багцад хуваан барилгын ажлыг гүйцэтгэсэн ба эхний 2 багцын нийт 104 км автозамын барилгын ажлыг БНХАУ-ын Дачин Ойлфийлд зам гүүрийн компани гүйцэтгэж, 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгсөн. 3, 4 дүгээр багцын барилгын ажил гүйцэтгэгчээр Монгол улсын "Арж капитал" ХХК шалгарч, гэрээ байгуулан ажилласан. Тус хатуу хучилттай авто замыг 2016 онд бүрэн ашиглалтад оруулсан ба тус замаар гарын тосны экпортын тээвэрлэлт гүйцэтгэж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 49 | 6 | 49 | 8.6.11. барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт; | Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт байхгүй болно. | /-/ | |
| 50 | 6 | 50 | 8.6.20. нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл; | УУХҮЯ-наас олгож буй тусгай зөвшөөрлийн мэдээлэл, ЭБМЗ-ийн үйл ажиллагааны мэдээлэл, АМГТГ-аас олгож буй ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн мэдээлэл, хайгуулын болон уулын ажлын тайлан, төлөвлөгөөний мэдээлэл, газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээлэл зэргийг ашиглаж буй системүүдээс гарган авч нийтэд нээлттэйгээр мэдээлж байна. (https://mpc.mmhi.gov.mn/, https://license.mn/, https://cmcs.mrpam.gov.mn/cmcs | 100% | |
| 51 | 6 | 51 | 8.6.21. мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт; | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2022 оны Сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Тайлант оны хагас жилийн байдлаар нийт Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 4, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 5, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч, бусад цаг үеийн шинжтэй мэргэшүүлэх сургалтуудад /Мерит тэслийн шугамаар болон ЖҮХ, ХЭҮК, ТАЗ, АТГ/ давхардсан тоогоор нийт 12 албан хаагчийг хамруулсан бөгөөд холбогдох мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Мэдээлэл хариуцагчийн зардлаар 2022 онд гадаад дотоодын их дээд сургуульд суралцагч яваагүй болно. | 100% | |
| 52 | 6 | 52 | 8.6.22. хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. (8.6.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:) | Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд цаг тухай бүр яамны цахим хуудсанд байршуулан ажиллаж байна. https://mmhi.gov.mn/ Сайтны хууль тогтоомж цэс, ил тод байдал цэсэнд байршуулж тогтмол шинэчилдэг. https://ngs.gov.mn/legal/ https://ngs.gov.mn/il-tod-baidal/ https://mrpam.gov.mn/article/45/ | 100% | |
| 53 | 7 | 53 | **Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2021-12-24 Дугаар 2021-12-24** 11.3. Улсын Их Хурлаас энэ хуулийн 11.2-т заасны дагуу Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд Улсын Их Хуралд ирүүлэх ба түүнд Тамгын газар дүн шинжилгээ хийж, танилцуулгыг холбогдох Байнгын хороодод хүргүүлнэ. (11.2.Улсын Их Хурал шаардлагатай | Улсын Их хурлын тогтоолын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим системд 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр байршуулсан. Нийт 6 зүйл, заалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг 73.33 хувийн биелэлттэй гэж дүгнэв. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргана.) | | | |
| 54 | 7 | 54 | 15.3. Улсын Их Хурал хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахаар Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоол баталсан бол Засгийн газар уг тогтоолын хэрэгжилтийг тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй. | 1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд 2022.01.05-ны өдөр УИХ-ын даргад Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн бөгөөд 2022.01.17-ны өдөр УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж дэмжигдсэн. Улмаар 2022.01.18-ны өдөр УИХ-ын намрын ээлжит чуулганы сүүлийн өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэж дэмжигдсэн. УИХ-ын ЭЗБХ-ноос ажлын хэсэг гарахаар болсон бөгөөд Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд заасны дагуу холбогдох Ажлын хэсэг УИХ-ын даргын захирамжаар байгуулагдаж мөн дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийн дэд ажлын хэсгийн хурал нь 2022-10-20-ны өдөр хуралдаж, Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 23-ын өдөр Эдийн засгийн байнгын хороонд өргөн мэдүүлж, батлуулав.<br>2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар Монгол Улсын гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай Засгийн Газрын 2022 оны 362 дугаар тогтоолл тусгагдсан уул уурхайн биржийн тогтолцооны нэгдсэн цахим системийг нэвтрүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг уул уурхайн биржийн үйл ажиллагаа явуулах боломжтой аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлтэй уулзалт хийж нэвтрүүлэх цахим системүүдтэй танилцсан. Аж ахуйн нэгжүүдтэй хийсэн уулзалт, цахим системийн боломжийн талаар Төрийн нарийн бичгийн даргад танилцуулж улмаар ЗГ-ын хуралдаанд мэдээлэл хийсэн. Ажлын хэсэг уул уурхайн бүтээгдэхүүнийг цахимаар нээлттэй арилжих түр журмын төслийг боловсруулсан. "Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам"-ыг боловсруулж бусад яамд болон холбогдох бусад байгууллагаас санал авахаар 2022.12.01-ний өдөр 01/3180 дугаар албан бичгийг хүргүүлээд байна. Тус албан бичигтэй холбогдуулан яам болон холбогдох бусад байгууллагаас ирсэн албан бичгүүдийг нэгтэн, журмын төсөлд тусган Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 466 дугаар тогтоолоор журам батлагдсан.<br>3. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний баялгийн | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж, хуулийн төсөлд яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамнаас 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг ЗГХЭГ-аар дамжуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бүрдлийг ханган хүргүүлсэн. Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу 2022.11.01-ний өдөр хуулийн төсөл, дагалдах хууль болон холбогдох бусад бичиг баримтуудыг буцаахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт албан бичиг төлөвлөн хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" 192 дугаар захирамжаар Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Улмаар тус Ажлын хэсгийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн сайд ажиллах болсон тул холбогдох материалуудыг 2022 оын 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/3297 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайдад шилжүүлсэн. | | |
| 55 | 8 | 55 | **Хөрөнгийн үнэлгээний тухай /Шинэчилсэн найруулга/ 2022-06-17 Дугаар 2023.01.01**<br>7.2.12. ашигт малтмал болон газрын тосны орд, байгалийн хийн хөрөнгийн үнэлгээний журам, аргачлалыг уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран; (7.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дангаар, эсхүл доор дурдсан төрийн байгууллагатай хамтран тухайн хөрөнгийн үнэлгээний зүйлийн шинж байдал, зориулалтад | Хуулийн хэрэгжилт 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр батлагдсан тул хэрэгжилт гаргах боломжгүй байна. | /-/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | нийцсэн хөрөнгийн үнэлгээний журам, аргачлалыг батална:) | | | |
| | | | 1.б. Улсын Их Хурлын тогтоол | | | |
| 56 | 1 | 1 | **Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2018-06-29 Дугаар 2018 №73** 1.1/. Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын "б", "в"-д заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх хүрээнд холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх; | Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор тус яамнаас "Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" саналыг боловсруулж, Засгийн газрын 2018 оны 296 дугаар тогтоолоор батлуулсан. Улмаар "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн охин компани "Эрдэнэс Тавантолгой Майнинг" ХХК-ийг компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 28 дугаар тогтоолын дагуу байгуулж, үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд нийцүүлэн олон улсын болон дотоодын зах зээлд үе шаттайгаар үнэт цаас гаргах ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай зөвлөх үйлчилгээг үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, үйлчилгээ авах гэрээг байгуулан ажиллаж байсан. Гэвч УИХ 2018 оны 73 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр Засгийн газраас баталсан 2019 оны 296 дугаар тогтоолыг 2020 оны 146 дугаар тогтоолоор хүчингүй болгосон тул гадаадын хөрөнгийн биржид үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа зогсонги байдалд орсон. | /-/ | |
| 57 | 1 | 2 | 1.2/. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Оюутолгой-Ханги, Тавантолгой-Барууннаран чиглэлийн авто замын төгсгөлөөс Цагаандэл уул чиглэлийн тусгай зориулалтын авто зам болон Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам зэрэг төслийг эхлүүлэх талаар шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км, Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой- Манлай-Ханги чиглэлийн 435 км, Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км авто замын төслүүдийг концессын гэрээгээр хэрэгжүүлэхээр тусгасан. Үндэсний хөгжлийн газраас өгсөн мэдээллээр Засгийн газрын дээрх шийдвэрийг хэрэгжүүлэх концесс эзэмшигч нарыг сонгон шалгаруулж холбогдох гэрээг байгуулсан байна.Үүнд:<br>1. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын авто замын концессын гэрээг Засгийн газрын 2018 оны "Концессын гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай" 229 дүгээр тогтоолын дагуу "Тал нутгийн хөгжлийн зам" ХХК, ("Чайна тиэсижү сивил инженеринг групп" ХК болон "Дардан говь" ХХК-ийн түншлэлийн байгуулсан компани);<br>2. Тавантолгой- Манлай-Ханги чиглэлийн 435 км авто замын концессын гэрээг Засгийн газрын 2019 оны "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах, концессын гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай" 238 дугаар тогтоолын дагуу "Тахилт хайрхан транс" ХХК;<br>3. Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км авто замын концессын | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | гэрээг Засгийн газрын 2018 оны "Концессын гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай" 330 дугаар тогтоолын дагуу "Ундрах говь" ХХК тус тус эзэмшиж байгаа байна.<br>4. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх Тавантолгой төмөр зам" ХХК-ийг Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоолын дагуу байгуулсан бол Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх "Зүүнбаян төмөр зам" ХХК-ийг Засгийн газрын 2020 оны 117 дугаар тогтоолоор тус тус байгуулж, төмөр замын төслүүдийн барилга байгууламжийг барьж, ашиглалтад оруулсан | | |
| 58 | 1 | 3 | 1.4/. Өмнөд бүсийн уул уурхайн төслүүдийн эрчим хүчний хэрэгцээг хангах цахилгаан станц болон нүүрс химийн үйлдвэрийг Тавантолгойн ордыг түшиглэн барих талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Засгийн газрын 2020 оны 124 дүгээр тогтоолоор Тавантолгойн дулааны цахилгаан станц барих төслийг төрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зорилгоор "Тавантолгой дулааны цахилгаан станц" ТӨХХК-ийг байгуулсан. Тавантолгой ордыг түшиглэн жилд 30 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын "Чайна металлуржикал инженеринг компани" /CMEC/ боловсруулж 2021 оны 4 сарын 1-ий өдрийн ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Тус яамнаас "Нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, 2021.04.28-ны өдрийн 113 дугаар тогтоолоор батлуулсан. Улмаар "Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх" түлхүүр гардуулах нөхцөлтэй тендерт "Norinco International Cooperation" Ltd шалгарч 2022 оны 4 дүгээр сарын 14-нд EPC гэрээг байгуулсан. | 100% | |
| 59 | 1 | 4 | 1.5/. Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах усан хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах ажлын хүрээнд гадаргын болон гүний усыг байгаль, экологийн тэнцвэрийг алдагдуулахгүйгээр зохистой ашиглах боломжийг судлан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны захиалгаар Дэлхийн банкны "2030 Усны нөөцийн бүлэг" нь "Монголын Өмнөд говийн уул уурхай, хүнд үйлдвэрийн бүсийн усны эрэлт-хангамжийн гидроэкономик шинжилгээ"-г 2020 онд хийж гүйцэтгэсэн. Судалгаа, шинжилгээний үр дүнд өмнийн говийн ашиглах боломжтой газрын доорх усны нийт 20 ордыг нийгэм, эдийн засаг, байгаль орчны шалгуур үзүүлэлтээр үнэлж, хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн газрын доорх усны ордоос эхэлж ашиглах талаар зөвлөмж өгсөн ба үүнд Өмнийн говийн бүсэд гадаргын усыг шилжүүлэн ашиглах төсөл хэрэгжиж эхлэх хүртэл хугацаанд Загийн усны хоолой болон Цагаан цавын газрын доорх усны ордуудыг ашиглах боломжтойг тодорхойлсон. Тавантолгой ордын үйлдвэрлэлийн болон дэд бүтцийн төслүүдийн усны хэрэгцээг хангахын тулд 280 орчим л/с усны нөөц шаардлагатай бөгөөд энэхүү усны хэрэгцээг Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах "Загийн усны хоолой" болон Дорноговь аймгийн Мандах сумын нутагт байрлах "Цагаан цав"-ын газрын доорх усны ордыг ашиглаж хангахаар төлөвлөж байна. Загийн усны хоолойн газрын доорх усны орд нь Тавантолгойн уурхайгаас 65 км орчим зүүн хойшоо Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах бөгөөд Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар 2015-2016 онд гидрогеологийн нарийвчилсан хайгуул судалгааг хийж Загийн усны хоолойн хэсэгт | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | газрын доорх усны нөөцийг 63,65 л/с-ээр тогтоосон бөгөөд Эрдэнэс Тавантолгой ХК ус ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, холбогдох дүгнэлт, зөвшөөрлийг эрх бүхий байгууллагуудаас авсан. | | |
| 60 | 2 | 5 | **Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай<br>2018-11-15<br>Дугаар 2018 №84**<br>2.9/. Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх | Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх зорилгоор "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018.03.13-ны өдрийн хурлын шийдвэрээр "Эрдэнэс Алт Ресурс" ХХК-ийг 100 хувь төрийн өмчит компани хэлбэрээр байгуулсан. "Эрдэнэс алт ресурс" ХХК 2020-2021 онд олон улсын 20 гаруй компанитай холбоо тогтоож төсөл дээр санал авсан ба "түлхүүр гардуулах" нөхцөлөөр 4 компани (Сымбат инжерениг, Шинхай групп, "Кронимет Майнинг, Зижин Майнинг) санал ирүүлсэн. Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол, ижил төстэй үйлдвэрүүдийн харьцуулсан судалгаа, төслийн санхүүжилтийн талаар санал дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирлын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2021.10.01-ний өдрийн А/100 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг БНКазУ-ын "Сымбат инженеринг" ХХК-ийн боловсруулсан 81.9 сая ам.долларын хөрөнгө оруулалт бүхий ТЭЗҮ-ийг хянаж, ТЭЗҮ-ийн эдийн засгийн тооцооллыг зассан ч ТЭЗҮ бодит байдалтай нийцэхгүй, хөрөнгө оруулалтын зардлыг хэт өндөр байна гэж дүгнэсэн. Бүгд Найрамдах Казахстан Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайдын яамнаас 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 30-309 дугаартай захидлаар "Сымбат инженеринг" ХХК нь алт цэвэршүүлэх үйлдвэр барихад 80 сая ам.долларын санхүүжилтийг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэх боломжтойг уламжилсан саналд "Эрдэнэс алт ресурс" ХХК нь санал болгож буй хөрөнгө оруулалтыг хүлээн авч бүх талаар хамтран ажиллах саналаа илэрхийлж, "2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн ЕА 22/65 албан бичгээр хүргүүлсэн байна. | 100% | |
| 61 | 3 | 6 | **Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай<br>2019-06-06<br>Дугаар 2019 №62**<br>1.7/г/. уул уурхайн салбарт ажиллагсдыг осол гэмтэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламжийн чанар, хүртээмжийг сайжруулах, ажлын байрны аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Уул уурхайн салбарт ажиллагсдын осол гэмтэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлд 2017 оноос яамны дэргэд салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороог сайдын тушаалаар байгуулан ажиллаж байна Тус хорооноос уул уурхайн салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийг сурталчлах, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал/ХЭМАБ/-ын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, холбогдох дүрэм, журам, стандартыг сайжруулах чиглэлд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв болон Хөдөлмөрийн эрүүл ахуйчдын үндэсний холбоо зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Энэ хугацаанд салбар хорооноос дараахь гол ажлуудыг хийж хэрэгжүүлж байна -Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын 176-р конвенцид нэгдэн орж, тус конвенцийг хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох байгууллагууд /ХНХЯ, МХЕГ, МАОЭНХ, МҮЭ, салбарын аж ахуйн нэгж | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгууллагууд/-тай хамтран ажиллаж байна. Конвенцоор хүлээсэн үүргийн дагуу хэрэгжилтийн тайланг 2017, 2020 тус тус боловсруулж, Олон Улсын хөдөлмөрийн байгууллагад хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. -Жил бүрийн 4 дүгээр сард Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян, 9-10 сард "Нэн түрүүнд ХАБ бага хурал"-ыг Уул уурхайн салбарын хэмжээнд зохион байгуулж байна. -Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас олон улсын чиг хандлага, техник, технологийн хөгжилтэй уялдсан аюулгүй ажиллагааны дүрмүүдийн шинэчлэн боловсруулж, батлуулан аж ахуйн нэгж байгууллагуудад мөрдүүлэх, хяналт шалгалт хийх бололцоог бүрдүүлж, уурхайчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор дараах аюулгүй ажиллагааны дүрмүүдийг шинэчлэн боловсруулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Үүнд,<br>• "Ил уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрэм" (2019 он)<br>• "Тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм" (2020 он)<br>"Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм" (2020 он) | | |
| 62 | 4 | 7 | **Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай 2019-11-21 Дугаар 2019 №92**<br>.1/. 1.Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай: 1/Монгол Улсын Засгийн газар болон Айвенхоу майнз Монголиа Инк ХХК, Айвенхоу майнз Лтд, Рио Тинто Интернэшнл Холдингс Лтд компани хооронд 2009 оны 10 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ, Эрдэнэс Монгол ХХК болон Айвенхоу Оюу Толгой (Ви Ви Ай) Лтд, Оюу Толгой Нидерланд Би Ви, Оюу Толгой ХХК хооронд 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан Хувь нийлүүлэгчдийн гэрээ (нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон)-ний хэрэгжилтийг Улсын Их Хурлын 2008 оны "Үндсэн зарчим, удирдамж батлах тухай" 40 дүгээр тогтоол, 2009 | 1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2019.12.18-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 174 дүгээр захирамжаар ""Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" Улсын Их Хурлын 2019.11.21-ний өдөр батлагдсан 92 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, Оюу толгой төслийн гадны хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг"-ийг байгуулсан. Уг ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.02.09-ний өдрийн 45 дугаар захирамжаар шинэчилсэн.<br>2. Монгол Улсын Засгийн газрын 2020.02.19-ний өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" 74 дүгээр тогтоолын 1 дэх заалтаар "Оюу Толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах "Ажлын ерөнхий төлөвлөгөө" батлагдсан.<br>Улмаар дээрх Ажлын хэсгийн дарга, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020.03.31-ний өдрийн "Ажлын дэд хэсэг байгуулах тухай" 23 дугаар тушаалаар "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" Монгол Улсын Их Хурлын 2019.11.21-ний өдөр батлагдсан 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2019.12.18-ны өдрийн 174 дүгээр захирамжийн дагуу байгуулагдсан Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, зохицуулах үүрэг бүхий Ажлын дэд хэсэг"-ийг Санхүүгийн асуудал хариуцсан, Хуулийн асуудал хариуцсан, Техникийн хамтарсан хэсэгтэйгээр байгуулж, тэдгээрийн ажиллах чиглэлийг заажээ. Уг ажлын дэд хэсгийг ХЗДХ-ийн Сайдын 2021.02.24-ний өдрийн А/29 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | оны "Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай" 57 дугаар тогтоол болон Монгол Улсын хууль тогтоомжтой уялдуулан сайжруулах чиглэлээр цогц арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хараат бус зөвлөх үйлчилгээ авах | 3. Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.02.09-ний өдрийн 45 дугаар захирамжаар шинэчлэн байгуулагдсан Ажлын хэсгийн хуралдаан 2021.02.18-ны өдөр цахимаар, 2021.02.20-ны өдөр ХЗДХЯ-ны хурлын танхимд, 2021.02.23-ны өдөр Төрийн ордны "Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит танхим"-д, 2021.03.05-06-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Ханбогд сум Оюутолгой ХХК-ийн уурхайд тус болсон.<br>4. "Эрдэнэс Оюутолгой" ХХК-ийн зүгээс 2009.10.06-ны өдөр байгуулсан "Хөрөнгө оруулалтын гэрээ", 2011.06.08-ны өдөр байгуулсан "Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээ", 2015.05.18-ны өдөр байгуулсан "Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө"-г тодорхой болгох, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс шинээр болон дахин найруулах, өөрчлөлт оруулах, нэмэх, хасах санал болон санхүүгийн зарим тооцооллын талаарх мэдээллийг Монголын талын ажлын хэсэг дотроо тусгайлан хэлэлцүүлэхээр 2021.11.04-ний өдрийн 01/247 дугаартай албан бичгээр Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Ажлын хэсгийн ахлагч Х.Нямбаатарт албан хүргүүлсэн.<br>5. ДУББСТ, ДУББСНТ-г [хүчингүй болгох тухай] [цуцлах] гэрээний төсөл, эдгээртэй холбоотой үүсэж болзошгүй асуудлуудын талаарх "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-н саналыг Монгол Улсын Засгийн газрын 2021.11.10-ны өдрийн хуралдааны 59 дүгээр тэмдэглэлд нийцүүлэн боловсруулж, 2021.11.22-ны өдрийн Н-15 дугаартай албан бичгээр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогтод, 2021.11.23-ны өдрийн Н-16 дугаартай албан бичгээр Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Насантогтох нарт тус тус хүргүүлсэн.<br>6.ДУББСТ, ДУББСНТ-г [хүчингүй болгох тухай] [цуцлах] гэрээний төсөл, эдгээртэй холбоотой үүсэж болзошгүй асуудлуудын талаарх "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-н саналыг 2021.10.18-нд УИХ дахь МАН бүлэгт, 2021.11.08-нд УИХ дахь АН бүлэгт тус тус танилцуулсан.<br>7. УИХ-ын 2019 оны 92 дугаар тогтоолын 1.1-д "... шаардлагатай тохиолдолд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хараат бус зөвлөх үйлчилгээ авах ..." гэсний дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 45 дугаар захирамжаар байгуулагдсан "Ажлын хэсэг"-ээс сонгогдсон 3 хуулийн этгээд, 2 зөвлөх тогтоолын хэрэгжилтийг хангуулахад гэрээний үндсэн дээр /нууцлалын/ мэргэшлийн зөвлөгөө, туслалцааг үзүүлэн ажилласан.<br>Улмаар Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн нэгдсэн хуралдаанд "Оюутолгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" УИХ-ын 2019 оны 92 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах ажлын багийн хэрэгжүүлж буй ажлын явцын талаарх мэдээллийг танилцуулсан болно. | | |
| 63 | 4 | 8 | 1.2/. Монгол Улсын Засгийн газар, Эрдэнэс Оюу Толгой ХХК болон Туркойс Хилл Ресурсес Лтд, Ти Эйч | 1. "Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө"-нд гарын үсэг зурах эрх олгосон Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 27, 94, 99, 123 дугаартай захирамжуудыг Нийслэл дэх | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Ар Оюу Толгой Лтд, Оюу Толгой Нидерланд Би Ви, Рио Тинто Интернэшнл Холдингс Лтд, Оюу Толгой ХХК хооронд 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө” болон “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө”-г Монгол Улсын эрх ашиг, хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулах; | Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.11.18-ны өдрийн 128/ШШ2019/0808 дугаар шийдвэрээр илт хууль бус болохыг тус шүүхийн шийдвэрээр тогтоож хүчин төгөлдөр болсон. Уг шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах тухай нэр бүхий иргэдийн хүсэлтийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2021.08.27-ны өдрийн 128/ШТ2021/0090 дугаартай тогтоолоор хангахаас татгалзаж, уг тогтоолыг давж заалдах гомдол гаргах эрхгүй байх заалтыг тусгаж шийдвэрлэсэн.<br>2. 2015.05.18-ны өдөр байгуулагдсан “Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-ний 35 заалтыг тодорхой болгох, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс шинээр болон дахин найруулах, өөрчлөлт оруулах, нэгтгэх, хасах санал болон санхүүгийн зарим тооцооллын талаарх мэдээллийг Монголын талын ажлын хэсэг дотроо тусгайлан хэлэлцүүлэхээр 2021.11.04-ний өдрийн 01/247 дугаартай албан бичгээр Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Ажлын хэсгийн ахлагч Х.Нямбаатарт хүргүүлсэн.<br>3. ДУББСТ, ДУББСНТ-г [хүчингүй болгох тухай] [цуцлах] гэрээний төсөл, эдгээртэй холбоотой үүсэж болзошгүй асуудлуудын талаарх “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-н саналыг Монгол Улсын Засгийн газрын 2021.11.10-ны өдрийн хуралдааны 59 дүгээр тэмдэглэлд нийцүүлэн боловсруулж, 2021.11.22-ны өдрийн Н-15 дугаартай албан бичгээр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогтод, 2021.11.23-ны өдрийн Н-16 дугаартай албан бичгээр Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Насантогтох нарт тус тус хүргүүлсэн.<br>4. ДУББСТ, ДУББСНТ-г [хүчингүй болгох тухай] [цуцлах] гэрээний төсөл, эдгээртэй холбоотой үүсэж болзошгүй асуудлуудын талаарх “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-н саналыг 2021.10.18-нд УИХ дахь МАН бүлэгт, 2021.11.08-нд УИХ дахь АН бүлэгт тус тус танилцууллаа.<br>5. ДУББСТ, ДУББСНТ-г дуусгавар болгох, цуцлах тухай Хөрөнгө оруулагч талаас ирүүлсэн төсөлд “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-н зүгээс “ДУББСТ, ДУББСНТ-ийг хүчин төгөлдөр бус болохыг харилцан хүлээн зөвшөөрөх гэрээ”-г байгуулах саналыг боловсруулж, 2022.01.14, 2022.01.16, 2022.01.28, 2022.03.16-ны өдрүүдэд тус тус “Ажлын хэсэг”-т хүргүүлсэн.<br>6. Уг асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 45 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг судалж, санал дүгнэлтээ гаргах, улмаар гадаадын хөрөнгө оруулагч талтай хэлэлцэн тохиролцох ажиллагаа явагдаж байна. | | |
| 64 | 4 | 9 | 1.3/. Оюу толгой төслөөс хүртэх Монголын талын үр өгөөжийг Хөрөнгө оруулалтын гэрээ болон 2010 оны техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоололд заасныар нэрлэсэн үнээр 53 хувиас бууруулахгүй байх хүрээнд | 1. “Оюу Толгой” ХХК-с ирүүлсэн санхүүгийн загварт нарийвчилсан шинжилгээ хийж, Гол параметерүүдийн Монгол Улсын 3Г-н төслөөс хүртэх мөнгөн урсгалд нөлөөлөх мэдрэмжийн шинжилгээг хийж, нөлөөллөөр нь эрэмбэлсэн. 2. Дээрх судалгаанд үндэслэж Монгол Улсад ногдох мөнгөн урсгалыг нэмэгдүүлэх боломжит хувилбаруудыг боловсруулж, үр дүнг тооцоолж, танилцуулга материал бэлтгэж | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Монголын талын эзэмшлийн 34 хувийн хувьцаа эзэмшлийг бүтээгдэхүүн хуваах нөхцөл, эсвэл ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах хувилбаруудыг судлан шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах тухай санал боловсруулан Улсын Их Хуралд танилцуулах; | холбогдох албан тушаалтнуудад танилцуулсан. 3. Хөрөнгө оруулагчдын хоорондох хэлэлцээрт шаардлагатай мэдээллийг бэлтгэж, МУЗГ-ын 34 хувийн эзэмшилд ногдох зээлийн үлдэгдэлийг тэглэхтэй холбоотой санхүүгийн тооцоолол, мэдээллийг бэлтгэж эрх бүхий төрийн байгууллагуудад хүргүүлсэн. 4. 2022.01.25-нд МУЗГ-т ногдох 34%-ийн хувьцааны зээлийн өр болох 2,363 сая ам.долларын өр тэглэгдсэнээр МУЗГ төслөөс бодит мөнгөн ногдол ашиг хүртэх нөхцөл бүрдсэн бөгөөд ирээдүйд төслөөс хүртэх өгөөжийн хувь 53%-д хүрэх төсөөлөлтэй байна | | |
| 65 | 4 | 10 | 1.4/. Оюу толгой ордын зэс, алт, мөнгө болон бусад дагалдах элементийн нөөцийн үнэлгээг Монгол Улсад мөрдөгдөж байгаа олон улсын стандартын дагуу дахин хийж, үүнд үндэслэсэн техник, эдийн засгийн үндэслэлийг дахин боловсруулж, эрх бүхий байгууллагаар дүгнэлт гаргуулах; | Оюу Толгойн бүлэг ордын нөөцийг 2015-2018 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнд тулгуурлан дахин тодотгон, тооцоолж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн хуралдаанд 2021 онд танилцуулж бүртгүүлсэн. Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлөөс орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг тогтоогдсон нөөцийг иж бүрэн ашиглах хүрээнд боловсруулж, танилцуулах даалгаварыг Оюутолгой ХХК-д өгсөн. Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн сайдын 2021.11.24-ний өдрийн А/284 тоот тушаалаар "Оюутолгой болон Засгийн газар хоорондын мэдээллийн тэнцвэртэй байдал, ойлголтын зөрүүг арилгах зорилго бүхий ажлын хэсэг"-ийг байгуулж, Ажлын хэсгийг газар дээр нь ажиллуулсан. Уг ажлын хэсэгт Оюутолгой ХХК-ийн зүгээс Хойд Хюго ордын 1-р давхарын хэмжээнд хийгдэж буй судалгааны ажлын үр дүнд үндэслэн техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулж, 2023 оны 4-р улиралд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хүргүүлэх төлөвлөгөөг танилцуулсан байна. | 70% | |
| 66 | 4 | 11 | 1.5/. Байгаль орчны болон усны нөхцөл байдлын үнэлгээг шинэчлэн хийлгэж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 175 тоот "Газрыг улсын хэрэгцээнд авах тухай" тогтоолыг өөрчилж, говийн бүсийн гүний ус ашиглах нөхцөлийг харгалзан тогтоох; | Эрдэнэс Оюу Толгой" ХХК-иас Оюутолгой ХХК-д гүний хоолойн газрын доорх ус ашиглалтын үеийн нөөцийг дахин үнэлүүлэх талаар санал хүргүүлж, 2022 оны үйл ажиллагааны төсөвт хайгуулын ажил хийх зардлыг тусгуулан холбогдох ажлыг зохион байгуулсан. Оюу Толгойн ордоос зэс-алт олборлох төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ)-ний нэмэлт тодотголыг 2016 онд гүйцэтгэсэн. Оюутолгой ХХК-иас орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлд нэмэлт, тодотгол хийсний дараа байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ)-ний нэмэлт тодотголыг боловсруулж, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлэхээр төлөвлөж байна. | 70% | |
| 67 | 4 | 12 | 1.6/. Монгол Улсын Их Хурлын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар захирамжаар байгуулагдсан Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, | Эрдэнэс Оюутолгой" ХХК-ийн зүгээс 2009.10.06-ны өдөр байгуулсан "Хөрөнгө оруулалтын гэрээ", 2011.06.08-ны өдөр байгуулсан "Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээ", 2015.05.18-ны өдөр байгуулсан "Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө"-г тодорхой болгох, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс шинээр болон дахин найруулах, өөрчлөлт оруулах, нэгтгэх, хасах санал болон санхүүгийн | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | дүгнэлтийг хэрэгжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах; | зарим тооцооллын талаарх мэдээллийг Монголын талын ажлын хэсэг дотроо тусгайлан хэлэлцүүлэхээр 2021.11.04-ний өдрийн 01/247 дугаартай албан бичгээр Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Ажлын хэсгийн ахлагч Х.Нямбаатарт албан хүргүүлсэн байна. Оюутолгой ХХК-тай байгуулсан "Хөрөнгө оруулалтын гэрээ"-ний 3.7-д "Оюу толгой төслийн ил, далд уурхайгаас дараагийн 5 /таван/ жилд олборлож боловсруулахаар тооцсон Бүтээгдэхүүний тоо хэмжээг заасан хүснэгтийг Хөрөнгө оруулагч жил бүр шинэчилж, Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх..." гэж заасны дагуу уг хүснэгтийн загварыг боловсруулж, 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 2/2057 дугаартай албан бичгээр Оюутолгой ХХК-д хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/16 дугаар тушаалаар батлагдсан "Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах журам"-ын 2.1.1-д заасныг тус тус үндэслэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж Оюутолгой ХХК-ийн Далд уурхайн бүтээн байгуулалттай газар дээр нь танилцаж, ашиглалтад хүлээн авах эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргахаар 2022 оны 05 дугаар сарын 24-нөөс 25-ны хооронд ажиллаж, далд уурхайг Панел-0-ийн хүрээнд хүлээн авсан. | | |
| 68 | 4 | 13 | 1.7/. Оюу толгой төслийн Монголын талын төлөөллийг хэрэгжүүлэгч байгууллагын санхүүгийн болон хүний нөөцийн чадавхыг олон улсын түвшинд хүргэж, бэхжүүлэх. | 1."Эрдэнэс Оюутолгой" ХХК-ийн үндсэн зорилго, чиг үүргийг хэрэгжүүлэх, Монгол Улсын Их Хурлын "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" 2019 оны 92 дугаар тогтоолын 1.7-д заасны дагуу "Оюу Толгой" ХХК-д менежментийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор "Оюу Толгой" ХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 274 дүгээр тогтоолоор "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн дээрх чиглэлийн үйл ажиллагааны 4 жилийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн байна. 2. "Эрдэнэс Оюутолгой" ХХК-ийн хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд зөвхөн ажлын байрны тодорхойлолтод нийцсэн мэргэжлийн ажил горилогчийг шалгаруулан авч хүний нөөцийн бүрдүүлэлтийг хийж ажиллаж байна. Мөн байгууллагад өөрийн мэдлэг чадвараа дайчлан ажлын өндөр бүтээмж, үр дүн гарган ажиллаж байгаа ажилтнуудын албан тушаалын зэрэглэл, ажлын гүйцэтгэлд нь нийцсэн цалин хөлс, урамшуулал олгож, ажилтны тогтвор суурьшилтай, өндөр бүтээмжтэй ажиллах нөхцөлийг цалин хөлс, урамшуулал, бусад хангамжийг сайжруулах замаар бүрдүүлж байна. 3. "Эрдэнэс Оюутолгой" ХХК-ийн ажилтнуудыг олон улсын түвшинд хүргэж мэргэшүүлэх тал дээр илүү олон төрлийн сургалтад ажилтнуудыг хамруулах тал дээр анхаарч ажиллахаар төлөвлөсөн хэдий ч Монгол Улсын Төрийн хэмнэлтийн тухай хуульд туссан баримталбал зохих 15.2.3 сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх; зэрэгт нийцүүлэн | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | гадаадын мэргэжлийн уул уурхайн онлайн сургалт авах зэргээр ажилтнуудыг хязгаарлагдмал хүрээнд чадавхижуулж байна. | | |
| 69 | 5 | 14 | **Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2020-01-09 Дугаар 2020 №02** УУХҮЯ хуулийн төсөл 2020. Ашигт малтмалын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн холбогдох судалгааг хийх, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн зүгээс Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх аргачлал, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл болон хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэргийг эцэслэн боловсруулсан. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөлд мэргэжлийн холбоод болон аж ахуйн нэгж байгууллагаас санал авах хэлэлцүүлгийг зохион байгуулж холбогдох саналыг авч хуулийн төсөлд тусгахаар ажиллаж байна. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.10.27-ны "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" А/273 дугаар тушаалаар байгуулагдаж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу УИХ-д өргөн мэдүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.10.27-ны өдрийн А/273 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг хуулийн төсөл болон үзэл баримтлалын төслийг боловсруулаад байна. | 70% | |
| 70 | 5 | 15 | СЯ хуулийн төсөл 2020. Үндэсний баялгийн сангийн тухай /Анхдагч хууль/ Засгийн газрын тусгай сангийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Татварын ерөнхий хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг батлаж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж, хуулийн төсөлд яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамнаас 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг ЗГХЭГ-аар дамжуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бүрдлийг ханган хүргүүлсэн. Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу 2022.11.01-ний өдөр хуулийн төсөл, дагалдах хууль болон холбогдох | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | бусад бичиг баримтуудыг буцаахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт албан бичиг төлөвлөн хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" 192 дугаар захирамжаар Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Улмаар тус Ажлын хэсгийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн сайд ажиллах болсон тул холбогдох материалуудыг 2022 оын 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/3297 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайдад шилжүүлсэн | | |
| 71 | 6 | 16 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай**<br>**2020-08-28**<br>**Дугаар 2020 №24**<br>2.4/. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан экспортыг нэмэгдүүлж, ажлын байр бий болгон иргэдийн орлогыг нэмэгдүүлж, эдийн засагт нөлөө үзүүлэх 10 томоохон төслийг санхүүгийн боломжит бүх арга хэрэгслийг ашиглан санхүүжүүлэх. | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Шинэ сэргэлтийн бодлого"-д салбарын хэмжээнд хэрэгжүүлэхээр тусгасан Газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн "Ил уурхайн олборлолтын технологи нэвтрүүлэх төсөл", "Далд уурхайн төсөл", "Ус хангамжийн системийн төсөл", "Нүүрс баяжуулах үйлдвэрийн төсөл", Эрдэнэт гангийн үйлдвэр байгуулах төсөл, Дархан гангийн үйлдвэр байгуулах төсөл, Алтанширээт аж үйлдвэрийн парк байгуулах төсөл, Газрын тос дамжуулах хоолой барих төсөл, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ийн "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төсөл", "Исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл", "Уул уурхай-металлург-химийн үйлдвэрлэлийн төсөл", Оюутолгойн ордыг түшиглэн "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төсөл" зэрэг төслүүдийн хэрэгжилтийн явц, тулгамдаж буй асуудал, санхүүжилтийн саналын талаарх мэдээллийг боловсруулж 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 01/2820 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Тус яам нь "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолын дагуу тус компаний төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн үүргийг 2018-2021 оны хооронд гүйцэтгэж байна. Улсын Их Хурлын 2020.08.28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.6.1.1."Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг барьж дуусган, Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлнэ" гэж тусгагдсан. Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоолын дагуу байгуулагдсан "Тавантолгой төмөр зам" ХХК, Засгийн газрын 2020 оны 117 дугаар тогтоолын дагуу байгуулагдсан "Зүүнбаян төмөр зам" ХХК-иудад шаардагдах хөрөнгө оруулалтыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-иас Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу олгож Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг ашиглалтад оруулсан. | 100% | |
| 72 | 6 | 17 | **Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай** | 1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд хяналт тавьж, төсвийн орлого | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | **холбогдуулан авах арга хэмжээний тухай 2020-12-04 Дугаар 2020 №39**<br><br>1.1/. 1.Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай: 1/бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсвийн орлого нэмэгдүүлэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж, бүх салбарын төсвийн шинэчлэлийг эрчимжүүлэх; | нэмэгдүүлэх, тэвчиж болох зардлыг хэмнэн зарцуулалтад анхаарч ажилласан. 2021 төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулахад анхаарч хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт тавьж гүйцэтгэгч байгууллагын ажлыг гүйцэтгэлийн явцад 2 удаа ажлын талбар дээр очиж хяналтыг хийсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцаас 2021 онд Улсын төсөвт төвлөрүүлэхээр баталсан 265.4 тэрбум төгрөгөөс 268.9 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж 101.2%-иар орлогын төлөвлөгөөг биелэсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцад 2021 онд батлагдсан 39.8 тэрбум төгрөгийн зардлаас 36.3 тэрбум төгрөгийг буюу 92%-иар зардлыг зарцуулсан ба 8%-ийн хэмнэлт гарсан байна. | | |
| 73 | 6 | 18 | 1.2/. Төсвийн ерөнхийлөн захирагчдын жилийн төсвийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой шийдвэр гарган, хэрэгжилтийг хангаж ажиллах; | УУХҮсайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг хүлээн авч хянан Сангийн яамны э-тайлангийн системд оруулан Засгийн газрын нэгтгэсэн тайланд нэгтгэсэн. УУХҮСайдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд Төрийн аудитын байгууллагад хүргүүлэн аудит хийлгэсэн. УУХҮСайдын жилийн төсвийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 9 дүгээр сарын 30 өдрийн байдлаар гарган Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. Зөвлөмжийн биелэлт 90.7%, акт, албан шаардлагын биелэлтийг 87.4%-тайгаар хүргүүлсэн. | 100% | |
| 74 | 7 | 19 | **Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай 2021-01-22 Дугаар 2021 №12**<br>3. Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч нэн шаардлагатай гэж үзсэн хууль тогтоомжийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлж | Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч нэн шаардлагатай гэж үзсэн УУХҮЯ-нд хамаарах 7 хууль тогтоомжийн төслийг санаачлан боловсруулаад байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны А/93 дугаар тушаалаар УУХҮЯ, Сангийн яам, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулж, ажлын хэсэг тус хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулж, 2022.01.05-ны өдөр Улсын Их хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн барьсан.Улсын Их хурал хуулийн төслийг 2022.12.23-ны өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцэж, баталсан.Хуулийн төсөл батлагдсанаар уул уурхайн бүтээгдэхүүний бирж байгуулах эрх зүйн орчин бүрдэж, уул | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | байхыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай. | уурхайн бүтээгдэхүүний нийлүүлэгч, худалдан авагчийг холбох найдвартай тогтолцоо бий болж, зах зээлийн бодитой ханш тогтохын зэрэгцээ, арилжааны болон гэрээ, хэлцлийн мэдээлэл олон улсын зах зээлд нээлттэй зарлагдсанаар хөрөнгө оруулагчид найдвартай мэдээллээр хангагдаж, улмаар Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар нэмэгдэх боломж бүрдэх юм | | |
| 75 | 7 | 20 | 4. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн биелэлтийг зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг жил бүрийн намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд хүргүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай. | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж, хуулийн төсөлд яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамнаас 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг ЗГХЭГ-аар дамжуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бүрдлийг хангаж хүргүүлсэн. Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу 2022.11.01-ний өдөр хуулийн төсөл, дагалдах хууль болон холбогдох бусад бичиг баримтуудыг буцаахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт албан бичиг төлөвлөн хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" 192 дугаар захирамжаар Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Ажлын хэсгийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн сайд ажиллах болсон тул холбогдох материалуудыг 2022 оын 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/3297 дугаар албан бичгээр ЭЗХСайдад шилжүүлсэн. | 100% | |
| 76 | 7 | 21 | УУХҮЯ хуулийн төсөл 2021.<br>Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай Баялгийн сангийн тухай Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт | 1.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг УУХҮС-ын 2020.11.02-ны өдрийн А/270 дугаар тушаалаар шинэчлэн байгуулагдсан. Хуулийн төслийн үзэл баримтлалыг 2020 оны 8 дугаар сард Сангийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталсан. Хуулийн төслийг батлагдсан үзэл баримтлалдаа нийцүүлэн боловсруулж, Хууль | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | оруулах тухай Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Хүнд үйлдвэрийг дэмжих тухай | тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу яамны цахим хуудас, "Нээлттэй нийгэм форум" болон "Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилга" төслийн цахим хуудсанд тус тус байршуулж санал авч, хуулийн төслийн хэлэлцүүлгийг иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан 2020.10.06-ны өдөр зохион байгуулж, саналыг тусгасан. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хуулийн төсөл, дагалдах хуулийн болон дүрэм, журам боловсруулах үүрэг бүхий олон улсын болон дотоодын зөвлөх 2020 оны 12 дугаар сараас ажиллаж, өмнө боловсруулсан хуулийн төсөлд тулгуурлаж шинэчилсэн хуулийн төсөл, танилцуулгыг боловсруулсан Ажлын хэсгийн гишүүд нь хуулийн төслийн бичвэрийг эцэслэж, Улсын Их Хурлын 2022 оны намрын чуулганд багтаан өргөн мэдүүлэхээр товлож байсан болович ХЗДХЯ руу хуулийн төслийг шилжүүлж, улмаар тус хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг ХЗДХС-ын 2022.09.05-ны өдрийн А/254 дүгээр тушаалаар байгуулсан бөгөөд тус яаманд үзэл баримтлалыг батлуулахаар 2022.10.31-ний өдрийн 1/5480 дугаар албан бичгээр ирүүлээд байна<br><br>2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн холбогдох судалгааг хийх, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн зүгээс Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх аргачлал, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл болон хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэргийг эцэслэн боловсруулсан. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөлд мэргэжлийн холбоод болон аж ахуйн нэгж байгууллагаас санал авах хэлэлцүүлгийг зохион байгуулж холбогдох саналыг авч хуулийн төсөлд тусгахаар ажиллаж байна.Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.10.27-ны өдрийн А/273 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан.<br>Ажлын хэсэг хуулийн төсөл болон үзэл баримтлалын төслийг боловсруулаад байна.<br>3. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж, хуулийн төсөлд яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамнаас 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг ЗГХЭГ-аар дамжуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бүрдлийг ханган хүргүүлсэн. Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу 2022.11.01-ний өдөр хуулийн төсөл, дагалдах хууль болон холбогдох бусад бичиг баримтуудыг буцаахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт албан бичиг төлөвлөн хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" 192 дугаар захирамжаар Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Улмаар тус Ажлын хэсгийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн сайд ажиллах болсон тул холбогдох материалуудыг 2022 оын 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/3297 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайдад шилжүүлсэн.<br>4. Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хүрээнд УУХҮ-ийн сайдын А/12 дугаар тушаалаар газрын тосны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааг хийж, хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн төсөлд төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг болон сургалтын урамшууллыг зарцуулах журам боловсруулахаар тусган ажиллаж байна. /ГТБГ-аас нэмэх/<br>5. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг УУХҮС-ын 2021.03.07-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар байгуулан, шатахууны импорт, бөөний болон жижиглэнгийн худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбогдсон нэршил, нэр томъёо, зохицуулалтыг ойлгомжтой болгох, чанарын хяналтын тогтолцоог бий болгох, завсрын бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэлийн зохицуулалтыг нэмж тусгах зэрэг зохицуулалтыг тусгасан төслийг боловсруулсан. Зөвшөөрлийн тухай хууль 2022.06.22-ны өдөр батлагдсантай холбогдуулан тус хуулийг дагалдан өөрчлөлт оруулах хуулийн төслийн хүрээнд Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | давхардсан тоогоор хуулийн 14 зүйлд нийт 40 хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг дахин боловсруулж Засгийн газрын 2022.11.09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлээд байна. /ГТБГ-аас нэмэх/<br>6.Хүнд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн хүрээнд Түүхий эд, эрдэс баялгийн нөөцөд тулгуурлан хүнд үйлдвэрийг төрийн нэгдсэн бодлогоор дэмжих, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх, үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, түүнчлэн хар болон өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэл, газрын тос, нүүрс-химийн боловсруулах үйлдвэрлэл, металл хийц, машин үйлдвэрлэлийг хөгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэн нутагшуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт болон татварын бодлогоор дэмжих замаар хүнд үйлдвэрийн салбарын эдийн засагт оруулах үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэсэн харилцааг зохицуулах "Хүнд үйлдвэрийн тухай" хуулийн төслийг боловсруулж 2021.08.24 өдөр Засгийн газарт хүргүүлэн, УИХ-ын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2021.12.14-ны өдрийн хурлаар хэлэлцэн, УИХ-ын даргын 2022.03.30-ны өдрийн 46 дугаар захирамжаар МУИХ-ын 2022 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард хэлэлцэх асуудлын дараалалд оруулсан бөгөөд УИХ-ын чуулганаар хэлэлцэхээр хүлээгдэж байна | | |
| 77 | 8 | 22 | **УУХҮЯ хуулийн төсөл 2023. Газрын хэвлийн тухай /Шинэчилсэн найруулга/** | Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан. Үүнд: Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагын хүрээнд:<br>• Давхардал, хийдэл, зөрчлийн судалгаа;<br>• Газрын хэвлийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн судалгааг хийсэн.<br>• Хуулийн төсөл боловсруулах практик үндэслэл, шаардлагыг гаргасан.<br>• Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг тодорхойлсон.<br>• Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай саналыг тусгасан.<br>• Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон Улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох хуулийн талаарх саналыг боловсруулсан. Хуулийн төслийн танилцуулга болон бусад холбогдох материалыг боловсруулж, албан бичгээр ХЗДХЯ-д хүргүүлэхээр удирдлагуудад танилцуулж байна | 70% | |
| 78 | 9 | 23 | **Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга** | 1. Монгол Улсын Их Хурлын 2019.11.21-ний өдрийн "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" 92 дугаар | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **хэмжээний тухай 2021-12-30 Дугаар 2021 №103** 1.1/. Оюу толгой төслийн Монгол Улсын Засгийн газрын эзэмшлийн 34 хувь /Эрдэнэс Оюу Толгой ХХК/-д ногдох Оюу Толгой ХХК-иас Туркойс Хилл Ресурсес Лтд-д төлөгдөх 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хуримтлагдаад байгаа нийт 2.3 тэрбум ам.долларын өрийг 100 хувь тэглэх; (1.Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газар болон Оюу толгой төслийн гадаадын хөрөнгө оруулагчтай хийсэн хэлэлцээрийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулагчаас ирүүлсэн саналыг харгалзаж дараах арга хэмжээг Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т зөвшөөрсүгэй:) | тогтоолоор нийт 7 арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан бөгөөд тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газар болон Оюу Толгой төслийн гадаадын хөрөнгө оруулагчтай хийсэн хэлэлцээрийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулагч Рио Тинто группийн Ерөнхий захирал Якоб Стаусхолм болон Туркойз Хилл Ресурсес компанийн Гүйцэтгэх захирал Стив Тибоу нараас 2021.12.13-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж, дараах 5 санал бүхий албан бичгийг ирүүлсэн. Үүнд:<br>1.Оюу Толгой төслийн Монгол Улсын Засгийн газрын эзэмшлийн 34%-д ногдох нийт 2.3 тэрбум ам.долларын өрийг 100% тэглэх. Ингэснээр өмнө нь тооцоолж байсан 22 тэрбум ам.долларын өр үүсэхгүй, улмаар "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн 34% эзэмшлийн үнэ цэн нэмэгдэж, ногдол ашиг авах хугацаа наашлах;<br>2.ДУББСТ болон "Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө"-г цуцлаж дуусгавар болгох;<br>3.Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын төслийн санхүүжилтэд хөндлөнгийн аудит оруулахыг зөвшөөрөх;<br>4.Гүний уурхай ашиглалтад орж олборлолт эхлэх хугацаа буюу 2023 оны эхний хагас хүртэлх нэмэлт зардлыг хөрөнгө оруулагч тал 100% хариуцаж "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-д нэмэлт өр үүсгэхгүй байх;<br>5."Оюу Толгой" ХХК-ийн засаглалыг сайжруулах байдлаар гүний уурхайн төслийн хяналтыг сайжруулах арга хэмжээ авч холбогдох зардлыг харилцан тохиролцсон нөхцөлийн дагуу "Оюу Толгой" ХХК төлөх; Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулах; төслийн байгаль орчин, нийгэм, засаглалыг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах гэсэн.<br>Түүнчлэн, тус албан бичигт "Энэхүү шийдвэрүүдийг гаргахад амаргүй байсан бөгөөд энэ нь манай эцсийн санал гэдгийг дурдахын дашрамд хөрөнгө оруулагчдаас Монгол Улсад шилжүүлж буй томоохон үнэ цэн бөгөөд цаашдын хамтын ажиллагааны итгэлцлийн суурь болно гэдэгт бид иттэж байна. Ингэснээр Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай УИХ-ын 2019 оны 92 дугаар тогтоол хэрэгжсэн гэж бидний зүгээс үзэж байна" гэж дурдсан байдаг.<br>-Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 45 дугаар захирамжаар Монгол Улсын Их Хурлын 92 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, Оюу Толгой төслийн гадны хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг шинэчлэн байгуулагдсан бөгөөд тус Ажлын хэсгийн дарга Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар 2021.12.22-ны өдөр "Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг хангуулах тухай" тогтоолын төслийг яаралтай горимоор хэлэлцүүлэхээр УИХ-ын даргад өргөн барьсан. Улмаар Улсын Их Хурлын 2021.12.30-ны өдрийн нэгдсэн чуулганы | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хуралдаанаар "Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг хангуулах тухай" тогттолын төслийг хэлэлцүүлж батлуулсан.<br>-"Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн 34%-д ногдох зээлийг тэглэх бичгийн Англи хэл дээрх төсөл (Deed Poll, Confirmation of debt forbearance and Current outstanding balance (the "Confirmation"))-ийг хөрөнгө оруулагч тал (Rio Tinto)-аас 2022.01.13-ны өдөр ирүүлсэн. "Эрдэнэс Оюу толгой" ХХК-иас тус саналыг дэмжих боломжгүй талаар дэлгэрэнгүй тайлбар, танилцуулгыг бэлтгэж, 2022.01.14-ний өдөр Ажлын дэд хэсгийн Хуулийн дэд хэсэгт хүргүүлсэн.<br>Улмаар "Оюутолгой" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хуралдаан 2022.01.24-25-ны өдрүүдэд хуралдаж, "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн 34%-д ногдох зээлийг тэглэх бичиг болох Албан ёсны мэдэгдэл, түүний хавсралт Батламжийн талаар хэлэлцээгүй бөгөөд "Огтлох малталтыг эхлүүлэхийг дэмжих тухай" ТУЗ-ийн тогтоолыг хэлэлцэн баталж, түүний хавсралтаар "Оюу Толгойн далд уурхайн төсөл огтлох малталтыг эхлүүлэх шалгуур нөхцөл, техникийн шалгуур нөхцөлтэй холбоотой нэмэлт мэдээлэл"-ийг Монгол, Англи хэл дээр хавсаргаж баталсан байна.<br>Улмаар 2022.01.25-ны өдрийн албан ёсны мэдэгдлийг "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захиралд "Оюу Толгой" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Ц.Цэрэнхүү 2022.01.26-ны өдөр хүлээлгэн өгсөн бөгөөд тус албан ёсны мэдэгдлийн дагалдах баримт бичгээр "Өрийг хүчингүй болгосон тухай болон одоогийн үлдэгдэл төлбөрийн тухай батламж" (Батламж)-ийн загвар хавсаргасан байна. | | |
| 79 | 9 | 24 | 1.2/. Монгол Улсын Засгийн газар, Эрдэнэс Оюу Толгой ХХК болон Туркойс Хилл Ресурсес Лтд, Ти Эйч Ар Оюу Толгой Лтд, Оюу Толгой Нидерланд Би Ви, Рио Тинто Интернэшнл Холдингс Лтд, Оюу Толгой ХХК-ийн хооронд 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан "Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө" болон "Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө"-г хуульд нийцүүлэн цуцалж, хүчингүй болгох; | 1. "Эрдэнэс Оюутолгой" ХХК-ийн зүгээс 2009.10.06-ны өдөр байгуулсан "Хөрөнгө оруулалтын гэрээ", 2011.06.08-ны өдөр байгуулсан "Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээ", 2015.05.18-ны өдөр байгуулсан "Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө"-г тодорхой болгох, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс шинээр болон дахин найруулах, өөрчлөлт оруулах, нэгтгэх, хасах санал болон санхүүгийн зарим тооцооллын талаарх мэдээллийг Монголын талын ажлын хэсэг дотроо тусгайлан хэлэлцүүлэхээр 2021.11.04-ний өдрийн 01/247 дугаартай албан бичгээр Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Ажлын хэсгийн ахлагч Х.Нямбаатарт албан хүргүүлсэн. 2. ДУББСТ, ДУББСНТ-г [хүчингүй болгох тухай] [цуцлах] гэрээний төсөл, эдгээртэй холбоотой үүсэж болзошгүй асуудлуудын талаарх "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-н саналыг Монгол Улсын Засгийн газрын 2021.11.10-ны өдрийн хуралдааны 59 дүгээр тэмдэглэлд нийцүүлэн боловсруулж, 2021.11.22-ны өдрийн Н-15 дугаартай албан бичгээр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогтод, 2021.11.23-ны өдрийн Н-16 дугаартай албан бичгээр Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Насантогтох нарт тус тус хүргүүлсэн. 3. ДУББСТ, ДУББСНТ-г | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | [хүчингүй болгох тухай] [цуцлах] гэрээний төсөл, эдгээртэй холбоотой үүсэж болзошгүй асуудлуудын талаарх "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-н саналыг 2021.10.18-нд УИХ дахь МАН бүлэгт, 2021.11.08-нд УИХ дахь АН бүлэгт тус тус танилцуулсан. 4. ДУББСТ, ДУББСНТ-г дуусгавар болгох, цуцлах тухай Хөрөнгө оруулагч талаас ирүүлсэн төсөлд "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-н зүгээс "ДУББСТ, ДУББСНТ-ийг хүчин төгөлдөр бус болохыг харилцан хүлээн зөвшөөрөх гэрээ"-г байгуулах саналыг боловсруулж, 2022.01.14, 2022.01.16, 2022.01.28, 2022.03.16-ны өдрүүдэд тус тус "Ажлын хэсэг"-т хүргүүлсэн. 6. Уг асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 45 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг судалж, санал дүгнэлтээ гаргах, улмаар гадаадын хөрөнгө оруулагч талтай хэлэлцэн тохиролцох ажиллагаа явагдаж байна. | | |
| 80 | 9 | 25 | 1.3/. Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтэд хөндлөнгийн аудит хийлгэх; | 1. Далд уурхайн бүтээн байгуулалтын төслийн зардал нэмэгдэж, ашиглалтад орох хугацаа хойшилсон тухай асуудлаар мэргэшсэн шинжээч сонгон, хөндлөнгийн дүгнэлт гаргуулж, тайлагнах үүрэг бүхий "Тусгай хороо"-г "Оюу Толгой" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Монголын талын ТУЗ-ийн гишүүдийн санаачилгаар 2020.11.30-ны өдрийн 253 дугаар тогтоолоор байгуулсан.<br>2. Тусгай хорооны 2021.03.15-ны өдрийн 7 дугаар хурлаар Хөндлөнгийн шинжээчдийн багийг сонгон ажиллуулсан. Хөндлөнгийн шинжээчдийн багийн гол зорилго нь төслийн бүтээн байгуулалтын ажлын хуваарь, зардал хэтрэхэд нөлөөлсөн үндсэн шалтгаануудыг тодорхойлох байв. Түүнчлэн, Хөндлөнгийн шинжээчдийн багийн дүгнэлт тайланд дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн хоёр мэргэжилтэн Хянан магадлагаа (Peer review) хийсэн.<br>2021.07.31-ний өдөр Оюу Толгой ХХК-ийн ТУЗ-ийн Тусгай Хороонд зориулж Хөндлөнгийн Шинжээчдийн багийн бэлтгэсэн "Эцсийн Тайлан" гарсан.<br>Хөндлөнгийн шинжээчдийн баг нь Төслийн зардлын хэтрэлт нь зөвхөн геотехникийн асуудал, далд уурхайн бүтээн байгуулалт, уулын цулын малталтаас шалтгаалаагүй гэж дүгнэсэн.<br>Тогтвортой олборлолт хийх хүртэл Төслийн хугацаа нь 22 сараар хойшилж, Капитал зардал дуусах үе шат хүртэл 34 сар нэмэгдсэн нь ИХНБУМ (EPCM)-ийн үйлчилгээ болон Эзэмшигчийн Төслийн Менежментийн багын зардлууд хэтрэх гол шалтгаан болсон.<br>Гүний уурхайн дэд бүтцийн байгууламжууд болох материал дамжуулах систем, бутлуурын байгууламжууд нь мөн зардлын хэтрэлтэд ихээр нөлөөлсөн.<br>Гадаргуун дэд бүтцийн байгууламжууд болох босоо ам, агуулах, төвийн дулааны станц, ажилчдын хувцас солих байр зэрэгт зардал нилээд өссөн . | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Гадаад валютын орлогын тооцоолол нь цэвэр зардлын хэтрэлтийг буурахад нилээд нөлөөлсөн." гэж дүгнээд санхүүгийн аудит хийлгэхийг зөвлөсөн.<br>3. Тогтоолын энэ заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хөндлөнгийн, хараат бус, мэргэшсэн, хүлээн зөвшөөрөгдсөн аудиторуудыг судлах, харилцаа тогтоох, санал болгох, сонгох зэрэг зохион байгуулалтын ажиллагааг эхлүүлж, тэдгээр аудиторуудтай хамтран ажиллах бэлтгэлийг ханган ажиллаж байна.<br>4. "Оюу Толгой" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 274 дүгээр тогтоолд тусгагдсан Хөндлөнгийн аудит ажиллуулах асуудлыг Тусгай хорооны дүрэмд тусгаж, хэрэгжилтийг хангуулах ажиллагаа хийгдэж байна.<br>5. Тусгай хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр хөндлөнгийн, хараат бус хуулийн фирмийг авч ажиллуулж холбогдох зардлыг "Оюу Толгой" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 274 дүгээр тогтоолд заасны дагуу "Оюу Толгой" ХХК хариуцана.<br>6. Одоогоор санхүүгийн аудит хийлгэх газрыг судалж байгаа бөгөөд Эрдэнэс Оюу толгой ХХК-н зүгээс санхүүгийн аудитын хамрах, хүрээ ажлын далгаварыг бэлтгэн тусгай хороонд хүргүүлээд байна. | | |
| 81 | 9 | 26 | 1.4/. Оюу толгой төслийн гүний уурхай ашиглалтад орж олборлолт эхлэх хугацаа буюу 2023 оны эхний хагас жил хүртэлх нэмэлт зардлыг гадаадын хөрөнгө оруулагч тал 100 хувь хариуцаж, Эрдэнэс Оюу Толгой ХХК-д нэмэлт өр үүсгэхгүй байх, Оюу Толгой ХХК-д хувьцаа эзэмшигчид болон гуравдагч этгээдээс нэмэлт зээлийн санхүүжилт авахгүй байх; | 1. Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн УИХ-01/231 дугаартай "Хариу хүргүүлэх тухай" албан бичигт: "*"Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн тогтоолыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Түр хорооны хуралдаанаар хэлэлцэх явцад тогтоолын 1.4 дэх дэд заалтын тухайн хэсгийг Улсын Их Хурлын гишүүд хэрхэн үзэж томъёолсон талаар Түр хорооны албан бичгийг хавсарган хүргүүлж байна."* гэж дурдаж, түүний хавсралтаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэний 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн УИХ-03/213 дугаартай "Хариу хүргүүлэх тухай" албан бичгийг Рио Тинто группийн Зэсийн группийн Гүйцэтгэх захиралд хүргүүлсэн байна.<br>Тус албан бичигт:<br>*"Чуулганы хуралдааны явцад Оюу Толгой төслийн 2022-2023 оны эхний хагас хүртэлх хугацаанд шаардагдах нэмэлт санхүүжилт, зардлыг ОТ ХХК-д өрийн нэмэлт дарамт учруулахгүй байхаар, санхүүжилтийн хүүгүй эх үүсвэр ашиглах зарчим баримтлахыг УИХ-ын ихэнх гишүүд онцгойлон анхааруулж, санал хэлсэн бөгөөд өөрөөр хэлбэл, Оюу Толгой төсөлд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг өндөр хүүтэй хувь нийлүүлэгчдийн болон арилжааны, түүнчлэн төслийн санхүүжилтээс бусад санхүүжилтийн боломжит дараах хувилбарыг ашиглаж санхүүжүүлэх боломжтой гэж санал гаргасан УИХ-ын гишүүд үзсэн болно. Үүнд:*<br>*"Эрдэнэс Оюу Толгой" ХХК-д өрийн нэмэлт дарамт учруулахгүй байхаар тооцож хувьцааны санхүүжилтээр хийх;* | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | *Тухайн жилд санхүүжүүлэх үйл ажиллагааг санхүүгийн тухайн жилийн үйл ажиллагааны явцад үүсэх чөлөөт мөнгөн хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр тооцох;*<br>*Шаардлагатай бол зарим санхүүжилтийн эх үүсвэрийг урьдчилгаа төлбөр байдлаар урьдчилан авч, эргэн төлөлтийг бүтээгдэхүүнээр төлөх;*<br>*Рио Тинто Интернэшнл Холдингс Лтд компанийн өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс хүүгүй нөхцөлөөр"* гэжээ.<br>Энэхүү албан бичигт 2022-2023 оны эхний хагас хүртэлх Оюу Толгой төсөлд шаардлагатай нэмэлт санхүүжилт, зардлыг шийдвэрлэхдээ *"ОТ ХХК-д өрийн нэмэлт дарамт учруулахгүй, санхүүжилтийн хүүгүй эх үүсвэр ашиглах"* зарчмыг баримталж, санхүүжүүлэх боломжтой хувилбаруудын тухай УИХ-ын гишүүдийн гаргасан саналуудыг дурджээ. Үүнд:<br>Монголын талд нэмэлт өр үүсгэхгүй, хувьцааны санхүүжилт хийх;<br>Гадаадын хөрөнгө оруулагч тал өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хүүгүй санхүүжүүлэх;<br>Компанийн үйл ажиллагааны тухайн жилийн чөлөөт мөнгөн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх;<br>Шаардлагатай бол зарим санхүүжилтийн эх үүсвэрийг урьдчилгаа төлбөрийн байдлаар урьдчилан авч, эргэн төлөлтийг бүтээгдэхүүнээр төлөх гэсэн байна.<br>2. Уг асуудлыг 2022.06.15-16-ны өдрүүдэд хуралдахаар товлогдсон ОТ ХХК-ийн ТУЗ-ийн ээлжит 49 дүгээр хурлын хэлэлцэх асуудалд багтаасан боловч 2022.06.22-ны өдрийн байдлаар Оюу Толгой төслийн санхүүжилттэй холбогдуулан танилцуулсан "Урьдчилгаа төлбөрийн гэрээ"-ний нөхцөл нь Монгол Улсын Их Хурлын 2021 оны 103 дугаар тогтоолын 1.4 дэх заалтад: *"Оюу толгой төслийн гүний уурхай ашиглалтад орж олборлолт эхлэх хугацаа буюу 2023 оны эхний хагас жил хүртэлх нэмэлт зардлыг гадаадын хөрөнгө оруулагч тал 100 хувь хариуцаж, Эрдэнэс Оюу Толгой ХХК-д нэмэлт өр үүсгэхгүй байх, Оюу Толгой ХХК-д хувьцаа эзэмшигчид болон гуравдагч этгээдээс нэмэлт зээлийн санхүүжилт авахгүй байх;"* гэсэнтэй нийцүүлэх шаардлагыг тавьж, зарим нэмэлт мэдээлэл, санхүүгийн тооцоолол, харьцуулсан судалгаа, холбогдох хариу тайлбартай танилцах шаардлагын хүрээнд уг хурал түр завсарласан болно.<br>3. УИХ-н 103 дугаар тогтоолын 1.4 заалтын дагуу "Оюу Толгой" ХХК нь Хувь Нийлүүлэгчдийн зээлийг 2022 оны 1 дүгээр сараас, энгийн хувьцааг 2021 оны 3 дугаар сараас хойш нэмж гаргаагүй.<br>4. "Оюу Толгой" ХХК-с ТУЗ-н 2022.03.15-ны хуралд ОТ ХХК-н 2022-2024 оны санхүүжилтийн төлөвлөгөөг танилцуулсан. Үүнд:<br>Төслийн зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулж, үндсэн төлбөрийн төлөлтийг хойшлуулах, | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Урьдчилгаа төлбөрийн санхүүжилт хийх,<br>Давуу эрхтэй төслийн зээл нэмж авах зэрэг санхүүжилтийн хувилбаруудыг танилцуулсан.<br>5. "Эрдэнэс Оюу толгой" ХХК-н зүгээс санхүүжилтийн хувилбаруудын нөхцөлүүдийг нарийвчлан судалж 103-р тогтоолтой нийцэхгүй байна гэсэн дүгнэлт гаргасан байна.<br>6. ТРК болон Рио Тинто-оос ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн гэрээтэй холбоотой санал, болон PWC-н дүгнэлт, ЭОТ ХХК-ийн санхүүгийн зөвлөхүүдээс гаргасан дүгнэлт зэрэгт дүн шинжилгээ хийж, нэгдсэн дүгнэлт гаргаж, урьдчилгаа төлбөрийн гэрээний нөхцөлийг УИХ-н 103-р тогтоолд нийцүүлэх талаар холбогдох саналыг боловсруулж холбогдох албан тушаалтнуудад хүргүүлээд байна. | | |
| 82 | 9 | 27 | 1.5/. Оюу Толгой ХХК-ийн засаглалыг сайжруулах, Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулах, ус ашиглалт, байгаль орчин, нийгэм, засаглалыг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах; | 1. Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2020 оны 217 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг болон Оюутолгой ХХК нь хамтран ажиллаж ХөОГ-ний 7.3.3-т заасны дагуу Монгол Улсын Нэгдсэн сүлжээнээс Оюутолгой ХХК-ийг цахилгаан эрчим хүчээр хангах тухай гэрээний төслийг харилцан тохиролцсон. 2. 2022.01.27-ны өдөр Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс Оюу Толгой уурхайг урт хугацаанд "Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ"-г Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК, Диспетчерийн үндэсний төв ХХК, Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК болон Оюутолгой ХХК-ийн хооронд байгуулсан. 3. Эрдэнэс Оюу толгой ХХК-ийн зүгээс ус ашиглалтыг сайжруулах чиглэлээр дараах ажлуудыг хийгдэж байна. Үүнд: -<br>Оюу Толгой төслийн хүрээнд жилдээ 8-14 мянган хүн ажиллаж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар хүн амын унд ахуйн хэрэглээний 3.0 сая.м3 усыг байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 заалтын дагуу усны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөгдсөн бөгөөд Монгол Улсын Засгийн Газрын 326, 327 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах, ундны усанд төлбөр ногдуулах тухай асуудлаар Усны газартай хамтран ажиллаж байна. - Оюутолгой ХХК нь улсын хяналт шинжилгээний сүлжээнд өнөөгийн байдлаар нийт 12 мониторингийн цэг холбогдсон байгаа бөгөөд цаашид Гүний хоолойн ордын талбай дахь цооногуудаас сонгон авч улсын хяналт шинжилгээний сүлжээнд нэмэлт мониторингийн цэгүүд холбохоор төлөвлөн ажиллаж байна. 4. "Оюу Толгой" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 274 дүгээр тогтоолын 6 дахь заалтын хэрэгжилтийг хангуулж "ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ"-ний төслийг боловсруулж, зөвшилцөж, харилцан тохиролцохоор Оюутолгой ХХК-д хүргүүлсэн. | 100% | |
| 83 | 9 | 28 | 1.6/. татварын актуудын биелэлтийг хангуулах, цаашид нэг мөр ойлгож дагаж мөрдөхийг хүлээн зөвшөөрүүлж, хэрэгжүүлэх. | 1. 2013-2015 оны татварын маргаан:<br>2013-2015 оны татварын аудитын үр дүнд Монгол Улсын ТЕГ-аас Оюу Толгой ХХК-д 2018.01.10-ны өдөр шийтгэлийн хуудас ногдуулж, нийт 377 тэрбум төгрөгийн татвар, торгууль төлөх, ирээдүйд шилжүүлэн тооцох татварын алдагдлыг (ИШТТА) 612 тэрбум төгрөгөөр бууруулах шаардлага тавьсан. Үүнээс Оюу Толгой ХХК 11 тэрбум төгрөгийн татвар, | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | торгууль төлөх шаардлага, мөн ирээдүйд шилжүүлэн тооцох татварын алдагдлыг 579 тэрбум төгрөгөөр бууруулахыг хүлээн зөвшөөрсөн. Шийтгэлийн хуудсаар ногдуулсан татвар, торгуулийн мөнгөн дүнгийн үлдсэн хэсэг болох 366 тэрбум төгрөг буюу 128 орчим сая ам.доллар, мөн ИШТТА-аас бууруулахаар шаардсан үлдсэн 33 тэрбум төгрөгийг Оюу Толгой ХХК-иас хүлээн зөвшөөрөөгүй.<br>Засгийн газар, Оюу Толгой ХХК-иас (РТ, Туркойз Хилл Ресурс) уг татварын маргааныг олон улсын арбитраар шийдвэрлүүлэх шийдвэрт хүрсэн. Арбитрын мэдэгдлийг 2020.02.20-ны өдөр гаргасан. 2022.02.11-ний өдөр Татварын арбитрын явцыг 2022.08.12 хүртэл хойшлуулж, энэ хугацаанд тохиролцоонд хүрэхээр зорьж байгаа ч албан ёсны хэлэлцээр хараахан эхлээгүй байна.<br>ТЕГ-ын нэхэмжлэхийн дагуу Оюу Толгой ХХК 366 тэрбум төгрөг буюу 128 орчим сая ам.долларыг улсын төсвийн дансанд 2021 оны 3 сард шилжүүлсэн. Маргаан Оюу Толгой ХХК-д зэргээр шийдвэрлэгдсэн тохиолдолд энэхүү мөнгөн дүнг буцаан авах эрхтэй. Оюу Толгой ХХК арбитрт хандсан маргаантай асуудлууд (нийт 358 тэрбум төгрөг)-ыг Захиргааны хэргийн шүүхээс 2021.05.19-нд татан авсан. Мөн өдөр Захиргааны хэргийн шүүх үлдэж буй 2 асуудал (1.8 тэрбум төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийн татвар болон 33 тэрбум төгрөгийн ИШТТА)-ыг татварын албаны талд шийдвэрлэсэн. Энэхүү шүүхийн шийдвэрээр Оюу Толгой ХХК-д 5.8 тэрбум төгрөгийн хүү, торгуульд өршөөл үзүүлсэн. "Оюу Толгой" ХХК дээрх шүүхийн шийдвэрийн тодорхой хэсгээр 2021 оны 7-р сард Дээд шүүхэд давж заалдсан. 2021 оны 11-р сард Дээд шүүхээс өмнөх шүүхийн шийдвэрийг өөрчлөхгүй хэвээр үлдээх шийдвэр гаргасан. Оюу Толгой ХХК-иас Дээд шүүхийн шийдвэрийн дагуу 5.8 тэрбум төгрөгийг буцаан олгох хүсэлтийг ТЕГ-д гаргасан бөгөөд өнөөг хүртэл хариу нь гараагүй байна.<br><br>2. 2016-2018 оны татварын маргаан:<br><br>Татварын ерөнхий газраас Оюу Толгой ХХК-ийн 2016-2018 оны татварын аудитыг 2020 оны 12-р сард дуусгаж 649 тэрбум төгрөг буюу 228 сая ам.долларын нөхөн ногдуулалтын акт тавьсан. Үүнээс гадна Татварын ерөнхий газар нөхөн ногдуулалтын актаар Оюу Толгой ХХК-ийн ирээдүйд шилжүүлэн тооцох алдагдлын дүнг 3.4 их наяд төгрөгөөр бууруулан шийдвэрлэсэн. Үүний нэлээд хэсэг нь хувь нийлүүлэгчийн зээлд төлсөн хүүгийн төлбөр болон менежментийн үйлчилгээний төлбөрийн татварын хасагдах зардлын бууралт юм. Татварын хасагдах зардлыг бууруулахдаа үнэ шилжилтийн дүрэм журмын дагуу тухайн дүнг "сунгасан гарын зарчмаар" тооцоолоогүй гэж үзсэн.<br>Үүний дийлэнх хувь нь өмнөх татварын хяналт шалгалтаар дэвшүүлсэнтэй ижил асуудлууд бөгөөд олон улсын арбитрын маргаан | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | дээр хянагдаж байгаа асуудлууд болно. Өнөөг хүртэлх хугацаанд дараах арга хэмжээ хэрэгжээд байна. Үүнд:<br>Оюу Толгой ХХК 2021.04.02-нд Нэмэлт өөрчлөлт оруулсан нэхэмжлэлийг олон улсын арбитрт хүргүүлсэн.<br>МУЗГ 2021.04.30-нд Хариу тайлбар болон Сөрөг нэхэмжлэл гаргасан.<br>РТ, ТХР- ийг маргаанд оролцуулах МУЗГ-ын хүсэлтийг хүргүүлсэн ба арбитрын шүүх хурал 2023 оны 2-р сар хүртэл хойшлогдсон.<br>ТЕГ-ын дэргэдэх Маргаан таслах зөвлөл Оюу Толгой ХХК-ийн гомдлыг 2021.04.05-ны өдөр хэлэлцээд Нөхөн ногдуулалтын актыг хэвээр үлдээсэн. Оюу Толгой ХХК Захиргааны хэргийн шүүхэд 2021 оны 6 сард нэхэмжлэл гаргасан ба Захиргааны хэргийн шүүх 2021 оны 10-р сард арбитрын шийдвэр гарах хүртэл хэргийг түдгэлзүүлсэн. ТЕГ-ын нэхэмжлэхийн дагуу Оюу Толгой ХХК 649 тэрбум төгрөг буюу 228 орчим сая ам.долларыг улсын төсвийн дансанд 2021 оны 2, 3 сард шилжүүлсэн. Маргаан Оюу Толгой ХХК-ийн хувьд зергээр шийдвэрлэгдсэн тохиолдолд энэхүү мөнгөн дүнг буцаахаар байна. | | |
| 84 | 9 | 29 | 2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссанаар Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" 92 дугаар тогтоолыг хэрэгжсэн гэж үзсүгэй. | УИХ-ын 2021 оны 103 дугаар тогтоолын 1 дэх заалт бүрэн хэрэгжиж, тогтоолд заасан үр дүнг нэгтгэн үнэлсний дараа уг заалтын хэрэгжилтийг нэгтгэн дүгнэх боломж бүрдэнэ. | /-/ | |
| 85 | 10 | 30 | **Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай**<br>**2022-01-18**<br>**Дугаар 2022 №08**<br>1.1/. Ашигт малтмалын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/; Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй: | Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.10.27-ны өдрийн А/273 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг хуулийн төсөл болон үзэл баримтлалын төслийг боловсруулаад байна. | 70% | |
| 86 | 11 | 31 | **Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай**<br>**2022-07-05**<br>**Дугаар 2022 №46**<br>1/. паркийн үйл ажиллагаанаас төсөвт төвлөрөх орлогын тодорхой хувьтай тэнцэх санхүүжилтийг паркийг хөгжүүлэх, түүний дэд бүтцийг сайжруулах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зориулалтаар жил | УИХ-аас 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталж, 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт "Паркийн удирдлага нь Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компанийн хэлбэртэй байна" гэж тус тус заасны дагуу байгуулагдсан ҮТП-ийн бүтээн байгуулалт бүрэн хийгдэж, үйл ажиллагааг эхлэн, төсөвт орлого төвлөрүүлж эхлэхэд паркийн үйл ажиллагаанаас төсөвт төвлөрөх орлогын тодорхой хувьтай тэнцэх санхүүжилтийг паркийг хөгжүүлэх, түүний дэд бүтцийг сайжруулах, эдийн засгийн үр ашгийг | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | бүрийн улсын төсөвт тусгуулах арга хэмжээ авч, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох | нэмэгдүүлэх зориулалтаар жил бүрийн улсын төсөвт тусгуулах арга хэмжээ авахаар төлөвлөн ажиллаж байна. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.1.7-д заасны дагуу "Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/245 дугаар тушаалаар баталж, захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлийн 5959 дугаарт бүртгүүлээд байна. | | |
| 87 | 11 | 32 | 2/. үйлдвэрлэл, технологийн паркийн хууль, эрх зүйн зохицуулалт, татварын орчны талаарх танилцуулга, сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулах. | Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн танилцуулгыг хүнд болон хөнгөн үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгж байгууллага, үйлдвэрлэл, технологийн паркийн төлөөлөл, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөлөл, эрдэмтэн судлаачдыг оролцуулан 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хурлын танхимд зохион байгуулсан. Мөн Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон холбогдох хуулийн эмхэтгэлийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны цахим хуудсанд 2022 оны 8 дугаар сарын 15-ны өдөр байршуулсан. | 100% | |
| **1.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол** | | | | | | |
| 88 | 1 | 1 | **"Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл"-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ** 3.20.. Уул уурхай, барилга, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт аж ахуйн нэгж, байгууллагуудтай хийх гэрээнд "Хүүхэд ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ыг мөрдөж ажиллах талаар тусгаж, иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах. | Аймаг орон нутагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, нөхөрлөлүүдэд АМГТГ, МХГ-ууд төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтаа хийж байгаа ба насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулсан зөрчил 2022 оны жилийн эцсийн байдлаар гараагүй байна. | 100% | |
| 89 | 2 | 2 | **Чиглэл өгөх тухай 2018-04-25 Дугаар 2018 №08 ЭЗБХ** 2.2/. Төрийн захиргааны төв байгууллагуудын статистикийн мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах, хамрах хүрээг | УУХҮЯ болон ХБНГУ-ын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн (BGR)-ийн хамтран хэрэгжүүлж буй "Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ" (ТД 2020.2036.0) үзүүлэх төслийн хүрээнд геологи, уул уурхайн мэдээллийн системийг шинэчлэн сайжруулах ажлыг эхлүүлэн гүйцэтгэж байна. Энэ хүрээнд АМГТГ-т ашиглагдаж байгаа Уул уурхайн кадастрын цахим систем /кадастрын систем/, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө тайлангийн цахим систем /e-reporting/ гэсэн 2 үндсэн цахим мэдээллийн системийг цаашид | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | өргөжүүлэх, төрийн мэдээллийн нэгдмэл сангийн сүлжээг байгуулах; | өргөтгөн сайжруулж, уялдаа холбоог нь хангах, цахим хэлбэрээр иргэд, аж ахуйн нэгжид мэдээлэл, лавлагаа хүргэх, төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системд холбох зэрэг ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд хийгдсэн томоохон ажлууд нь Улсын бүртгэлийн ерөнхий газраас ХУР системээр дамжуулан тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн улсын бүртгэлд өөрчлөлт орсон тухай бүрт нь өөрчлөлтийг кадастрын систем рүүгээ татан авч аж ахуйн нэгжийн мэдээллээ шинэчилдэг болсон. | | |
| 90 | 3 | 3 | **Чиглэл өгөх тухай 2018-10-30 Дугаар 2018 №32 ЭЗБХ** 2.4/. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн олон талт эх үүсвэртэй байх бодлого баримтлах, Гашуунсухайт-Ганц модны боомтоор шатахуун импортлох ажлыг эхлүүлэх. | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 53 дугаар тогтоолоор Газрын тосны бүтээгдэхүүний импортын олон талт эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Өмнөговь аймаг дахь Шивээхүрэн болон Гашуунсухайт боомт орчмын хилийн зурваст газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламж барих зориулалтаар газар ашиглахыг зөвшөөрч, газрын байршил, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицол, талбайг хэмжээг баталсан. Үүний дагуу тус 2 боомт орчмын хилийн зурваст газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламжийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮ-ийн сайдын 2022.04.05-ны өдрийн А/60 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгийн зохион байгуулсан сонгон шалгаруулалтад Шунхлай ХХК шалгарч, тус яамтай хамтран ажиллах тухай №21, №22 тоот гэрээг байгуулан үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Гэрээ байгуулж, үйл ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан Өмнөговь аймгийн Шивээхүрэн болон Гашуунсухайт боомтын хилийн зурвас дагуу шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламж барих үйл ажиллагааг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх тухай хүсэлтийг Засгийн газрын 2022 оны 53 дугаар тогтоолд хамтран ажиллахаар нэр дурдсан төрийн болон орон нутгийн холбогдох байгууллагуудад УУХҮ-ийн Сайдын 2022.05.30-ны өдрийн 01/1539 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Шалгарсан аж ахуйн нэгж төслийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. | 100% | |
| 91 | 4 | 4 | **Экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газар, Монголбанканд чиглэл өгөх тухай 2019-04-09 Дугаар 2019 №04 ЭЗБХ** 2.4/. Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтын 7 дахь дэд заалтад заасан эх үүсвэрийг хөрөнгө оруулалтын санд төвлөрүүлж, уул уурхайн бус салбарын экспортыг дэмжих чиглэлээр хувьцааны болон зээлийн хөрөнгө оруулалтыг хийх. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон Монголбанкны ерөнхийлөгч нарын 2020 оны А/102, А-177 дугаар хамтарсан тушаалд 2022.04.05-ны өдрийн А/62, А-97 дугаар хамтарсан тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд хөнгөлөлттэй санхүүжилт олгох журмын 6.1-д заасны дагуу уулын ажил гүйцэтгэх баримт бичгийн бүрдлийг хангасан алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд санхүүжилт олгох үйл ажиллагаа явагдаж байна. Дээрх үйл ажилагааны хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас Монголбанкинд нийт 61 аж ахуйн нэгжийн жагсаалтыг хүргүүлсэн бөгөөд эхний ээлжинд БМНС ХХК, "Хаан булаг интернэйшнл" ХХК, Илт гоулд ХХК, "Вестерн ресурс" ХХК, "Хамтын эх булаг" ХХК, "Эс жи групп" ХХК, "Алтан гол эксплорэйшн" ХХК, "Алтай хангай бүрд" ХХК, "Наран мандал энтерпрайзес" ХХК, "Монрок" ХХК, "Хос хас" ХХК зэрэг | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | нийт 13 ААН-д 52,095.45 сая төгрөгийн урьдчилгаа болон урт хугацааны санхүүжилтийг олгосон байна. | | |
| 92 | 5 | 5 | **Засгийн газарт чиглэл өгөх тухай БОХХААБХ/ӨБХ/ 2019-05-28 Дугаар 2019 №04/01** 1.1/. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухахй хуулийн биелэлтийг нийслэл болон Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт хангасан талаар танилцуулах; | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5-д зааснаар хайрга, дайрганы түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох эрх нь орон нутгийн удирдлага засаг даргад хадгалагддаг. Орон нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход Ашигт малтмал, газрын тосны газраас дүгнэлт гаргадаг бөгөөд Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар давхцал байгаа тохиолдолд олгох боломжтой дүгнэлтийг гаргахгүй, хориотой юм. Харин урт нэртэй хууль гарахаас өмнө Ашигт малтмалын тухай хуулийн дагуу Төв аймгийн Алтанбулаг, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт олгогдсон байдаг бөгөөд уг газруудыг Засаг дарга цуцлаж шийдвэрлэсэн болон холбогдох мэдээллийг Ашигт малтмал, газрын тосны газарт ирүүлсэн тохиолдолд УУККС бүртгэх боломжтой. | 70% | |
| 93 | 6 | 6 | **Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021-12-28 Дугаар 2021 №6 УБХ.** I.1. Нүүрсний экспортыг нэгдүүлэхтэй холбоотой хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал, тээвэрлэлтийг нэмэгдүүлэх төслүүд /чингэлэгт тээврийн терминал, жолоочгүй тээврийн хэрэгсэл, дүүжин тээвэр, конвейнерийн систем/ | Засгийн газрын 2021 оны 185 дугаар тогтоолоор хилийн боомт, улсын хилийн бүс, зурвас газруудад чингэлэгт тээврийн терминал байгуулах үүргийг холбогдох албан тушаалтнуудад даалгасан. Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулсан. Тухайлбал, Гашуунсухайт боомтод 30 га талбайд чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг "Энержи ресурс" XXK, "Эрдэнэс Тавантолгой" XK, "Тавантолгой" ХК-иудын хөрөнгөөр гүйцэтгэж, 2021.09.20-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан. Харин Шивээхүрэн боомтод 11.6 га талбайд чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг "Монголын алт (МАК)" XXK, "Саусгоби сэндс" XXK, "Хүрэн толгой коал майнинг" XXK, "Өсөх зоос" XXK, "Жавхлант орд" XXK, "Цагаан өвөлжөө" XXK "Сан транс" ХХК-иуд гүйцэтгэж 2022.06.16-ны өдөр Шивээхүрэн терминал ХХК-ийг байгуулсан. Түүнчлэн Сангийн яамны дэргэдэх Хөгжлийн хөтөч төслийн нэгжээс хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулж, үүний дагуу Замын-Үүд, Гашуунсухайт боомтуудад өргөтгөл шинэчлэлтийн ажлуудыг 2021 онд эхлүүлсэн. Улсын Их Хурлын 2021.12.30-ны өдрийн нэгдсэн чуулганаар батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын 1 дүгээр зүйлд "Боомтын сэргэлт" гэсэн арга хэмжээ тусгагдсан. | 100% | |
| 94 | 6 | 7 | I.2. Экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжих төмөр замын төслүүд /Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, Богдхан төмөр зам, нүүрс ачилтын байгууламж, холболтын болон хилийн төмөр зам/ | Тус яам нь "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолын дагуу тус компаний төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн үүргийг 2018-2021 оны хооронд гүйцэтгэж байна. Улсын Их Хурлын 2020.08.28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.6.1.1."Тавантолгой-Гашуунсухайт, | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг барьж дуусган, Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлнэ" гэж тусгагдсан. Энэ хүрээнд Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоолын дагуу байгуулагдсан "Тавантолгой төмөр зам" ХХК, Засгийн газрын 2020 оны 117 дугаар тогтоолын дагуу байгуулагдсан "Зүүнбаян төмөр зам" ХХК-иудад шаардагдах хөрөнгө оруулалтыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-иас Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу олгож Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг ашиглалтад оруулсан | | |
| 95 | 6 | 8 | I.3. Үйлдвэрлэлийг дэмжих, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, агаарын бохирдлыг бууруулах төслүүд /Тавантолгойн цахилгаан станц, нүүрс баяжуулах, кокс-химийн, төрөл бүрийн сайжруулсан түлшний үйлдвэр, метан хийн болон дамжуулах хоолойн төслүүд, тэдгээртэй холбоотой бусад барилга байгууламж/ | <u>Нүүрс баяжуулах төсөл:</u> Үйлдвэрлэлийг дэмжих, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, агаарын бохирдлыг бууруулах төслүүдийн хүрээнд Нүүрс баяжуулах үйлдвэрийн зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр зарлаж, 2022 оны 03 дугаар сарын 2-ны өдөр нээж, гүйцэтгэгчээр БНХАУ-ын "Норинко Интернейшнл Күүперэшн" компани болон Дади инженеринг девелопмент групп" компаниудын түншлэл шалгарч 2022 оны 04 дүгээр сарын 14-ний ЭТТ 2022/222 тоот гэрээг байгуулан ажиллаж байна. Нүүрс баяжуулах төслийн бүтээн байгуулалтын ажил 2022 онд 13% -тай байна.<br>Улсын Их Хурлын 2020.08.28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.5.1.4-д "Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ" гэж, 3.2.1.6-д "Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна" гэж тус тус тусгагдсан.<br>Мөн Засгийн газрын 2020 оны 124 дүгээр тогтоолоор Тавантолгойн дулааны цахилгаан станц барих төслийг төрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зорилгоор "Тавантолгой дулааны цахилгаан станц" ТӨХХК-ийг байгуулсан бөгөөд уг компанийн 30 хувийг "Эрдэнэс Таванголгой" ХК-д эзэмшүүлэх замаар хөрөнгө оруулах шийдвэр гаргасан. Тавантолгой ордыг түшиглэн жилд 30 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын "Чайна металлуржикал инженеринг компани" /CMEC/ боловсруулж 2021 оны 4 сарын 1-ий өдрийн ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. "Тавантолгой түлш" ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 2021.10.13-ны өдрийн 316 дугаар тогтоолоор тус компанийн нийт хувьцааны 51 хувийг "Эрдэнэс Тавантолгой" ХК-д эзэмшүүлэх шийдвэр гарсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | "Тавантолгой Түлш" ХХК болон "Эрдэнэс Тавантолгой" ХК хооронд байгуулсан гэрээний хүрээнд 2022 онд нийт 36.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.<br>Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн 94 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлд "Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдаж байгаа газрын тос боловсруулах үйлдвэрийн газрын тос дамжуулах хоолойн байгууламж барихад шаардагдах 397 сая ам долларыг бүтээгдэхүүн урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /Д.Батбаатар/-д тус тус даалгасугай" гэж тусгагдсан.<br>Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд "Норинко интернэшнл күүпэрэйшн" лимитед компанитай 2022.04.22-ны өдөр 253 тоот Нүүрс худалдах, худалдан авах гэрээг байгуулсан. | | |
| 96 | 6 | 9 | 1.6. Ил уурхайн ашиглалтын өртөг, зардлыг бууруулж, олборлолтыг нэмэгдүүлэх чиглэлд далд уурхайн ашиглалтын технологийг нэвтрүүлэх боломжийг судлах | Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийг хангаж, бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд шинээр ил болон далд уурхайг нээх ажлыг эхлүүлж, олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх, ордын хэмжээнд конвейерийн систем болон бусад дэвшилтэт технологи нэвтрүүлж, өртөг зардлыг бууруулах арга хэмжээ авах тухай "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан яамдаас санал авч, саналыг тусган Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. | 100% | |
| 97 | 6 | 10 | 2. Эрдэнэс-Тавантолгой хувьцаат компанийн бие даан болон бусад этгээдтэй хамтран хөрөнгө оруулж, санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг энэ тогтоолын 1 дэх заалтад тусгагдсанаар хязгаарлаж, тэдгээрийг тус компанийн борлуулалтын орлого болон гадаад дотоод зах зээлд үнэт цаас гаргах, зээл авах, нүүрс урьдчилан борлуулах зэрэг эдийн засгийн үр ашигтай нөхцөлөөр санхүүжүүлэх арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай. | Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийг хангаж, бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд шинээр ил болон далд уурхайг нээх ажлыг эхлүүлж, олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх, ордын хэмжээнд конвейерийн систем болон бусад дэвшилтэт технологи нэвтрүүлж, өртөг зардлыг бууруулах арга хэмжээ авах тухай "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан яамдаас санал авч, саналыг тусган Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. | 70% | |
| 98 | 6 | 11 | 3. Төсөл хөтөлбөрүүдийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, санхүүжилт, хувь оролцоо, эзэмшил, | "Монгол Улсын уул уурхайн салбарын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ" сэдэвт зөвлөхдөх хуралдааныг 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Тус хуралд | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | борлуулалтын асуудлаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллахдаа менежментийн тогтвортой байдлыг хангах, компанийн засаглалыг сайжруулах арга хэмжээ авч, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай. | Эдийн засаг, хөгжлийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага, Залуу судлаачдыг дэмжих сан, Тогтвортой хөгжил, нийгмийг хариуцлагын зөвлөл, Монголын Уул уурхайн үндэсний ассоциаци, ХБНГУ-ын элчин сайдын яам, Оксфордын Их сургууль, Дэлхийн банк, Австрали-Монголын Эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр зэрэг гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын 50 гаруй төлөөлөл оролцож манай улсын нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээний өнөөгийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний стратегийг хэлэлцэж холбогдох зөвлөмжийг гаргаад байна. Засгийн газрын 2021.12.08-ны өдрийн 367 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлд "Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр "Эрдэнэс Монгол" ХХК-ийг тогтоосугай" гэж заасан. Засгийн газрын тогтоолын дагуу "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн менежментийн тогтвортой байдлыг хангах, компанийн засаглалыг сайжруулах ажлыг "Эрдэнэс Монгол" ХХК хариуцан ажиллаж байна. | | |
| 99 | 7 | 12 | **Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай**<br>**2022-05-24**<br>**Дугаар 2022 №03 АБГББХ**<br>1.1/. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг Монгол Улсын эрх ашигт нийцүүлэн шинэчилж, хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах; (1.Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр болон газрын тосны салбарын хөрөнгө оруулалт, экспорт, эрэл хайгуул, ашиглалт, олборлолт, байгалийн нөөц, нөхөн сэргээлтийн талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай:) | Монгол Улсын Газрын тосны ашиглалтын Тосон-Уул XIX, Тамсаг-XXI талбайнуудад байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/-г 2014 онд Монгол Улсын Их Хурлаар баталсан Газрын тосны тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтын дагуу Засгийн газрын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан "БХГ-ний загвар"-т нийцүүлэх ажлыг гүйцэтгүүлэх зорилгоор 2016-2018 онуудын хооронд холбогдох яам, агентлагийн түвшинд 4 удаа Ажлын хэсэг байгуулж ажиллаж байсан боловч өнөөдрийг хүртэл талууд нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 78 дугаар захирамжаар "Газрын тосны ашиглалтын Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайнуудад байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авсан "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн хэрэгжүүлж буй бүтээгдэхүүн хуваах гэрээг дүгнэх, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлыг судалж, санал боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын Шадар сайдаар ахлуулан ажиллаж байна. | 70% | |
| 100 | 7 | 13 | 1.3/. Ашигт малтмалын тухай болон Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах | 1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн холбогдох судалгааг хийх, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх; | байгуулсан. Ажлын хэсгийн зүгээс Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх аргачлал, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл болон хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэргийг эцэслэн боловсруулсан. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөлд мэргэжлийн холбоод болон аж ахуйн нэгж байгууллагаас санал авах хэлэлцүүлгийг зохион байгуулж холбогдох саналыг авч хуулийн төсөлд тусгахаар ажиллаж байна. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.10.27-ны "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" А/273 дугаар тушаалаар байгуулагдаж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу УИХ-д өргөн мэдүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 2. 2021 оны 1-р сарын 18-ны өдөр УУХҮ-ийн сайдын А/12 дугаар тушаалаар газрын тосны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааг хийж, хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн төсөлд санал авахаар яамны сайтад 2022 оны 7 дугаар сарын 7-ны өдөр байршуулсан. Хуулийн төсөл намрын чуулганы жагсаалтад ороогүй тул хүлээгдэж байна. | | |
| 101 | 7 | 14 | 1.4/. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дэвсгэрт дотоодын түүхий эдэд түшиглэн барьж байгаа Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдийн тогтвортой нөөцөөр хангах бэлтгэл ажлыг зохион байгуулах, газрын тосны хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлэх, шинээр нөөцийг тогтоох, ашиглах үйл ажиллагааг дэмжих; | "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн үйл ажиллагаа болон газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай газрын тосны нөөцийн талаар Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар танилцуулан 29 дүгээр тэмдэглэлийг гаргуулан хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна. | 70% | |
| 102 | 7 | 15 | 1.5/. "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн Байгаль орчны менежментийн 2020 оны төлөвлөгөөний биелэлтийг хангуулах, 2021, 2022 оны төлөвлөгөөг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд яаралтай баталж, хэрэгжилтэд хяналт | 2022 оны 06 дугаар сарын 28-аас 07 дугаар сарын 01-ний өдрийн хооронд Байгаль орчин аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг болон, Дорнод аймгийн Засаг даргын 2020 оны А/500 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг газар дээр нь дахин ажилласан ба 91%-иар үнэлж, 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдөр батлуулж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% | |
| 103 | 7 | 16 | 1.6/. Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой үүссэн маргааныг хууль тогтоомжийн дагуу эцэслэн шийдвэрлэх, шаардлагатай бол холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах; | Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой үүссэн маргаан ирээгүй болно. | /-/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 104 | 7 | 17 | 1.7/. "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-д 2018 онд нэмэгдсэн өртгийн албан татвар /НӨАТ/, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар /ААНОАТ/ , Хувь хүний орлогын албан татвар /ХХОАТ/-ыг төлөх тухай тавьсан шаардлагатай холбоотой гомдлыг Татварын ерөнхий газрын дэргэдэх Татварын маргаан таслах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх; | Петрочайна Дачин Тамсаг ХХК болон Татварын ерөнхий газар Бүтээгдэхүүн хуваах гэрээний зүйл заалт, холбогдох тооцоолол тоон мэдээллийг нягталж шалгах шаардлагатай гэж үзэж байгаа ба нэгдсэн саналд хүрээгүй байна. Харин 2022 оны 7 дүгээр сарын 8-ны өдөр Татварын ерөнхий газрын дэргэдэх Татварын маргаан таслах зөвлөлөөс энэхүү татварын маргааныг хэлэлцээд шийтгэлийн хуудсыг түдгэлзүүлж, дахин шалгуулахаар дээд шатны татварын албанд буцаасугай гэж шийдвэрлэсэн байна. | 100% | |
| 105 | 7 | 18 | 1.8/. Газрын тосны олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанд үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа гүний ус ашиглах технологийг өөрчилж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багатай, орчин үеийн дэвшилтэд техник, технологийг үе шаттай нэвтрүүлэх; | Шадар сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөндлөнгийн мэргэшсэн байгууллагаар дүгнэлт, зөвлөмж гаргуулах, бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх талаар судалгаа хийн ажиллаж байна. | 30% | |
| 106 | 7 | 19 | 1.9/. Газрын тосны хайгуул, олборлолтын үеийн үйл ажиллагаанаас үлдсэн чанарын шаардлага хангахгүй, устгах шаардлагатай химийн бодисын хог хаягдлыг олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийн дагуу шийдвэрлэх; | Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий "Элемент" ХХК Тосон-Уул XIX талбайд хуримтлагдсан химийн бодисыг устгах ажлыг гүйцэтгэж байна. Тус компани 2022.09.25-ны өдрөөс ажиллаж эхэлсэн бөгөөд 2022.10.12-ны өдрийн байдлаар 161 тонн химийн бодисыг Налайх дүүрэгт байрлах өөрийн үйлдвэр рүү тээвэрлэсэн байна. | 70% | |
| 107 | 7 | 20 | 1.10. Газрын тосны экспортын тээвэрлэлтийг шороон замаар хийж байгаагийн улмаас тухайн орон нутгийн байгаль орчин, бэлчээр ихээр сүйдэж, тоосжилт үүсч байгаа тул хатуу хучилттай автозамын барилгын ажлыг яаралтай дуусгах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг авах; | Бүтээгдэхүүн хуваах гэрээт 21 дүгээр талбайгаас Баянхошуу хилийн боомт чиглэлийн 58,5 км хатуу хучилттай автозамыг "Их Монгол Барилга" ХХК гүйцэтгэж байна. "Петрочайна Дачин Тамсаг" ХХК замын ажлын явцыг эрчимжүүлэх зорилгоор БНХАУ-ын авто замын компани болох "Дачин Баушн" ХХК-иар төлөвлөсөн автозамын маршрутын зүүн урдаас автозамын ажлыг эхлүүлэн ажиллаж байна. Захиалагч талаас 5000 тн цементийг худалдан авч талбайд татсан байна. Мөн ажиллах хүч, техник хэрэгслийг нэмэгдүүлэн 2022 оны 10 дугаар сард багтаан тус автозамыг ашиглалтад оруулахаар захиалагч болон гүйцэтгэгч нар хамтран ажиллаж байна. 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар замын далан 100%, суурийн үе (20см) 100%, дээд суурь (18см) 63.6%, Асфалтийн үе (5см) 58.9%-ийн гүйцэтгэлтэй байна. | 70% | |
| 108 | 7 | 21 | 1.11/. "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн зүгээс нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн орон нутгийн тогтвортой хөгжлийн бодлогыг дэмжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх, төсөл, хөтөлбөрийг | Ашигт малтмал, газрын тосны газар, Дорнод аймгийн Матад, Халхгол сумдын Засаг дарга болон Петрочайна Дачин Тамсаг ХХК хооронд 2022 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр байгуулсан "Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх" нийгмийн хариуцлагын гэрээний хувьд Халх гол сумын нутаг дэвсгэрт сумын иргэдийн оршин суугаа орон сууцны барилгуудын сантехникийн шугам хоолойг шинэчлэх ажлын | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлэх хүрээнд холбогдох байгууллагатай хамтран ажиллах; | хүрээнд суурийн ажил бүрэн хийгдэж дууссан, дотоод холболтын ажил эхэлсэн байдалтай. Харин Ялалт багийн хүн эмнэлгийн болон багийн Засаг даргын ажлын албаны байрын барилгын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй энэ 10 сард ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байгаа талаар мэдээлэл ирүүлсэн . Мөн Ялалт багийн сургуулийн гадна дулаалгын хийж засварын ажлыг дуусгасан байна. Дорнод аймгийн Матад сумын иргэдийн хурлаас шийдвэрлэсний дагуу сум байгуулагдсаны ой болохтой холбоотойгоор тус сумын зүгээс наадмын талбай барьж байгуулах ажил эхлэлийн шатанд буюу холбогдох бараа материалаа Улаанбаатар хотоос татан авч байна. Мөн сумын хогийн цэгийн бүтээн байгуулалтын ажил болон төрийн албан хаагчийн орон сууцны барилгын ажил явагдаж байгаа бөгөөд 2022 оны 4 дүгээр улиралд сард багтаан Матад суманд хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн байна. Халхгол, Матад сумын удирдлагууд болон "Петрочайна дачин тамсаг" ХХК-тай хамтарсан уулзалтыг 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газар, "Петрочайна дачин тамсаг" ХХК, Халхгол сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, төлөөлөгч, Матад сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, төлөөлөгч нартай хамтран зохион байгуулж 2021, 2022 оны Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх гэрээг "Петрочайна дачин тамсаг" ХХК, Халхгол сумын Засаг дарга, Матад сумын Засаг дарга нар байгуулсан байна. | | |
| 109 | 7 | 22 | 1.12/. "Петрочайна Дачин Тамсаг" ХХК болон туслан гүйцэтгэгч компаниудад ажиллаж байгаа Монгол Улсын иргэдийн тоог нэмэгдүүлэх, сургах, дадлагажуулах, мэргэшүүлэх ажлыг холбогдох төрийн байгууллагатай хамтран зохион байгуулах. | "Петрочайна Дачин Тамсаг" ХХК нь Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран мэргэжлийн дипломтой ажилтан сонгон шалгаруулж ажилд авдаг. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг жилд 1-2 удаа зохион байгуулж, бүх ажилтнуудыг хамруулдаг. Туслан гүйцэтгэгч компанийн тухайд улирлын чанартай ажил гүйцэтгэдэг бол орон нутгаас хөдөлмөр зуучийн компаниар дамжуулан түр ажилд ажилтан авдаг бөгөөд тэдгээрт мэргэжлийн диплом шаардагдахгүй. Түр гэрээт монгол ажилчид цооног өрөмдлөг, перфораци, шингэн хагалбар, туршилт үйлчилгээний ажлуудад дагалдан хийх ба ажлын туршлага хуримтлуулж чадсан хүн дараа жил мөн ажлын байрандаа ажиллах боломж нээлттэй. 2022 оны 10 дугаар сарын байдлаар "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-д үндсэн 559 ажилчид, туслан гүйцэтгэгч ангиудад нийт 250 ажилчид ажиллаж байна. | 70% | |
| 110 | 7 | 23 | 3. Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай. | Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн нийгмийн даатгал, татварын асуудлаар болон газрын тосны нөөцийн талаарх танилцуулгыг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулан Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 03 дугаар тогтоол гаргуулсан. Уг тогтоолын хэрэгжилтийг 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр 01/2795 тоотоор ЗГХЭГ-т хүргүүлсэн. Мөн | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Тосон-Уул-19 болон Тамсаг-21 дүгээр талбайн БХГ хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх талаар Ерөнхий сайдын 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 78 дугаар захирамжийг Шадар сайд С.Амарсайханаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Ажлын дэд хэсэг 4 удаа хуралдсан бөгөөд ажлын дэд хэсгийн зарим гишүүд Дорнод аймгийн нутгийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, мөн Тосон-Уул-XIX, Тамсаг-XXI талбайд үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, бүтээгдэхүүн хуваах гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлыг судалсан. Ажлын дэд хэсэг гэрээлэгч компанийн үйл ажиллагааг сайжруулах, бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх, газрын тосны салбарыг цаашид хөгжүүлэх талаар авах арга хэмжээ гэсэн чиглэлээр нэгдсэн санал, дүгнэлтээ боловсруулж Шадар сайд Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Хуралдаанаас ажлын хэсгийн ажлын шуурхай авч хэрэгжүүлэх талаар үүрэг чиглэл өгөөд байна. 2022 оны 09 дүгээр сарын 21-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газар, Петрочайна дачин тамсаг ХХК, Халхгол сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, төлөөлөгч, Матад сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, төлөөлөгч нартай хамтарсан хурал зохион байгуулж 2021, 2022 оны Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх гэрээг байгуулсан. | | |
| 111 | 7 | 24 | 2. "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн 2014-2018 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг баталгаажуулах аудитыг нэн яаралтай дуусгаж, холбогдох Байнгын хороонд танилцуулахыг Үндэсний Аудитын газарт даалгасугай. | Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ний 2014-2018 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг баталгаажуулалт хийсэн аудитын тайланг 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр ирүүлээд байна. | 70% | |
| 112 | 7 | 25 | 1.2/. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг хийснээс хойших хугацаанд Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалт, үр ашиг, өгөөжийг тооцох, "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн үйл ажиллагаанд экспертийн дүгнэлт гаргах үүрэг бүхий холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан ажлын хэсгийг томилж, ажиллуулах; | Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 51 дүгээр тушаалаар дээрх ажлын хэсгийг мэдээллээр хангаж ажиллах ажлын дэд хэсгийг ХЗДХ-ийн дэд сайд Б.Солонгоор ахлуулан байгуулж ажиллаж байгаа бөгөөд Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөндлөнгийн мэргэшсэн байгууллагаар дүгнэлт, зөвлөмж гаргуулах, бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх талаар судалгаа хийн ажиллаж байна. | 100% | |

| 1.г. Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 113 | 1 | 1 | **Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай**<br>**2018-05-23**<br>**Дугаар 2018_46**<br>3. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | 3. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | 100% | |
| 114 | 2 | 2 | **Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/**<br>**2021-10-04**<br>**Дугаар 2021_58**<br>2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | 1. Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам, Үндэсний геологийн албаны албаны албан хаагчид Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн болон тус сарын аяны хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Баянзүрх дүүргийн Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 120 модыг ойн мэргэжлийн инженерийн заавар зөвлөмжийн дагуу тарьсан. 2. Ашигт малтмал, газрын тосны албан хаагчид "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн болон тус арын аяны хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Баянгол дүүргийн агропаркад 500 модыг ойн мэргэжлийн инженерийн заавар зөвлөмжийн дагуу тарьсан. 3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхлэгч 21 компани 608.5 сая мод тарихаа илэрхийлж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас батламж авсан. 4.Ашигт малтмал, газрын тосны газар нь Бүгд найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Уул уурхайн нөхөн сэргээлтийн корпорац болон худалдаа, хөрөнгө оруулалтын агентлагийн Монгол дахь салбартай хамтран 2022 оны 04 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд 680 сая мод тарихаа илэрхийлсэн, томоохон 30 компанийн мэргэжилтнүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын уул уурхайн нөхөн сэргээлтийн туршлага, ойжуулалт, мод тарих аргачлал, технологи сэдвийн хүрээнд сургалт, семинарыг зохион байгуулсан. | 100% | |
| 115 | 3 | 3 | **Засгийн газарт чиглэл өгөх тухай**<br>**2022-04-05**<br>**Дугаар 2022_43** | Уул уурхай хүнд үйлдвэрийн яам болон харьяа агентлаг, алба нь Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 1.4. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох; | авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох шийдвэрийг мөрдөж ажиллаж байна. | | |
| 116 | 3 | 4 | 2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай. | Салбарын хэмжээнд нийтийг хамарсан тэмдэглэлт арга хэмжээнд архи согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд нийгэм эдийн засгийн сөрөг үр дагаварыг бууруулах талаар дотооддоо сургалт сурталчилгааны ажлуудыг хийж байна. Албан хаагчдын эрүүл мэнд, хамт олны эв нэгдлийг дэмжих зорилгоор долоо хоног бүрийн нэг өдөр спортоор хичээллэх архи, согтууруулах ундаа хэрэглэхийн эсрэг спортыг дэмжиж ажиллаж байна. | 100% | |
| 117 | 4 | 5 | **Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159** 2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай. | Ерөнхийлөгчийн зарлигын дагуу байгууллага албан хаагчдад сурталчлан, уриалж ажиллаж байна. | 100% | |
| 118 | 4 | 6 | 4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эвээ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай. | Ерөнхийлөгчийн зарлигын дагуу байгууллага албан хаагчдад сурталчлан, уриалж ажиллаж байна. | 100% | |
| | | | 1.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | | | |
| 119 | 1 | 1 | **Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай 2010-03-18 Дугаар 2010_10/09** | УУХҮЯ нь 2020 онд яамны барилга байгууламжийн "Гамшгийн эрсдлийн үнэлгээ" зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт зарлаж Гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний үндэсний төв ТББ-аар эрсдлийн үнэлгээг хийлгэж зөвлөх үйлчилгээний тайланг хүлээн авсан. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2. Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн эрсдэлийн бодит байдлыг нийтэд таниулах, нийслэлийн орчмын бүс нутагт өндөр хурдны зам, эрчим хүчний шугам тавих замаар үйдвэр, үйлчилгээ, хүн амын суурьшлын шинэ төвүүдийг бий болгох, их, дээд сургуулийн хотхон байгуулах зэргээр төвлөрлийг задлах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, | | | |
| 120 | 2 | 2 | **Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40** 2.8. Уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, буруутай этгээдэд хариуцлага тооцох, учруулсан хохирлыг барагдуулах арга хэмжээ авах | Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5 дахь заалтад "тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан;" тохиолдолд Тусгай зөвшөөрлийг цуцлах тухай зохицуулалтыг Улсын Их Хурлын 2019.05.02-ны өдрийн чуулганы хуралдаанаар хэлэлцэж баталсан. Дээр дурдсан хуулийн заалтын дагуу 2019 онд Өмнөговь аймгийн Гурвантэс, Номгон, Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг дэвсгэрт нийт 20 аж ахуйн нэгжийн 25 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцалж, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг албадан гүйцэтгүүлэх, цаашид хууль бусаар алт олборлох зөрчил гарахаас сэргийлэх, хууль бусаар алт олборлогч нар талбайг ухахаас хамгаалах зорилгоор 2019.12.01-ний өдрийг хүртэл цагдаа болон мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтад авах шийдвэрийг гаргаж, хэрэгжүүлж ажилласан. 2019.08.23-ны өдрөөс 2019.12.01-ний өдрийг хүртэл Цагдаагийн Ерөнхий газрын Эргүүл тусгай хамгаалалтын тасгийн 160, Архангай аймаг дахь Цагдаагийн газрын 160 нийт 320 алба хаагчид 22 тээврийн хэрэгсэлтэй хамгаалалтыг авч хэрэгжүүлсэн. | 100% | |
| | | | | **1.е. Засгийн газрын тогтоол** | | |
| 121 | 1 | 1 | **"Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл" батлах тухай 2021-03-10 Дугаар 2021_58** 3. Энэ төсөлд хамрагдсан залуучуудыг ажлын байраар хангах талаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүтээн байгуулалтын болон бусад холбогдох төсөл, арга хэмжээний хүрээнд дэмжлэг үзүүлж | Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл"-д хамрагдсан залуучуудыг ажлын байраар хангах асуудлыг судалж, хамтран ажиллах албан хаагчийн нэр авахаар ХНХЯ-аас 2021.12.15-ны өдрийн 01/3340 дугаар албан бичгийг ирүүлсэн. Тус ажлыг хариуцан, хамтран ажиллах албан хаагчаар УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газрын Техник технологийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Хулангийн нэрийг 2021.12.21-ний өдрийн 01/3150 дугаартай албан бичгээр ХНХЯ-нд хүргүүлсэн. | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллахыг бүх Төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл болгосугай. | | | |
| 122 | 2 | 2 | **Нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын тухай 2021-04-28 Дугаар 2021_113** 1. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан Тавантолгойн ордод түшиглэсэн нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу 2021 оны III улиралд багтаан эхлүүлж, 2023 онд ашиглалтад оруулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ)-д тус тус даалгасугай. | Эрдэнэс Тавантолгой ХК "Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх" түлхүүр гардуулах нөхцөлтэй нээлттэй тендерийг 2022.01.28-ны өдөр дахин зарласан бөгөөд шалгаруулалтаар "Норинко Интернэшнл Күүперэшн" болон "Дади инженеринг девелопмент групп" компаниудын ирүүлсэн тендер хамгийн сайн үнэлэгдсэн тул 2022.04.14-нд EPC гэрээг байгуулсан. Ерөнхий гүйцэтгэгч болох Норинко Интернэшнл Күүперэшн" болон "Дади инженеринг девелопмент групп" компаниудын түншлэл давхар татвараас шалтгаалж манай улсад шууд үйл ажиллагаа явуулах боломжгүй байсан тул төлөөний газрыг 2022 оны 7 дугаар сарын 25-нд байгуулж албан ёсоор төслийн талбайд үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Төслийн талбай дээр барилга угсралтын ажлын бэлтгэл ажил хийгдэж дууссан. Төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай суурь судалгаа, дэд бүтцийн эх үүсвэр хангах /ус, цахилгаан/, бетон зуурмагын үйлдвэр барих, төслийн талбайн хашаа барих, ажилчдын түр кемп байгуулах зэрэг ажлуудыг бүрэн хийж дууссан. Ерөнхий төлөвлөгөө, загвар зургийг холбогдох газруудаар батлуулсан. Технологийн схемийг батлан, тоног төхөөрөмж, төмөр хийцийн бүтээцийн эхний багцуудын захиалгыг хийн, үйлдвэрлэлийг эхлүүлсэн бөгөөд 2023 оны эхний улиралд багтаан ирүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Төслийн явцыг хурдасгах зорилгоор зураг төслийн хэсэгчлэн боловсруулж байгаа бөгөөд түүхий нүүрсний агуулахын зураг төслийг батлуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлэн, бусад барилгын зураг төслийг хамтад нь 2023 оны 2 улиралд багтаан батлуулахаар ажиллаж байна. Гэрээний дагуу урьдчилгаа төлбөр болох гэрээний дүнгийн 10% буюу 95.6 тэрбум төгрөгийг Эрдэнэс Тавантолгой ХК олгосон. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 24.2%-тай хэрэгжиж байна. | 70% | |
| 123 | 3 | 3 | **Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай 2021-05-05 Дугаар 2021_129** 2. Энэ тогтоолын 1-д заасан үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааны хүрээнд "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр", "Исэлдсэн хүдрээс нуруулдан уусгах SX/EW технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр", "Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр" болон | Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь БНХАУ-ын "China ENFI Engineering" компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Тус ТЭЗҮ-д тооцсоноор төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 762,255.12 ам доллар байх бөгөөд үүний 30%-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгөөр, 70%-ийг зээлээр санхүүжүүлэхээр тусгасан.<br>Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захиалгаар "Майнинг Шорт Лонг Терм" ХХК-ийн боловсруулсан Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | "Засвар, механикийн заводын өргөтгөл"-ийг тус тус "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгөөр санхүүжүүлж, ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай. | байна. Хөрөнгө оруулалтын хэмжээ, эх үүсвэр нь тус ТЭЗҮ-ээр тодорхойлогдох юм.<br>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах уул уурхай, металлурги химийн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн ТЭЗҮ болон паркийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажилд 1590 сая, паркийн техник, технологийн түвшний үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний ажилд 450.9 сая, үйлдвэрлэл, технологийн паркийн нутаг дэвсгэрийн геоэкологи, гидрогеологийн суурь судалгааны ажилд 265.3 сая, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх ажилд 101.8 сая, автозамын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажилд 72.6 сая, төмөр замын нарийвчилсан зураг төсөл боловсруулахад 214.9 сая, ус хангамж, ариутгах татуургын нарийвчилсан зураг төсөл боловсруулахад 590.8 сая, цахилгаан хангамжийн ТЭЗҮ боловсруулахад 68 сая, диспетчерийн үндсэний төвөөр горимын тооцоо хийлгэхэд 29.7 сая, 3 ширхэг дэд станцын техникийн нөхцөл гаргуулах төлбөрт 4.5 сая, үйлдвэрлэл, технологийн парк тойруулан хашаа барих ажилд 1168.6 сая, зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулахад 3340.4 сая, ЗБХБҮ-ээс гарах хүхэрт хийнээс элементийн хүхэр ялган авах үйлдвэрлэлийн туршилтын ажилд 9999.7 сая, исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах SX-EW технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулахад 745.2 сая, нийт 17473,6 сая төгрөгийг "Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ"-ын хөрөнгөөр санхүүжүүлээд байна.<br>Үйлдвэрлэл, технологийн паркийн авто зам, төмөр зам барих, авто замын техник, технологийн хяналт, ус хангамж, ариутгах татуургын системийг барьж байгуулах, цахилгаан хангамжийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, дэд станц барьж байгуулах, аж үйлдвэрийн бүсэд мөрдөх агаарын чанарын стандартууд болон зэс хайлуулах үйлдвэрийн хаягдал утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын ялгарлын стандартуудыг боловсруулж, батлуулах, үйлдвэрлэл, технологийн парк тойруулан хашаа барих ажилд нийт 92583 сая төгрөг, Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах металлурги-химийн үйлдвэрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, үйлдвэрийн үндсэн болон нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах, үйлдвэрээс гарах хүхэрт хийнээс элементийн хүхэр ялган авах үйлдвэрлэлийн туршилтын ажил гүйцэтгэх, Фосфорын ордыг ашиглах ТЭЗҮ боловсруулах, үйлдвэрийн техник технологийн түвшний үнэлгээний ажилд нийт 29111.6 сая төгрөг, SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах, техник технологийн түвшний үнэлгээний ажилд нийт 1981.3 сая төгрөг зарцуулахаар Эрдэнэт | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | үйлдвэр ТӨҮГ-ын 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаад байна. | | |
| 124 | 4 | 4 | **Их, дээд сургуулийг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2021-10-20**<br>**Дугаар 2021_321**<br>4. "Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор"-ыг орон нутагт хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, сургалтын хөтөлбөрийн давхардлыг арилгах, тухайн орон нутгийн онцлог, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон хот, тосгоны батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төв, орон нутаг дахь их сургуулийн хотхоны техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, газар олголт, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Их, дээд сургуулийг "Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор" болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 321 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэгт нэр авахаар БШУЯ-наас 2021.11.29-ний өдрийн 1б/6140 дүгээр албан бичгийг ирүүлсэн. Тус ажлын хэсэгт УУХҮЯ-ны Статистик судалгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн А.Эрдэнэбат, Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Жадамба нарыг оролцуулахаар 2021.12.08-ны өдрийн 02/3044 дүгээр албан бичгийг БШУЯ-нд хүргүүлсэн. Тус яамнаас тодруулахад тогтоолын хэрэгжилтийг хангах холбогдох арга хэмжээ авч байгаа талаар мэдэгдсэн. | 30% | |
| 125 | 4 | 5 | 5. Энэ тогтоолын 1.1-д заасан төрийн өмчийн их, дээд сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг улсын төсвийн төсөлд тусгахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт, 1.2-т заасан Шинжлэх ухаан, технологийн сургуулийн харьяа | Их, дээд сургуулийг "Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор" болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 321 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэгт УУХҮЯ-наас төлөөлөл ажиллаж байна. Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн нар Их сургуулийн цогцолбор төсөл хамтран хэрэгжүүлэхээр харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зураад байна. Ингэснээр Ш.Отгонбилэгийн нэрэмжит Эрдэнэт цогцолбор дээд сургуулийг уул | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | сургууль байгуулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөв болон тухайн орон нутагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүрдүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймгийн Засаг дарга Р.Сэддорж нарт, 1.3-т заасан Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа "Эрдэнэт цогцолбор" дээд сургууль, Монгол Улсын Их сургуулийн бүрэлдэхүүн "Эрдэнэт" сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх болон нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүрдүүлэх зохих арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймгийн Засаг дарга С.Батжаргал, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ (Х.Бадамсүрэн) нарт тус тус даалгасугай. | уурхай технологийн чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх ажил хийгдэж, ШУТИС-ийн 3 хөтөлбөрийг Эрдэнэт цогцолбор дээд сургуульд нутагшуулж, тухайн 3 хөтөлбөрөөр мэргэжилтэн давхардуулан бэлтгэхгүй байх нөхцөл бүрдэж байна. | | |
| 126 | 5 | 6 | **Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7** 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; | Ажилтан албан хаагчдыг монгол бичиг бие даан сурах боломж нөхцөлийг бүрдүүлэхээр монгол бичгийн цахим хичээлийг дотоод сүлжээнд байршууллаа.Мөн байгууллагын гадна хаягыг шинэчлэн крилл монгол шинэ бичгээр хослуулан хийлгэсэн. Ашигт малтмал, газрын тосны газар нь: Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын гадна хаяг болон УУГТТЛ, АМГТГ-ын Төлөөлөгчийн газрын хаягийг тус бүр монгол бичиг болгож шинэчилсэн. Мөн удирдах албан тушаалтнууд өөрсдийн нэрийн хуудсаа монгол бичгээр шинэчлэн өөрчилж албан хэрэгцээндээ ашиглаж байна. 2023 оны 1 дүгээр сарын 16-аас эхлэн ажлын долоон өдөр 10:00-12:00 цаг хүртэл хурлын зааланд хэлтэс тус бүрийн тайлан төлөвлөгөө хариуцсан мэргэжилтнүүдийг монгол бичгийн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | | | |
| 127 | 6 | 7 | **Төмөр замын шугамын чиг тогтоох тухай**<br>**2022-01-19**<br>**Дугаар 2022_51**<br>2. Батлагдсан чигийн дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай болон давхацсан газрыг чөлөөлөх, шинээр газар олгохгүй байх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар нарт, төмөр замын чигтэй давхацсан нутаг дэвсгэрт газар чөлөөлөхөд шаардагдах хөрөнгийг төслийн нийт санхүүжилтэд оруулан тооцохыг "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Удаанжаргалд тус тус даалгасугай. | Төмөр замын батлагдсан чигийг Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын бүртгэлийн системд бүртгэсэнээр шинээр тусгай зөвшөөрөл олгохгүй байх нөхцлийг бүрдүүлсэн | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 128 | 7 | 8 | **Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламж барих зориулалтаар улсын хилийн зурвaст газар ашиглуулах тухай**<br>**2022-01-26**<br>**Дугаар 2022_53**<br>2. Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламж барих төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх, шаардлагатай хөрөнгө оруулалтыг газрын тос импортлогч аж ахуйн нэгжийн санхүүжилтээр шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгасугай. | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 53 дугаар тогтоолоор Газрын тосны бүтээгдэхүүний импортын олон талт эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Өмнөговь аймаг дахь Шивээхүрэн болон Гашуунсухайт боомт орчмын хилийн зурвас газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламж барих зориулалтаар газар ашиглахыг зөвшөөрч, газрын байршил, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицол, талбайг хэмжээг баталсан. Үүний дагуу тус 2 боомт орчмын хилийн зурвас газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламжийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮ-ийн сайдын 2022.04.05-ны өдрийн А/60 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгийн зохион байгуулсан сонгон шалгаруулалтад Шунхлай ХХК шалгарч, тус яамтай хамтран ажиллах тухай №21, №22 тоот гэрээг байгуулан үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Гэрээ байгуулж, үйл ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан Өмнөговь аймгийн Шивээхүрэн болон Гашуунсухайт боомтын хилийн зурвас дагуу шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламж барих үйл ажиллагааг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх тухай хүсэлтийг Засгийн газрын 2022 оны 53 дугаар тогтоолд хамтран ажиллахаар нэр дурдсан төрийн болон орон нутгийн холбогдох байгууллагуудад УУХҮ-ийн Сайдын 2022.05.30-ны өдрийн 01/1539 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Шалгарсан аж ахуйн нэгж төслийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. | 70% | |
| 129 | 8 | 9 | **Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай**<br>**2022-04-06**<br>**Дугаар 2022_139**<br>3. Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрт 2023 оноос эхлэн уг сургалтыг нэмж тусган батлуулах арга хэмжээ авахыг "Удирдлагын академи" төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т, сургалт зохион байгуулахтай холбоотой зардлыг "Удирдлагын академи"-ийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Б.Жавхланд, тус сургалтад хамруулах албан хаагчдынхаа зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай. | 2022 онд УУХҮЯ-наас Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургууль, Мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулсан 13 сэдвээр богино хугацааны сургалтад давхардсан тоогоор нийтдээ 93 албан хаагчийг хамруулсан сертификат авчээ. Үүнд: 1.Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт:-2 2.Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт:-2 3.Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт:-3 4.Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалт:-7 5.Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт-2 6.Жендерийн ахисан түвшний сургалт-1 7.Төрийн албан дахь харилцаа, маркетинг богино хугацааны зайн сургалт-1 8.Төсвийн хөрөнгө оруулалт: үр ашгийн болон эрсдлийн шинжилгээ сургалт-2 9.Их өгөгдлийг бодлогын шийдвэрт ашиглах нь сэдэвт сургалтад-1 10.Систем сэтгэлээ сэдэвт сургалт-2 11.Дизайн сэтгэлгээ сэдэвт сургалтад-2 12.Зан үйлийн нөлөөлөл сэдэвт сургалтад-2 13.Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат "Шинэ сэргэлтийн бодлого" сэдэвт сургалтад -66. 2023 онд баагдах сургалтын төлөвлөгөөнд санал хүргүүлж ажилласан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 130 | 9 | 10 | **Жагсаалт шинэчлэн батлах тухай 2022-05-31 Дугаар 2022_215** 2. “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг импортлох, экспортлох хилийн боомтын жагсаалт”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. 2. Хилийн зарим боомтоор шинээр тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг импортлох, экспортлох хэрэгцээ, шаардлагын талаарх мэдээллийг боомт бүрээр бэлтгэж, дипломат шугамаар хөрш улсуудтай харилцаж, хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэхийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт тус тус үүрэг болгосугай. | Хилийн зарим боомтыг шинээр нээснээр тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн импортын урсгалыг нэмэгдүүлж, үүсээд байсан хомсдолыг хэвийн болгон тогтворжуулсан. Тухайбал Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор тэсрэх материалын импортыг хийх үйл ажиллагаа явагдаж байна. БНХАУ-ын талаас тэсрэх бодис импортоор авах асуудлаар БНХАУ-д суугаа Элчин сайдтай 2022.10.27-ны өдөр цахим уулзалт хийсэн. Мөн Ховд аймгийн засаг дарга БНХАУ-ын талтай Булганы боомтоор тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг импортлох асуудлаар 2022.11.07-ны өдөр харилцан тохиролцсон. | 70% | |
| 131 | 10 | 11 | **“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-06-08 Дугаар 2022_229** 1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн Онч хараат, Оорцог, Бортолгой хэсэгт хайгуул-судалгааны ажил гүйцэтгэж нөөцийг тогтоосны үндсэн дээр ил болон далд уурхайг нээж олборлолт эхлүүлэх, ордын хэмжээнд конвейерийн систем нэвтрүүлж өртөг зардлыг бууруулах арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хулан, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар) нарт тус тус даалгасугай. | Эрдэнэс Тавантолгой ХК нь урьдчилсан хайгуулын ажлын үр дүнд үндэслэн Ончхараат, Оорцог, Бортолгойн хэсгийг нээж олборлолтыг эхлүүлэх хугацааг тодорхойлж, олборлох нүүрсний хэмжээг компанийн урт хугацааны төлөвлөгөөнд тусгасан байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны Н-01 дугаар тушаалд үндэслэн Тавантолгойн ордын Бортолгой, Оорцог, Ончхараатын хэсэгт хөрөнгө оруулах замаар хамтран ажиллах компани (консорциум)-ийг сонгох сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг /УУХҮЯамны төлөөлөл оролцсон/ байгуулагдсан. Тус ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын баримт бичгийг Монгол болон Англи хэл дээр боловсруулсан. “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Евроашиан майнинг контрактор” ХХК-тай хамтран өмнөх жилүүдэд хийж гүйцэтгэсэн геологи, хайгуулын үр дүнг нэгтгэж урьдчилсан үнэлгээний ажил гүйцэтгэсэн. Хайгуул, судалгааны ажлын техникийн тодорхойлолт, ажлын даалгавар тендерийн баримт материалыг боловсруулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байна. "Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгой чулуун нүүрсний бүлэг ордын ил уурхайн хөрс, нүүрс тээвэрт Авто-конвейерийн хосолсон тээвэр бүхий мөчлөг-урсгал технологи нэвтрүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэл"-ийг боловсруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/249 дугаар тушаалаар "Санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчдийн ажлын хэсэг"-ийг байгуулсан байна. 2022-2025 оны хугацаанд нүүрсний уурхайн парк шинэчлэлийн хүрээнд, өөрөө олборлогч болохын тулд худалдан авах нийт техникүүдийн худалдан авалтын үйл | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллагааг зохион байгуулж техникүүдийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 14 багцаас 10 багцыг сонгон шалгаруулж гэрээг байгуулсан. | | |
| 132 | 10 | 12 | 2. Шинээр нээх уурхайн санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, эдийн засгийн хувьд хэмнэлттэй шинэ дэвшилтэт техник, технологи бүхий гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах замаар бүрдүүлэх арга хэмжээ авахыг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хулан, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт тус тус даалгасугай. | Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022.08.29-ний өдрийн А/529 тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. 2022.09.01-ний өдөр Олон улсын болон дотоодын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласан ба урилгад заасан хугацаанд 16 оролцогч хүсэлтээ ирүүлж, сонгон шалгаруулалтын баримт бичгийн төлбөр төлсөн 12 оролцогчдод шалгаруулалтын баримт бичиг, геологийн мэдээлэл танилцуулж өгсөн. 2022.10.31-ний өдрийн 10 цагт оролцогч нарын ирүүлсэн санал бүхий баримт бичгийг хүлээн авч хөрөнгө оруулж, хамтран ажиллах хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажил эхэлнэ. | 70% | |
| 133 | 11 | 13 | **Хөрөнгө гаргах тухай**<br>**2022-07-27**<br>**Дугаар 2022_288**<br>1. Намрын ургац хураалт, уринш боловсруулалтын ажлыг хугацаанд нь чанартай зохион байгуулахад шаардагдах дизель түлшний үнийг хаврын тариалалтын үеийн үнэтэй ижил түвшинд байхаар тооцож, зөрүүг аж ахуйн нэгжид олгох зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай. | 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/270 болон А/240 тоот Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар "Намрын ургац хураалт, уриншийн эцсийн боловсруулалтад шаардагдах дизель түлшний үнийн зөрүү төлбөрийг олгох нөхцөлийг" баталсан. Уг тушаалын хүрээнд холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. | 70% | |
| 134 | 12 | 14 | **Албан татвар хэсэгчлэн төлүүлэх тухай**<br>**2022-09-05**<br>**Дугаар 2022_335**<br>2. Шивээхүрэн хилийн боомтын чингэлэгт тээврийн терминалын төслийн бүтээн байгуулалтын ажилд зориулан импортоор оруулж ирэх техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэл ногдуулах гаалийн болон | Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Сангийн яамнаас 2022.10.19-ний өдрийн 03/7134 дугээр албан бичгээр "Шивээхүрэн терминал" ХХК-тай байгуулах гэрээний төсөл, холбогдох саналыг ирүүлэх тухай албан бичгийг тус яаманд ирүүлээд байгааг "Шивээхүрэн терминал" ХХК-д хүргүүлсэн. | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэхийг Сангийн сайд Б.Жавхланд зөвшөөрсүгэй. 2. Энэ тогтоолын 1-д заасан төслийг хэрэгжүүлж байгаа "Шивээхүрэн терминал" ХХК-тай гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн нарт тус тус даалгасугай. | | | |
| 135 | 13 | 15 | **Бүтээгдэхүүн хуваах гэрээ цуцлах эрх олгох тухай**<br>**2022-09-05**<br>**Дугаар 2022_337**<br>4. Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцлах ажлыг зохион байгуулж төлбөрийн үлдэгдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал)-т, бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцлахтай холбогдсон үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт тус тус даалгасугай. | Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 337 дугаар тогтоол гарсныг үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/109 дүгээр тушаалаар "Ренова-Илч" ХХК-ийн газрын тосны хайгуулын Хар-Ус II, "Өмнөд Монголын газар нутгийн тос" ХХК-ийн газрын тосны хайгуулын Номгон-IX , "Монголиа Шин ий энержи" ХХК-ийн газрын тосны хайгуулын Дарьганга-XXIV, "Хонгконг Велпек Индастриал" ХХК-ийн газрын тосны хайгуулын Хэрлэн тохой-XXVIII талбайнуудын бүтээгдэхүүн хуваах гэрээг тус тус цуцалж, Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг цуцалсантай холбогдуулан, Гэрээлэгчдийн гэрээгээр хүлээсэн төлбөрийн үлдэгдэлтэй холбогдсон асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга (Б.Дашпүрэв), Хууль эрх зүйн хэлтэс (Р.Энхтайван)-д үүрэг болгосон. Дээрх 4 талбайн БХГ-г цуцалсан талаарх мэдэгдлийг гэрээлэгч нарт 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 1/5166 албан тоотоор хүргүүлсэн. Тус 4 талбайн БХГ-ний дагуу төлөх төлбөр, урамшууллын үлдэгдлийг төлүүлэхээр харьяалах шатны шүүхийн байгууллагад хандаад байсан бөгөөд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх явц дараах байдалтай байна. Үүнд: - "Ренова илч" ХХК: 2020.12.31 өдөр Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд Иргэний хуулийн 227.1, Газрын тосны тухай хуулийн 43.1, БХГ-ний 22.1-д заасны дагуу "Ренова-илч" ХХК нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйн улмаас учирсан хохирлыг нэхэмжилж гомдол гаргасан. Хэрэг хянан шийдвэрлэгдэх шатандаа байна. - "Өмнөд Монголын газрын тос" ХХК: 2020.12.24-ний өдөр Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд Иргэний хуулийн 227.1, Газрын тосны тухай хуулийн 43.1, БХГ-ний 22.1-д заасны дагуу "Өмнөд Монголын газар нутгийн тос" ХХК нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйн улмаас учирсан хохирлыг нэхэмжилж гомдол гаргасан. Хэрэг хянан шийдвэрлэгдэх шатандаа байна. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 136 | 14 | 16 | **Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340** 3. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэлээр шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулж, хэлэлцүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгасугай. | ЗГ-ын 220 оны 340 дүгээр тогтоолын 2 дугаар заалттай холбогдуулан "Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний мэдээлэл" ирүүлэх тухай албан бичгийг 2022.10.12-ны өдрийн 09/2698 дугаар албан бичгээр АМГТГ, ҮГА болон дотоод албан бичгээр яамны газруудаас санал авсан. Уг тогтоолын 2 дугаар заалттай холбоотой салбарын хэмжээнд хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиг үүрэг, ажил үйлчилгээний мэдээлэлд хүргүүлэх саналгүй болохыг Сайдын 2022.10.14-ний өдрийн 01/2727 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100% | |
| 137 | 15 | 17 | **Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах тухай 2022-09-14 Дугаар 2022_349** 4. Энэ тогтоолын хэрэгжилтийг шуурхай удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга бөгөөд Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын үүрэг хариуцагч Д.Амарбаясгалан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт тус тус үүрэг болгосугай. | Тус яамнаас 2022.09.02-ны өдрийн 01/2356 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд "Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд санал хүргүүлсэн. | 70% | |
| 138 | 16 | 18 | **Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2022-10-05 Дугаар 2022_362** 2. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон экспортлох эрх бүхий төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар Монгол Улсын гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай Засгийн Газрын 2022 оны 362 дугаар тогтоолл тусгагдсан уул уурхайн биржийн тогтолцооны нэгдсэн цахим системийг нэвтрүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг уул уурхайн биржийн үйл ажиллагаа явуулах боломжтой аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлтэй уулзалт хийж нэвтрүүлэх цахим системүүдтэй танилцсан. Аж ахуйн нэгжүүдтэй хийсэн уулзалт, цахим системийн боломжийн талаар Төрийн нарийн бичгийн даргад танилцуулж улмаар ЗГ-ын хуралдаанд мэдээлэл хийсэн. Ажлын хэсэг | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | этгээдийн гүйцэтгэх удирдлагыг томилох эрх бүхий этгээд, Төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд, гүйцэтгэх удирдлагад тус тус даалгаж, орон нутгийн өмч давамгайлсан эрх бүхий этгээдэд зөвлөсүгэй. 2.1. Засгийн газрын шийдвэргүйгээр төлбөрийг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөлтэй /off-take/ бүх төрлийн шинэ гэрээ байгуулахыг зогсоох; 2.2. Төлбөрийг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөлтэй /off-take/ болон төлбөрийг урьдчилан авч ашигласан гэрээний дагуу, эсхүл төлбөр нь нэн даруй хийгдэх ашигт малтмалын экспортыг валютын бодит орох урсгалыг нэмэгдүүлэхээр оновчтой зохион байгуулах; 2.3. Ашигт малтмалын борлуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбоотой албаны болон байгууллагын нууцад хамааралтай гэрээ, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг 2022 оны 11 дүгээр сард багтаан нууцаас гаргаж, ил тод болгох арга хэмжээ авах, цаашид нууц гэрээ байгуулахгүй байх. | уул уурхайн бүтээгдэхүүнийг цахимаар нээлттэй арилжих түр журмын төслийг боловсруулсан бөгөөд "Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам"-ыг боловсруулж бусад яамд болон холбогдох бусад байгууллагаас санал авахаар 2022.12.01-ний өдөр 01/3180 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Тус албан бичигтэй холбогдуулан яам болон холбогдох бусад байгууллагаас ирсэн албан бичгүүдийг нэгтэн, журмын төсөлд тусган Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 466 дугаар тогтоолоор журам батлагдсан. | | |
| 139 | 16 | 19 | 4. "Оюутолгой" ХХК, "Энержи Ресурс" ХХК, "Монголын алт" ХХК, "МоЭнко" ХХК зэрэг ашигт малтмал олборлолтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын экспортын үйл ажиллагаатай холбоотой гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлж, валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай. | Тус яаманд Оюутолгой ХХК-иас БНХАУ-ын Ганцмодны боомтын зэсийн баяжмал тээврийн жолооч нараас 72 цаг тутамд 1 ПСР шинжилгээ авч байгааг 48 цаг болгох асуудлаар тус улсын талтай тохиролцсон тохиолдолд зэсийн баяжмалын экспортын хэмжээг 30 орчим хувиар нэмэгдүүлэх санал ирүүлснийг Боомтын сэргэлтийн үндэсний хороонд 2022.11.18-ны өдрийн 02/3051 дүгээр албан бичгээр уламжилсан. Үүний дагуу Хөххот дахь ЕКГ-аас Баяннуур хотын Гадаад харилцаа боомтын алба, Ганцмод боомтын зөвлөлийн удирдлагатай утсаар холбогдож нөхцөл байдлыг тодруулан үүсээд буй Оюу толгой компанийн тээврийн жолооч нараас Хятадын талд авах 72 цагийн ПГУ шинжилгээг 48 цагийн ПГУ горимд шилжүүлэх талаар хүсэлт тавьсан. Ганцмод боомтын зөвлөлөөс асуудлыг судалж, тээврийн жолооч нараас 48 цагийн ПГУ шинжилгээний горимд шилжүүлсэн талаар бидэнд мэдэгдсэн бөгөөд 150 жолоочийг 3 ээлжээр буюу эхний өдөр Монголын талд хоёр дахь өдөр Хятадын талд, гуравдахь өдөр хил нэвтрэн тээвэр хийж, уг өдрөө Монголын талд шинжилгээнд орох | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | байдлаар тээврийн тасралтгүй зохион байгуулалтыг хэрэгжүүлэх боломжтой болсон. 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд нийт 1,443.0 мян.тн зэсийн баяжмал экспортод гаргасан нь 119.0%-ийн гүйцэтгэлтэй байна. БНХАУ-ын Шивээхүрэн боомтын талд байгаа экспортод гаргасан нүүрсийг татан авах асуудлаар тус улсын талтай харилцан тохиролцох тухай Монголын алт (МАК) ХХК-иас тус яаманд ирүүлсэн саналыг Боомтын сэргэлтийн үндэсний хороонд 2022.11.18-ны өдрийн 02/3051 дүгээр албан бичгээр уламжилсан. 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд нийт 31.4 сая.тн нүүрс экспортод гаргасан нь 174.5%-ийн гүйцэтгэлтэй байна. | | |
| 140 | 16 | 20 | 5. Ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд ашигт малтмалыг уурхайн ам нөхцөлөөр борлуулах шинэ гэрээ байгуулахыг зогсоож, хилийн үнээр худалдан борлуулах, байнгын ачаа тээврийн хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийг олгох эрхийг олборлолтын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт даалгасугай. | Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-аас Тавантолгой ХК, Эрдэнэс Тавантолгой ХК, Энержи ресурс ХХК хооронд хамтран ажиллах гэрээний төслийг бэлтгэж, тус компаниудад хүргүүлсэн. Улмаар Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-аас аж ахуйн нэгжүүдэд хил нэвтрэх олон улсын С төрлийн бичгийг олгох эрхийг шилжүүлсэн. Эрдэнэс Тавантолгой ХК нүүрс тээврийн нээлттэй тендерийг 2022.12.19-ний өдөр зарласан бөгөөд 2023.01.18-ны өдөр тендерийг нээхээр төлөвлөж байна | 100% | |
| 141 | 16 | 21 | 6. Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэж байгаа ашигт малтмалын олборлолт, боловсруулалт, тээвэрлэлт зэрэг бүхий л үйл ажиллагааны төлбөрийг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх, үргэлжлэн хэрэгжиж буй гэрээг 2022 онд багтаан шинэчлэх арга хэмжээ авахыг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон экспортлох эрх бүхий аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгож, “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай” хуулийн хэрэгжилтийг хангах талаар Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллаж зохих арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, | Эдийн засаг, хөгжлийн дэд сайдын ахалсан Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Ажлын хэсэгт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ажиллаж байна Тус яамнаас Монголбанк, Ашигт малтмал, газрын тосны газар, Оюутолгой ХХК, Энержи ресурс ХХК, Монголын алт (МАК) ХХК, МонЭнко ХХК, Өсөх зоос ХХК, Хүрэн толгой коал майнинг ХХК, Саусгоби сэндс ХХК, Терра энержи ХХК зэрэг байгууллагуудын төлөөллийг оролцуулсан санал солилцох уулзалтыг 2022 оны 10 дугаар сарын 31, 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд аж ахуйн нэгжүүдийн гэрээт ажлын төлбөрийг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх чиглэлийг өгсөн. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт даалгасугай. | | |
| 142 | 16 | 22 | 7. Ашигт малтмалыг нээлттэй дуудлага худалдаагаар борлуулах уул уурхайн биржийн тогтолцооны нэгдсэн цахим системийг бий болгох эрх зүйн үндсийг бүрдүүлсний үндсэн дээр 2023 оны 1 дүгээр улиралд багтаан нэвтрүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт даалгасугай. | Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журмыг боловсруулж, Засгийн газрын 2022.12.14-ны өдрийн 466 дугаар тогтоолоор батлуулсан. Тогтоол гарсантай холбогдуулан журмын хэрэгжилтийг хангах зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.12.16-ны өдрийн А/305 дугаар тушаалаар өмнөх А/281 дүгээр тушаалыг шинэчлэн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинээр зохион байгуулж томилсон. Шинээр байгуулагдсан ажлын хэсэг цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. | 100% | |
| 143 | 16 | 23 | 11. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, хэрэгжилтийн явц, тайлан, мэдээг 7 хоног тутам Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай. | Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Наранцогтоор ахлуулсан Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Ажлын хэсэгт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ажиллаж байна. Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд 7 хоног бүрийн мягмар гарагт тогтоолын хэрэгжилтийг гаргаж, Эдийн засаг, хөгжлийн яаманд цахимаар хүргүүлж байна. | 100% | |
| 144 | 17 | 24 | **Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц тогтоох тухай 2022-10-19 Дугаар 2022_378** 2. Энэ тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг 2023 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал)-т тус тус даалгасугай. | Тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг бүрдүүлэх үүднээс тогтоолд нэр дурдсан аж ахуйн нэгж тус бүртэй гэрээ байгуулах ажлыг АМГТГ хариуцан гүйцэтгэж байна. 2023 оны 01 сарын 10-ны өдрийн байдлаар А 80 автобензин 37 хоног, Аи 92 автобензин 29 хоног, Аи 95 автобензин 31 хоног, дизель түлш 21 хоног, ТС-1 онгоцны түлш 30 хоногийн ердийн хэрэглээтэй тэнцэх үлдэгдэл, нөөцтэй байна. Хангамж, нийлүүлэлт тогтвортой байна. | 100% | |
| 145 | 18 | 25 | **Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц тогтоох тухай 2022-10-19 Дугаар 2022_378** 2. Энэ тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг 2023 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд | Жил бүрийн 8-10 дугаар сард дараа жил бүрдүүлэх газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийн хэмжээг шинэчлэн тогтоодог бөгөөд энэхүү тогтоолд 2023 онд нөөц бүрдүүлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан. Тогтоолд хамрагдсан ААН-үүдтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулах ажлыг АМГТГ хариуцан гүйцэтгэж байгаа бөгөөд газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэлт, хангамж нийлүүлэлтийн тогтвортой байдалд тухай бүр хяналт тавих, шаардлагатай тохиолдолд зохицуулалтын арга хэмжээ авах ажлыг АМГТГ-тай хамтран зохион байгуулж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал)-т тус тус даалгасугай. | | | |
| 146 | 19 | 26 | **Ашигт малтмал хайх талбайн солбицол батлах, эрх олгох тухай** **2022-10-19** **Дугаар 2022_379** 2. Энэ тогтоолын хавсралтад заасан Эрдэнэтийн стратегийн ордын талбайд ашигт малтмал хайх эрхийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-т олгох арга хэмжээг авч, ашигт малтмалын кадастрын зураг зүйн бүртгэл, мэдээллийн санд бүртгэхийг Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал)-т үүрэг болгосугай. 3. Ашигт малтмал хайх ажлыг гүйцэтгэх төрийн өмчит хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Орхон, Булган аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Ашигт малтмал, газрын тосны газраас 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр дараах хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгосон. Үүнд: 1. XV-022166 дугаартай "Хужир" нэртэй 62520.16 гектар 2. XV-022167 дугаартай "Хөх асгат" нэртэй 7521.09 гектар 3. XV-022168 дугаартай "Согоот" нэртэй 4016.87 гектар 4. XV-022169 дугаартай "Зөөхийн гол" нэртэй 3009.44 гектар 5. XV-022170 дугаартай "Ундрах" нэртэй 21451.23 гектар 6. XV-022171 дугаартай "Оюут" нэртэй 1032.75 гектар тус тус талбайнууд. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар Эрдэнэт үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцах албан томилолтын үеэр буюу 2022.11.11-ний өдөр дээрх тусгай зөвшөөрлүүдийг ерөнхий захирал Г.Ёндонд хүлээлгэн өгсөн. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ТЗ-ийг хүлээн авснаас 30 хоногийн дотор хайгуулын ажлын төлөвлөгөөг АМГТГ-аар хянуулан 2023 оноос хайгуулын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан. | 100% | |
| 147 | 20 | 27 | **Ашигт малтмал хайх талбайн солбицол батлах, эрх олгох тухай** **2022-10-19** **Дугаар 2022_379** 2. Орхон, Булган аймгийн нутагт ашигт малтмал хайх талбайн солбицлыг хавсралт ёсоор баталсугай. 2. Энэ тогтоолын хавсралтад заасан Эрдэнэтийн стратегийн ордын талбайд ашигт малтмал хайх эрхийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-т олгох арга хэмжээг авч, ашигт малтмалын кадастрын зураг зүйн бүртгэл, мэдээллийн санд бүртгэхийг Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал)-т үүрэг болгосугай. | Ашигт малтмал, газрын тосны газраас 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр дараах хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгосон. Үүнд: 1. XV-022166 дугаартай "Хужир" нэртэй 62520.16 гектар 2. XV-022167 дугаартай "Хөх асгат" нэртэй 7521.09 гектар 3. XV-022168 дугаартай "Согоот" нэртэй 4016.87 гектар 4. XV-022169 дугаартай "Зөөхийн гол" нэртэй 3009.44 гектар 5. XV-022170 дугаартай "Ундрах" нэртэй 21451.23 гектар 6. XV-022171 дугаартай "Оюут" нэртэй 1032.75 гектар тус тус талбайнууд. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар Эрдэнэт үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцах албан томилолтын үеэр буюу 2022.11.11-ний өдөр дээрх тусгай зөвшөөрлүүдийг ерөнхий захирал Г.Ёндонд хүлээлгэн өгсөн. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ТЗ-ийг хүлээн авснаас 30 хоногийн дотор хайгуулын ажлын төлөвлөгөөг АМГТГ-аар хянуулан 2023 оноос хайгуулын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 148 | 20 | 28 | 3. Ашигт малтмал хайх ажлыг гүйцэтгэх төрийн өмчит хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Орхон, Булган аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар Эрдэнэт үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцах албан томилолтын үеэр буюу 2022.11.11-ний өдөр дээрх тусгай зөвшөөрлүүдийг ерөнхий захирал Г.Ёндонд хүлээлгэн өгсөн. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ТЗ-ийг хүлээн авснаас 30 хоногийн дотор хайгуулын ажлын төлөвлөгөөг АМГТГ-аар хянуулан 2023 оноос хайгуулын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан. | 100% | |
| 149 | 21 | 29 | **"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-10-26 Дугаар 2022_385**<br>3. 3. Онцгой дэглэмийн хугацаанд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааны хэвийн нөхцөл байдлыг бүрэн хангаж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараахь албан тушаалтанд даалгасугай: 3.1. компанийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тогтоож, шинэчлэх, шаардлагатай бол нэгжийн удирдлага, холбогдох албан тушаалтныг томилж, чөлөөлөхийг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатад; 3.2. компанийн хөдөлмөрийн болон үйлдвэрлэл, технологийн тухайлсан дүрэм, үйлдвэрлэлийн аюул осолгүй ажиллагааны тусгай журам тогтоож, тэдгээрийг зөрчигчдөд зохих хариуцлага хүлээлгэж ажиллахыг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатад; 3.3. Тавантолгой нүүрсний ордоос нүүрс ачих, тээвэрлэх, худалдан борлуулах, хил нэвтрүүлэх бүхий л үе шатанд хяналтыг сайжруулах шаардлагатай арга хэмжээг тухай бүрд нь авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатад, энэ чиглэлээр бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллахыг Засгийн | 3.1 Эрдэнэс Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022.10.26-ны өдрийн 385 дугаар тогтоолын 2, 3.1-т заасны дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн бүтцээс 14 нэгж /алба/-ийг татан буулгаж, нийт 53 ажилтныг үүрэгт ажлаас чөлөөлж орон тоог бууруулсан байна.<br>3.2 Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн 2022.11.02-ны өдрийн "Хариуцлагыг сайжруулж ажиллах тухай" А/683 дугаар тушаалыг батлан Эрдэнэс тавантолгой ХК-д мөрдүүлж, үйлдвэрлэл болон нүүрс ачилтын хэвийн үйл ажиллагааг хангах, экспортын орлогыг нэмэгдүүлэх, сахилга хариуцлагыг чангаруулах төлөвлөгөө гарган ажиллаж байна. Мөн онцгой дэглэмийн хугацаанд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хөдөлмөрийн зохион байгуулалтын дотоод журмыг батлуулахаар ажиллаж байна.<br>Тавантолгойн уурхайд Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатын "Хариуцлагыг сайжруулж ажиллах тухай" А/683 тоот тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд Онцгой дэглэмийн үед салбарын үйл ажиллагааны тасралтгүй, аюулгүй байдлыг хангах, сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор "Онцгой дэглэмийн үед ажиллах журам"-ыг батлан гаргаж мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн Салбарын захирлын 2022.10.31-ний өдрийн А/83 тоот "Онцгой дэглэмийн хугацаанд сахилга батыг өндөржүүлэх тухай" тушаалыг гаргаж, хэрэгжүүлж байна.<br>3.3.Компанийн хувьд Онцгой дэглэмийн үед олборлолт, борлуулалт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг саадгүй явуулахад шаардлагатай хүний нөөцийн арга хэмжээг авч ажилласан. Өнөөдрийн байдлаар хоногт дунджаар 1100 орчим тээврийн хэрэгслээр 120 мянга орчим тонн нүүрс ачиж, олборлолт, борлуулалтыг 2 дахин, тээвэрлэлтийг 3-4 дахин нэмэгдүүлсэн. 2022 онд 11.2 сая тонн нүүрс олборлож төлөвлөгөөгөө давуулан биелүүлж борлуулалтын орлогыг 1.1 тэрбум ам.долларт хүргэсэн.<br>Нүүрс олборлохоос экспортлох бүх үе шатыг олон нийтэд нээлттэй, ил тод болгон байгууллагын албан ёсны цахим хуудас /www.ett.mn/-т байршуулж, улсын төсөвт төвлөрүүлэх татвар, хураамжийг 1.5 дахин буюу 410 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн.<br>3.4 Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.12.16-ны өдрийн А/306 тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн ажиллах удирдамжийн | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | газрын холбогдох гишүүдэд; 3.4. компанийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагаанд санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт; 3.5. "Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 362 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатад. | хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2022.12.20-ны өдрийн А/122 тоот тушаалаар "Эрдэнэс тавантолгой" ХК болон "Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагааг газар дээр нь танилцаж, жил бүрийн ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлангаар ирүүлсэн мэдээ, мэдээлэл үндэслэлтэй эсэхийг нягталж, дүгнэл гаргаж, цаашид авах арга хэмжээний саналаа нэгтгэн ажлын хэсгийн тайлан, танилцуулга бэлтгэн Сайдад 2022.12.30-ны өдөр танилцуулсан. | | |
| 150 | 22 | 30 | **"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-10-26 Дугаар 2022_385** 3. 3. Онцгой дэглэмийн хугацаанд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааны хэвийн нөхцөл байдлыг бүрэн хангаж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараахь албан тушаалтанд даалгасугай: 3.1. компанийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тогтоож, шинэчлэх, шаардлагатай бол нэгжийн удирдлага, холбогдох албан тушаалтныг томилж, чөлөөлөхийг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатад; 3.2. компанийн хөдөлмөрийн болон үйлдвэрлэл, технологийн тухайлсан дүрэм, үйлдвэрлэлийн аюул осолгүй ажиллагааны тусгай журам тогтоож, | 3.1 Эрдэнэс Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022.10.26-ны өдрийн 385 дугаар тогтоолын 2, 3.1-т заасны дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн бүтцээс 14 нэгж /алба/-ийг татан буулгаж, нийт 53 ажилтныг үүрэгт ажлаас чөлөөлж орон тоог бууруулсан байна.<br>3.2 Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн 2022.11.02-ны өдрийн "Хариуцлагыг сайжруулж ажиллах тухай" А/683 дугаар тушаалыг батлан Эрдэнэс тавантолгой ХК-д мөрдүүлж, үйлдвэрлэл болон нүүрс ачилтын хэвийн үйл ажиллагааг хангах, экспортын орлогыг нэмэгдүүлэх, сахилга хариуцлагыг чангаруулах төлөвлөгөө гарган ажиллаж байна. Мөн онцгой дэглэмийн хугацаанд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хөдөлмөрийн зохион байгуулалтын дотоод журмыг батлуулахаар ажиллаж байна.<br>Тавантолгойн уурхайд Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатын "Хариуцлагыг сайжруулж ажиллах тухай" А/683 тоот тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд Онцгой дэглэмийн үед салбарын үйл ажиллагааны тасралтгүй, аюулгүй байдлыг хангах, сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор "Онцгой дэглэмийн үед ажиллах журам"-ыг батлан гаргаж мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн Салбарын захирлын 2022.10.31-ний өдрийн А/83 тоот "Онцгой дэглэмийн хугацаанд сахилга батыг өндөржүүлэх тухай" тушаалыг гаргаж, хэрэгжүүлж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тэдгээрийг зөрчигчдөд зохих хариуцлага хүлээлгэж ажиллахыг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатад; 3.3. Тавантолгой нүүрсний ордоос нүүрс ачих, тээвэрлэх, худалдан борлуулах, хил нэвтрүүлэх бүхий л үе шатанд хяналтыг сайжруулах шаардлагатай арга хэмжээг тухай бүрд нь авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатад, энэ чиглэлээр бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд; 3.4. компанийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагаанд санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт; 3.5. "Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 362 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатад. | 3.3.Компанийн хувьд Онцгой дэглэмийн үед олборлолт, борлуулалт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг саадгүй явуулахад шаардлагатай хүний нөөцийн арга хэмжээг авч ажилласан. Өнөөдрийн байдлаар хоногт дунджаар 1100 орчим тээврийн хэрэгслээр 120 мянга орчим тонн нүүрс ачиж, олборлолт, борлуулалтыг 2 дахин, тээвэрлэлтийг 3-4 дахин нэмэгдүүлсэн. 2022 онд 11.2 сая тонн нүүрс олборлож төлөвлөгөөгөө давуулан биелүүлж борлуулалтын орлогыг 1.1 тэрбум ам.долларт хүргэсэн.<br>Нүүрс олборлохоос экспортлох бүх үе шатыг олон нийтэд нээлттэй, ил тод болгон байгууллагын албан ёсны цахим хуудас /www.ett.mn/-т байршуулж, улсын төсөвт төвлөрүүлэх татвар, хураамжийг 1.5 дахин буюу 410 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн.<br>3.4 Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.12.16-ны өдрийн А/306 тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн ажиллах удирдамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2022.12.20-ны өдрийн А/122 тоот тушаалаар "Эрдэнэс тавантолгой" ХК болон "Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагааг газар дээр нь танилцаж, жил бүрийн ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлангаар ирүүлсэн мэдээ, мэдээлэл үндэслэлтэй эсэхийг нягталж, дүгнэл гаргаж, цаашид авах арга хэмжээний саналаа нэгтгэн ажлын хэсгийн тайлан, танилцуулга бэлтгэн Сайдад 2022.12.30-ны өдөр танилцуулсан. | | |
| 151 | 23 | 31 | **Журам батлах тухай**<br>**2022-11-16**<br>**Дугаар 2022_406**<br>2. "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сан хөтлөх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай. 2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд оролцогч хуулийн | Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд тус яамны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, зориулалтын тоног төхөөрөмж, мэргэжлийн ажиллах хүчний тооллого хийх арга хэмжээг тусгасан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | этгээдийн тэсрэх материалын үйлдвэр, агуулахад хадгалагдаж байгаа тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, зориулалтын тоног төхөөрөмж, мэргэжлийн ажиллах хүчинд тооллого явуулж, шинэчилсэн бүртгэл хийхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт үүрэг болгосугай. 3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт үүрэг болгосугай. | | | |
| 152 | 24 | 32 | **Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_413** 2.3. "Кинкора коппер лимитед" компанийн газар ашигласны төлбөртэй холбоотой гомдлыг хянан үзэж, хуулийн дагуу шуурхай шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт; | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тус компанитай холбоотой өргөдөл гомдол ирээгүй болно. | /-/ | |
| 153 | 24 | 33 | 3. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийн явц, үр дүнг сар тутам Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тус компанитай холбоотой өргөдөл гомдол ирээгүй болно. | /-/ | |
| 154 | 25 | 34 | **Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_417** 3. Мэргэжлийн хяналтын чиг үүрэг салбарын яамдад шилжиж байгаатай холбогдуулан холбогдох яамдын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт зохих өөрчлөлт оруулах шийдвэрийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг | Монгол Улсын Засгийн газраас Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгаж, чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх болсонтой холбогдуулан Засгийн газрын 2020 оны "Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" 105 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, удирдлагаар хянуулж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд, энэ тогтоолын 2.3-т заасан улсын байцаагч нарыг яамны зохих бүтцийн нэгжид шилжүүлэн ажиллуулах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай. | | | |
| 155 | 26 | 35 | **Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2022-11-23**<br>**Дугаар 2022_419**<br>5. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдынхаа 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх бодлогын чиглэл баримталж, үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай. | “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дэвшүүлсэн “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийн зорилтыг хангах хүрээнд Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй салбарын аж ахуйн нэгжийг дэмжих цогц арга хэмжээний санал боловсруулахад шаардлагатай судалгааны ажлыг АМГТГ-тай хамтран боловсруулж байна. | 70% | |
| 156 | 27 | 36 | **“Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн талаар авах арга хэмжээний тухай**<br>**2022-11-30**<br>**Дугаар 2022_434**<br>4. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас оруулсан хөрөнгө, санхүүжилтийг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн тээвэрлэлтийн үйл ажиллагааны орлого, холбогдох бусад эх үүсвэрээс барагдуулах арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д тус тус даалгасугай. | Зүүнбаян төмөр зам” ХХК татан буулгасан тул Эрдэнэс Тавантолгой ХК болон Зүүнбаян төмөр зам ХХК хооронд 2022 оны 9 сард байгуулсан Тавантолгой Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хөрөнгө оруулалт санхүүжилтийн гэрээний дагуу санхүүжүүлэх боломж хязгаарлагдсан. | /-/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 157 | 28 | 37 | **“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-30 Дугаар 2022_435** 4.Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгахад шаардагдах эх үүсвэрийг тооцож саналаа танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх удирдлага (Ж.Ганбат)-д тус тус даалгасугай. | Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Эрдэнэс Монгол ХХК шилжүүлсэн тул үнэлэх боломжгүй | /-/ | |
| 158 | 29 | 38 | **Дүрэм батлах тухай 2022-12-07 Дугаар 2022_445** 3. Батлагдсан дүрмийг хэрэгжүүлж ажиллахыг цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангуулах чиг үүрэг бүхий байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай. 3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай. | Батлагдсан дүрмийн дагуу холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. | 70% | |
| 159 | 30 | 39 | **Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448** 2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, | 2023 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ байхгүй болно. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; 2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх; 2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; 2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах. | | | |
| 160 | 31 | 40 | **“Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-09 Дугаар 2022_450** 3.5. . компанийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагаанд санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт шалгалт хийж, дүнг | Тус яамны мэргэжилтэн Э.Болд-Эрдэнийг Тавантолгой ХК-ийн Ерөнхий инженерийн албан тушаалд шилжүүлэн ажиллуулж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.12.16-ны өдрийн А/306 тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн ажиллах удирдамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2022.12.20-ны өдрийн А/122 тоот тушаалаар "Эрдэнэс тавантолгой" ХК болон "Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагааг газар дээр нь танилцаж, жил бүрийн ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлангаар ирүүлсэн мэдээ, мэдээлэл үндэслэлтэй эсэхийг нягталж, | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт; | дүгнэл гаргаж, цаашид авах арга хэмжээний саналаа нэгтгэн ажлын хэсгийн тайлан, танилцуулга бэлтгэн Сайдад 2022.12.30-ны өдөр танилцуулсан. | | |
| 161 | 32 | 41 | **Журам батлах тухай**<br>**2022-12-14**<br>**Дугаар 2022_466**<br>2. Энэ тогтоолын 1-д заасан цахим арилжаанд хяналт тавих журмыг хамтран баталж, мөрдүүлэхийг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт үүрэг болгож, Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-д зөвлөсүгэй. | Тогтоол гарсантай холбогдуулан журмын хэрэгжилтийг хангах зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.12.16-ны өдрийн А/305 дугаар тушаалаар өмнөх А/281 дүгээр тушаалыг шинэчлэн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинээр зохион байгуулж томилсон. Шинээр байгуулагдсан ажлын хэсэг цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. | 70% | |
| 162 | 33 | 42 | **Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай**<br>**2022-12-21**<br>**Дугаар 2022_469**<br>4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт зохих нэмэлт, өөрчлөлтийг тусган боловсруулж, батлуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгасугай. | Монгол Улсын Засгийн газраас Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгаж, чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх болсонтой холбогдуулан Засгийн газрын 2020 оны "Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" 105 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, удирдлагаар хянуулж байна. | 100% | |
| 1.ё. Ерөнхий сайдын захирамж | | | | | | |
| 1.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | | |
| 163 | 1 | 1 | **2021 оны 2 дугаар сарын 14-ний өдөр 10 дугаар тэмдэглэл**<br>**2021-02-14**<br>**Дугаар 2021_10**<br>I.2. 19. Халдварт цар тахлын хүндрэлтэй нөхцөлд бүх төрлийн шатахуун, дизель түлшний жижиглэнгийн үнийг нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг | Тус тэмдэглэлийн 19 дүгээр заалтын дагуу газрын тосны бүтээгдэхүүний хангамж, гадаад зах зээлийн нөхцөл байдал, жижиглэн борлуулалтын үнийн талаарх Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, холбогдох танилцуулгыг бэлтгэж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар УУХҮ-ийн Сайдын 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 01/460 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд; | | | |
| 164 | 2 | 2 | **2021 оны 2 дугаар сарын 24-ний өдөр 13 дугаар тэмдэглэл 2021-02-24 Дугаар 2021_13** XI.3.6. Эрхлэх асуудлын хүрээнд хугацаа хоцорч, хэрэгжилт нь удаашралтай байгаа төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, төлөвлөсөн хугацаа, үр дүнг тооцож ажиллахыг холбогдох сайд нарт." | Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилтод тусгагдсан салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн ил уурхайн олборлолтын технологи нэвтрүүлэх, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, Оюутолгойн ордыг түшиглэн Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах, Газрын тос дамжуулах 530 км хоолой барих зэрэг төслийн хэрэгжилт удаашралттай байгаа талаар танилцуулга бэлтгэн Эдийн засаг, хөгжлийн яаманд 2022 оны 10 дугаар сард хүргүүлсэн. | 70% | |
| 165 | 3 | 3 | **2021 оны3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2021-03-03 Дугаар 2021_14** XII.4. 4. Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий тос дамжуулах хоолой барих санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, сонгон шалгаруулалтыг шуурхай зохион байгуулж, тус бүтээн байгуулалтын ажлыг ойрын үед эхлүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт, Газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай түүхий эдийг ОХУ болон бусад улсаас нийлүүлэх боломжийг судлахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд; | Олон улсын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж шалгарсан компанитай гэрээ байгуулах талаар ЗГ-ын 2022.3.02-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэл, 94 дүгээр тогтоолыг тус тус гаргуулж, хоолойн байгууламж барихад шаардагдах санхүүжилтийг нүүрс урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт хэрэгжүүлж буй газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл нь ҮАБЗ-ийн зөвлөмж болон ЗГ-ын шийдвэрийн хүрээнд дотоодын түүхий эдэд тулгуурласан үйлдвэр байх юм. Тус үйлдвэрт ОХУ болон бусад улсаас түүхий эд нийлүүлэх боломжийн талаар судалж байна. | 100% | |
| 166 | 3 | 4 | XII.4. 6. Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ТЭЗҮ-ийг дахин хянаад дүгнэлт гаргахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд; | "Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол, ижил төстэй үйлдвэрүүдийн харьцуулсан судалгаа, төслийн санхүүжилтийн талаарх санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий" ажлын хэсгийг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/100 дугаар тушаалаар байгуулсан. Дүгнэлтийг 2021.12.09-ний өдрийн 03/678 дугаар албан бичгээр УУХҮЯ-нд ирүүлсэн. Дүгнэлтээр: 1. ТЭЗҮ нь Монгол Улсад мөрдөгдөж буй эрх зүйн үндэслэлийг тооцоогүй, эдийн засгийн тооцоолол бүхэлдээ буруу хийгдэж алдаатай болсон, төслийг хэрэгжүүлэх эрсдэлтэй тул дахин шинээр хийх; 2. "Сымбат инженеринг" ХХК-тай цаашид ажиллахгүй тохиолдолд төсөлд оролцохоор ирүүлсэн хамгийн сайнаар үнэлэгдэх санал болох БНХАУ-ын "Шинхай групп"-ийн саналтай дүйцэх саналыг | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэрэгжүүлэх; 3. Цэвэршүүлэх алт мөнгөний жилийн хүчин чадлыг Монголбанкинд 1990 оноос хойш аж ахуй нэгж байгууллага, иргэдийн тушаасан алт мөнгөний хэмжээ, нөөц, уул уурхайн компаниудын хэтийн төлөв, ирээдүйд хэрэгжих томоохон төсөл хөтөлбөр, хэмжээ, нөөцийг харгалзан үзэж жилд 30 хүртэл тн алт, 50 хүртэл тн мөнгө цэвэршүүлэх, хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх боломжтойгоор төлөвлөх; 4. Эдгээр хувилбаруудаас хамгийн боломжит хувилбар "түлхүүр гардуулах"-аар "төсөл хэрэгжүүлэгчээр өөрөө нь санхүүжих, 8-10 жилийн урт хугацааны гадны банкны хөнгөлөлттэй зээлд хамрагдах хувилбарыг судлах гэсэн дүгнэлт гарсан. | | |
| 167 | 3 | 5 | XII.4. 9. Монгол Улсын төрийн өмчит "Мон-Атом" компани, Бүгд Найрамдах Франц Улсын "Орано" группын хамтран хэрэгжүүлж буй "Бадрах Энержи" ХХК-ийн төслийн талаарх байр суурийа тодорхой болгох, цаашид авах арга хэмжээний тухай саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд; | Монгол Улсын төрийн өмчит "Мон-Атом" компани, Бүгд Найрамдах Франц Улсын "Орано" группын хамтарсан "Бадрах Энержи" ХХК-ийн хэрэгжүүлж буй Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт байрлах Зөөвч овоогийн ордыг ашиглах туршилтын олборлолтыг 2021.07.09-ний өдрөөс эхэлсэн тул Засгийн газрын хуралдаанд танилцуулах шаардлагагүй болсон. | 70% | |
| 168 | 3 | 6 | XII.2. . Засгийн газраас 2020-2024 онд санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав: 1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоол болон Засгийн газрын 2020 оны 66 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын | 1. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны А/93 дугаар тушаалаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулж, ажлын хэсэг тус хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулж, 2022.01.05-ны өдөр Улсын Их хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн барьсан.Улсын Их хурал хуулийн төслийг 2022.12.23-ны өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцэж, баталсан.<br>Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.10.27-ны өдрийн А/273 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан.<br>Ажлын хэсэг хуулийн төсөл болон үзэл баримтлалын төслийг боловсруулаад байна.<br>2.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөвлөгөө"-нд тусгагдсан хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж, 2021 оны II улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; | баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж, хуулийн төсөлд яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагууХууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамнаас 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг ЗГХЭГ-аар дамжуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бүрдлийг хангаан хүргүүлсэн. Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу 2022.11.01-ний өдөр хуулийн төсөл, дагалдах хууль болон холбогдох бусад бичиг баримтуудыг буцаахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт албан бичиг төлөвлөн хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" 192 дугаар захирамжаар Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Улмаар тус Ажлын хэсгийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн сайд ажиллах болсон тул холбогдох материалуудыг 2022 оын 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/3297 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайдад шилжүүлсэн | | |
| 169 | 3 | 7 | XII.2.2. "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д тусгагдсан хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажлын төлөвлөгөөг баталж, үндсэн чиглэлд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; | Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны А/93 дугаар тушаалаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулж, ажлын хэсэг тус хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулж, 2022.01.05-ны өдөр Улсын Их хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн барьсан.Улсын Их хурал хуулийн төслийг 2022.12.23-ны өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцэж, баталсан. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.10.27-ны өдрийн А/273 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг хуулийн төсөл болон үзэл баримтлалын төслийг боловсруулаад байна. Улмаар тус Ажлын хэсгийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн сайд ажиллах болсон тул холбогдох материалуудыг 2022 оын 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/3297 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайдад шилжүүлсэн. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 170 | 4 | 8 | **2021 оны 3 дугаар сарын 5-ны өдөр 15 дугаар тэмдэглэл 2021-03-05 Дугаар 2021_15** III.2.3. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замыг барьж байгуулах ажлыг эрчимжүүлж, 2021 онд ашиглалтад оруулах талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; | Тавантолгой-Зүүнбаян болон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын төслийг санхүүжүүлэх зорилгоор "Эрдэнэс Тавантолгой" ХК болон "Тавантолгой төмөр зам" ХХК ЭТТ-2022/13 дугаартай санхүүжилтийн гэрээг байгуулсан бөгөөд төслийн бүтээн байгуулалтад 2022 онд нийт 218 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төслийн бүтээн байгуулалтын явц 98%-ийн гүйцэтгэлтэй явж байгаа бөгөөд техникийн комисс болон улсын комисс ажиллуулж, ашиглалтад оруулахаар ажиллаж байна. | 100% | |
| 171 | 4 | 9 | III.2.4. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын барилгын ажилд шаардлагатай үлдэгдэл санхүүжилтийг шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ)-д; | Төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэхэд зайлшгүй шаардлагатай хөрөнгийг санхүүжүүлэх хүрээнд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн зүгээс нийт 1.28 тэрбум төгрөгийн санхүүжилтийг төсөлд зарцуулсан байна. "Зүүнбаян төмөр зам" ХХК татан буулгасан тул Эрдэнэс Тавантолгой ХК болон Зүүнбаян төмөр зам ХХК хооронд 2022 оны 9 сард байгуулсан Тавантолгой Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хөрөнгө оруулалт санхүүжилтийн гэрээний дагуу санхүүжүүлэх боломж хязгаарлагдсан. | 100% | |
| 172 | 5 | 10 | **2021 оны 3 дугаар сарын 10-ны өдөр 17 дугаар тэмдэглэл 2021-03-10 Дугаар 2021_17** XII.4. . Монгол Улсын Засгийн газраас 2020-2024 онд уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэх томоохон бүтээн байгуулалт, "Үндэсний баялгийн сангийн тухай" болон "Эрдэс баялгийн биржийн тухай" хуулийн төслүүдийн явцын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав: 1. "Үндэсний баялгийн сангийн тухай" хуулийн төслийг хамтарсан Ажлын хэсэг байгуулж Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулан Засгийн | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж, хуулийн төсөлд яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамнаас 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг ЗГХЭГ-аар дамжуулан УИХ-д өргөн мэдүүлэхээр бүрдлийг хангаан хүргүүлсэн. Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу 2022.11.01-ний | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Б.Жавхлан нарт | өдөр хуулийн төсөл, дагалдах хууль болон холбогдох бусад бичиг баримтуудыг буцаахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт албан бичиг төлөвлөн хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" 192 дугаар захирамжаар Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Ажлын хэсгийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн сайд ажиллах болсон тул холбогдох материалуудыг 2022 оын 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/3297 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайдад шилжүүлсэн. | | |
| 173 | 5 | 11 | XII.4. 2. Эрдэс баялгийн биржийн тухай" хуулийн төслийг хамтарсан Ажлын хэсэг байгуулж Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд 2022.01.05-ны өдөр УИХ-ын даргад Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн бөгөөд 2022.01.17-ны өдөр УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж дэмжигдсэн. Улмаар 2022.01.18-ны өдөр УИХ-ын намрын ээлжит чуулганы сүүлийн өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэж дэмжигдсэн. УИХ-ын ЭЗБХ-ноос ажлын хэсэг гарахаар болсон бөгөөд Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд заасны дагуу холбогдох Ажлын хэсэг УИХ-ын даргын захирамжаар байгуулагдаж мөн дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийн дэд ажлын хэсгийн хурал нь 2022-10-20-ны өдөр хуралдсан бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд өргөн мэдүүлж, батлуулав. | 100% | |
| 174 | 6 | 12 | **2021 оны 3 дугаар сарын 31-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2021-03-31 Дугаар 2021_21** YII.9. Хилийн боомтуудын экспорт, импортын хэвийн үйл ажиллагааг хангах, ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэх, тасалдалгүй байхаар зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгав | Монгол-Хятадын хилийн бүсийн "Ногоон гарц" түр журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх саналыг боловсруулж 2021.02.16-ны өдрийн 01/373 дугаар албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. Үүний дүнд Ховд аймгийн нутаг дэвсгэр орших Булган боомтыг амралтын өдрүүдэд ажиллуулж хүчин чадлыг нэмэгдүүлсэн. Мөн нүүрсний тээврийн жолооч нарыг коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг дархлаажуулалт болох вакцинжуулалтад хамруулах ажлыг 2021.03.18-ны өдрөөс эхлэн зохион байгуулсан. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийн жолооч нарыг нэн түрүүнд вакцинд хамруулах шийдвэрийг Эрүүл мэндийн яамнаас гаргуулан Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газарт 11000 вакцины тун хүргүүлснээр Гашуун сухайт боомтын 5449, Оюутолгойн тээврийн 200, Шивээ хүрэн боомтын 1658, нийт 7307 тээврийн жолооч, тээвэр хариуцсан ажилчдыг Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг вакцинд хамруулсан болно. Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан 2022 оны 47 дугаар захирамжаар байгуулагдсан "Хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын үйл ажиллагааг эрчимжүүлэхэд зайлшгүй шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллаж, холбогдох мэдээлэл, саналыг тухай бүр өгч | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажилласан. Мөн хилийн Гашуунсухайт боомтод төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Чингэлэгт тээврийн терминалыг барьж ашиглалтад оруулсан. Улсын хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 31.1 сая тонн нүүрс, 1.44 сая тонн зэсийн баяжмал, 4.7 сая тонн төмрийн хүдэр, баяжмал тус тус экспортод гаргасан байна. | | |
| 175 | 7 | 13 | **2021 оны 5 дугаар сарын 12-ны өдөр 30 дугаар тэмдэглэл 2021-05-12 Дугаар 2021_30** XIX.5.4 . "Тавантолгой-Зүүнбаян" төмөр замын ажлын гүйцэтгэлийн үлдэгдэл санхүүжилтийг үе шаттайгаар шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт. | Төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэхэд зайлшгүй шаардлагатай хөрөнгийг санхүүжүүлэх хүрээнд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн зүгээс нийт 1.28 тэрбум төгрөгийн санхүүжилтийг төсөлд зарцуулсан байна. "Зүүнбаян төмөр зам" ХХК татан буулгасан тул Эрдэнэс Тавантолгой ХК болон Зүүнбаян төмөр зам ХХК хооронд 2022 оны 9 сард байгуулсан Тавантолгой Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хөрөнгө оруулалт санхүүжилтийн гэрээний дагуу санхүүжүүлэх боломж хязгаарлагдсан. | 100% | |
| 176 | 8 | 14 | **2021 оны 6 дугаар сарын 23-ны өдөр 36 дугаар тэмдэглэл 2021-06-23 Дугаар 2021_36** X.. 1. Тогтоол хүчингүй болгох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов. 2. Энэ тогтоолоор хүчингүй болгосон тогтоол, тогтоолын заалтын үр дүнд аж ахуйн нэгжүүд, эдийн засаг, төсөвт үзүүлж буй нөлөөллийг нэг жилийн хугацаагаар үнэлж дүгнэн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа 2022 оны 2 дугаар улиралд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгав. | Хүчингүй болгох тогтоол ирээгүй | 0% | |
| 177 | 8 | 15 | XII.9.2. Нийслэлийн хүн амын хэрэгцээнд шаардлагатай сайжруулсан шахмал түлш болон "Тавантолгой түлш" ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний үндсэн түүхий эд (мидлинг), барьцалдуулагчийн нөөц бүрдүүлэлт, тээвэрлэлтэд онцгой анхаарал тавьж ажиллахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн | Эрдэнэс Тавантолгой ХК "Тавантолгой түлш" ХХК-д 2022 онд нийт 96.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, "Тавантолгой түлш" ХХК (М.Ганбаатар)-д; | | | |
| 178 | 9 | 16 | **2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл 2021-07-07 Дугаар 2021_41** XXYII.2.. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаа болон охин компаниудын өнөөгийн байдал, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаанд аудит хийсэн дүн, Ажлын хэсгийн дүгнэлтийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий газрын тосоор тогтвортой тасралтгүй, найдвартай хангах судалгаа, тооцоог хийж, нөөц болон олборлолтыг өсгөх ажлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав; | Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлаар танилцуулга, мэдээлэл бэлтгэн 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 25 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. Уг тэмдэглэлд газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны хайгуул, ашиглалтын бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайг хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын газрын нэгдмэл санд бүртгэх, газар ашиглах гэрчилгээ олгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд дэмжиж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасан. Цаашид газрын тосны хайгуулын талбайнуудад нөөц тогтоох боломжтой Галба-11, Тариач-15, Баянтүмэн-17, Хөх нуур-18, Давст-31, Ар булаг-29 зэрэг талбайн мэдээллийг 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн Засгийн газрын ээлжит бус цахим хуралдаанд танилцуулж ажилласан болно | 70% | |
| 179 | 10 | 17 | **2021 оны 8 дугаар сарын 4-ний өдөр 45 дугаар тэмдэглэл 2021-08-04 Дугаар 2021_45** XII.6. . Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн гүйцэтгэсэн ажлын төлбөр, тооцоо, зардал болон төслийн бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгахад шаардагдах үлдэгдэл санхүүжилтийн эх үүсвэрийн асуудлыг 2021 оны 3 дугаар улиралд багтаан шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул | Төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэхэд зайлшгүй шаардлагатай хөрөнгийг санхүүжүүлэх хүрээнд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн зүгээс нийт 1.28 тэрбум төгрөгийн санхүүжилтийг төсөлд зарцуулсан байна. "Зүүнбаян төмөр зам" ХХК татан буулгасан тул Эрдэнэс Тавантолгой ХК болон Зүүнбаян төмөр зам ХХК хооронд 2022 оны 9 сард байгуулсан Тавантолгой Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хөрөнгө оруулалт санхүүжилтийн гэрээний дагуу санхүүжүүлэх боломж хязгаарлагдсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Б.Жавхлан, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр нарт даалгав; | | | |
| 180 | 11 | 18 | **2021 оны 8 дугаар сарын 18-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2021-08-18 Дугаар 2021_47** XIY.5. . Шатахууны үнэ тогтворжуулах сангийн үйл ажиллагаа болон бусад улс орны туршлага, эрх зүйн орчин, хүрэх үр дүнгийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан шатахууны үнийг тогтворжуулах сан байгуулах, түүний удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт, санхүүжилтын эх үүсвэрийн талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгав. | Тус тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хүрээнд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг тус тус боловсруулж, санал авахаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 01/2432 дугаар албан бичгээр яамдад хүргүүлсэн. Тус хуулийн төслийг дэмжих боломжгүй талаар Сангийн яамнаас 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 8-215680 дугаар албан бичгээр санал ирүүлсэн. Иймд хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх боломжгүй болсон | /-/ | |
| 181 | 12 | 19 | **2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 55 дугаар тэмдэглэл 2021-10-13 Дугаар 2021_55** XY.13.2. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дэргэдэх "Эрдэнэс газ" төслийн нэгжийг татан буулгаж, төрийн өмчийн хувьцаат компани байгуулах шийдвэрийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Хаянхярваад; | Эрдэнэс Монгол" ХХК-ийн дэргэдэх "Эрдэнэс газ" төслийн нэгжийг татан буулгаж, төрийн өмчийн хувьцаат компани байгуулах шийдвэрийн төслийг боловсруулах асуудлаар Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын албаны дарга Баяр-Эрдэнэ, "Эрдэнэс монгол ХК-ийн дэд дарга Энхболд, "Эрдэнэс газ" төслийн нэгжийн дарга Амарсайхан нар уулзалт зохион байгуулсан ба "Эрдэнэс Монгол" ХХК-ийн зүгээс төрийн өмчийн хувьцаат компани байгуулах шаардлагагүй гэж үзсэн. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 182 | 13 | 20 | **2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр 59 дүгээр тэмдэглэл 2021-11-10 Дугаар 2021_59** XIII.5. . Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн явцын талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. 1. Үүнтэй холбогдуулан уг төслийн талаар дараахь арга хэмжээ авч ажиллахыг холбогдох сайд нарт даалгав: 1.1. Байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн хэрэгжилтийг улам эрчимжүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; 1.2. Байгалийн хий нийлүүлэх магистраль шугамнаас Монгол Улс өөрийн дотоодын хийн хэргэлгээгээ авах эсэх асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар дахин хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх нарт; 1.3. Уг төслийг хэрэгжүүлэхэд зөвлөх үйлчилгээ авах асуудлыг судлахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт | Хийн хоолойн ТЭЗҮ боловсруулах судалгааны ажлын хүрээнд трассын дагуу байрших ашигт малтмалын илрэл, тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг хүргүүлсэн. Судалгааны ажил дууссан бөгөөд ТЭЗҮ-ийг тусгай зориулалтын компани "Газопровод Союз Восток" ХХК 2021.12.15-ны өдөр Монголын талд хүлээлгэн өгсөн. 2022.02.28-ны өдөр Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан болон "Газпром" НХН-ийн Удирдах зөвлөлийн орлогч дарга В.А.Маркелов нар Монгол Улсын Засгийн газар болон "Газпром" НХН-ийн Хамтарсан ажлын хэсгийн 2022–2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, "Газопровод Союз Восток" ХХК болон "Газпром Проектирование" ХХН-ийн хооронд инженер хайгуул судалгаа, зураг төслийн ажлуудыг гүйцэтгэх гэрээнд гарын үсэг зурсан. Үүний дагуу 2022.04.28-ны өдөр инженерийн хайгуул судалгааны ажил эхэлсэн бөгөөд холбогдох судалгааны ажил явагдаж байна. Мөн байгалийн хий дамжуулах хоолойн шугамын чиг /трасс/-ийг тодорхойлох талаар санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.04.05-ны өдрийн А/63 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Шадар сайдаас өгсөн чиглэлийн дагуу төслийн хэрэгжилтэд төрөөс дэмжлэг үзүүлэх тухай хуулийн төсөл боловсруулж батлуулах үүрэг бүхий ажлын ажлын хэсгийг Ерөнхий сайдын захирамжаар байгуулах тухай хүсэлтийг УУХҮ-ийн сайдын 2022.04.28-ны өдрийн 01/1231 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын газар нутгаар дамжин өнгөрөх байгалийн хий дамжуулах хоолойг барих төслийн дэд бүтэц түүний бүтээн байгуулалт, ТЭЗҮ зураг төсөлтэй холбоотой байгууллагын нууцад хамаарах мэдээллийг солилцох талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон "Газопровод Союз Восток" ХХК-ийн хооронд Нууцлалын гэрээг 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр байгуулж, гэрээний биелэлтийг ханган ажиллаж байна.<br><br>Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан барих байгалийн хийн хоолой төслийн бэлтгэл ажлыг хангах асуудлын хүрээнд холбогдох аймаг, сумдын нутаг дэвсгэрийг хамарсан байр зүйн зургийг бэлтгэн хавсралтаар хүргүүлж ажлын хэсгийг мэдээллээр хангаж оролцов. Ажлын хэсэг дамжуулах хоолойн зурвас газрыг улсын тусгай хамгаалалтад авахтай холбоотой асуудлаар Засгийн газраас гаргах шийдвэрийн төслийг боловсруулах ажлын хэсэг ажиллаж байна. | 70% | |
| 183 | 14 | 21 | **2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр 65 дугаар тэмдэглэл 2021-12-22 Дугаар 2021_65** | Монгол Улсын Засгийн газрын 2022.03.16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр даалгасны дагуу "Аж үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө (үйлдвэр тус бүрээр эдийн засгийн үр өгөөжийг харуулсан) дахин нарийвчлан боловсруулж" Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар УУХҮС-ын | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | XXIY.2. . Шинэ сэргэлтийн бодлого болон боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд хилийн боомтын хөгжлийн ерөнхий цогц төлөвлөгөөний төслийг Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Шинэ сэргэлтийн бодлогын Эрчим хүчний сэргэлтийн ерөнхий цогц төлөвлөгөөг боловсруулж танилцуулахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Аж үйлдвэржилтийн сэргэлтийн цогц төлөвлөгөөг боловсруулж танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хот, хөдөөгийн сэргэлтийн ерөнхий цогц төлөвлөгөөг боловсруулж танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Ногоон хөгжлийн сэргэлтийн ерөнхий цогц төлөвлөгөөг боловсруулж танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Төрийн бүтээмжийн сэргэлтийн ерөнхий цогц төлөвлөгөөг боловсруулж танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус даалгав | 2022.05.24-ний өдрийн 01/1500 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Сар тутам Эдийн засгийн хөгжлийн яаманд хэрэгжилтийг хүргүүлэн ажиллаж байна. | | |
| 184 | 15 | 22 | **2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр 1 дүгээр тэмдэглэл 2022-01-05 Дугаар 2022_1** XX.12.1. Дорноговь аймгийн Улаанбадрах суманд цацраг идэвхт ашигт малтмал буюу уран олборлох үйл ажиллагаа явуулах талбайн байгаль орчны суурь нөхцөл, олборлох технологи, нөлөөллийг тодорхойлсон Шинжлэх ухааны академийн дүгнэлт, зөвлөмжийн талаар Монгол Улсын сайд, Засгийн | БШУЯ-ны ШУТ-ийн салбар зөвлөлөөр 2022 оны 10 дугаар сард төслийн гүйцэтгэгчийг шалгаруулсан бөгөөд тус төслийг ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэн гүйцэтгэх болсон. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/517 дугаар тушаалаар "Дорноговь аймгийн Улаанбадрах суманд орших ураны орд газрын байгаль орчны мониторинг" сэдэвт төслийн 3 жилийн хугацаатай ШУХ-ын Хими, химийн технологийн хүрээлэн хэрэгжүүлж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Шинжлэх ухааны академийн дүгнэлт, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хулан нарт даалгав. | | | |
| 185 | 16 | 23 | **2022 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр 3 дугаар тэмдэглэл 2022-01-12 Дугаар 2022_3** XXYII.5.2. Зүүн бүсийн үйлдвэрийн талбайд сайжруулсан шахмал түлшний шинэ технологи бүхий үйлдвэр барих техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, танилцуулахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт тус тус даалгав. | Таван толгой түлш" ХХК-ийн Багануурын хүрэн нүүрсний ордыг түшиглэн байгуулах "Нүүрс химийн цогцолбор" төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг "Евро азиа майнз" ХХК гүйцэтгэж байна. Баруун бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг зүүн бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр рүү нүүлгэн шилжүүлэх талаар Засгийн газрын 2022.02.10-ны өдрийн хуралдаанд танилцуулж, хуралдааны 9 дүгээр тэмдэглэлийг гаргуулсан. | 100% | |
| 186 | 17 | 24 | **2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр 5 дугаар тэмдэглэл 2022-01-19 Дугаар 2022_5** XYIII.7. . Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар Эрчим хүчний сайд Н.Тавинбэх Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. "Тавантолгой түлш" ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний чанарыг сайжруулах дэвшилтэт технологийн судалгаа, туршилт хийж, үр дүнг 2022 оны 1 улирапд багтаан | Баруун бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг зүүн бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр рүү нүүлгэн шилжүүлэх талаар Засгийн газрын 2022.02.10-ны өдрийн хуралдаанд танилцуулж, хуралдааны 9 дүгээр тэмдэглэлийг гаргуулсан. Эрчим хүчний сайдын 2021 оны А/71 дүгээр тушаалаар "Таван толгой түлш" ХХК-ийн Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах сайжруулсан шахмал түлшний баруун бүсийн үйлдвэрийг Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах зүүн бүсийн үйлдвэр лүү шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, зардлын тооцоог боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулсан. Ажлын хэсэг баруун бүсийн үйлдвэрийг шилжүүлэх зардлын тооцоог боловсруулах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: -Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнгээс Баруун бүсийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийн байдалтай танилцах ажлыг зохион байгуулж, шилжүүлэх боломжтой тоног төхөөрөмжийн тооцоо судалгааг урьдчилсан байдлаар 90 тэрбум төгрөгийн зардлыг тооцоолж гаргав. - Зүүн бүсийн үйлдвэрийн ерөнхий төлөвлөгөөнд шинээр баригдах | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | танилцуулахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, "Эрдэнэс-Тавантолгой" ХК (Б.Ганхуяг), "Тавантолгой түлш" ХХК (М.Ганбаатар)-д; | барилга, байгууламжийн төлөвлөгөөг тусгаж шинэчлэн боловсруулсан. | | |
| 187 | 18 | 25 | **2022 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр 6 дугаар тэмдэглэл 2022-01-26 Дугаар 2022_6** IX.9.2. Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн боловсруулж байгаатай холбогдуулан тус хуулийн төсөлд ашигт малтмалын нөөц ашиглахтай холбогдолтой зарим татварыг орон нутгийн төсөвт шилжүүлэх зохицуулалт тусгахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; | Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.10.27-ны өдрийн А/273 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг хуулийн төсөл болон үзэл баримтлалын төслийг боловсруулаад байна. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022.10.04-ний өдрийн 157 дугаар захирамжаар "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дэвшүүлсэн хот, хөдөөгийн орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг дэмжих цогц арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Энэ хүрээнд Ашигт малтмалын томоохон орд тогтоогдсон бүс нутагт уул уурхайн цогц бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлж, орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх тухай мэдээллийг бэлтгэж, 2022.11.03-ны өдөр Сангийн яаманд цахимаар хүргүүлсэн. | 70% | |
| 188 | 18 | 26 | IX.9.4. Ашигт малтмалын томоохон орд тогтоогдсон бүс нутагт уул уурхайн цогц бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж, дүнг Засгийн газрын хуралдаанаар 2022 оны 2 дугаар улиралд багтаан хэлэлцүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт. | Монгол Улсын Ерөнхий сайдын 2022.10.04-ний өдрийн 157 дугаар захирамжаар "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дэвшүүлсэн хот, хөдөөгийн орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг дэмжих цогц арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Энэ хүрээнд Ашигт малтмалын томоохон орд тогтоогдсон бүс нутагт уул уурхайн цогц бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлж, орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх тухай мэдээллийг бэлтгэж, 2022.11.03-ны өдөр Сангийн яаманд цахимаар хүргүүлсэн. | 30% | |
| 189 | 18 | 27 | IX.10.2. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн "Техник эдийн засгийн үндэслэл"-ийг ОХУ-ын "Газпром" НХН-тэй хамтран баталсан талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: Байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж, барилгын | ОХУ-аас БНХАУ руу дамжуулан барих байгалийн хийн хоолой /трассын хувилбар нь/ нь манай улсын нийслэл Улаанбаатар хот болон Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь зэрэг хүн ам ихээр төвлөрсөн суурьшлын бүсүүдээр дайран өнгөрөхөөр төлөвлөгдсөн. Байгалийн хий дамжуулах хоолойн шугамын чиг /трасс/-ийг тодорхойлох талаар санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.04.05-ны өдрийн А/63 дугаар тушаалаар байгуулсан. Мөн Шадар сайдаас өгсөн чиглэлийн дагуу төслийн хэрэгжилтэд төрөөс дэмжлэг үзүүлэх тухай хуулийн төсөл боловсруулж батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд холбогдох яамдаас санал авч ажлын хэсгийг Ерөнхий сайдын захирамжаар байгуулах тухай хүсэлтийг УУХҮСайдын 2022.04.28-ны өдрийн 01/1231 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ажлыг 2024 оноос өмнө эхлүүлэх чиглэлээр ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хулан нарт даалгав. | хүргүүлсэн. Байгалийн хий дамжуулах хоолойн шугамын чиг /трасс/-ийг тодорхойлох талаар санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд шугамын чигийн дагуу дахин шалгаж талбайн давхцалыг гаргаж байна Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын газар нутгаар дамжин өнгөрөх байгалийн хий дамжуулах хоолойг барих төслийн дэд бүтэц түүний бүтээн байгуулалт, ТЭЗҮ зураг төсөлтэй холбоотой байгууллагын нууцад хамаарах мэдээллийг солилцох талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон "Газопровод Союз Восток" ХХК-ийн хооронд Нууцлалын гэрээг 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр байгуулж, гэрээний биелэлтийг хангаж ажиллаж байна. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан барих байгалийн хийн хоолой төслийн бэлтгэл ажлыг хангах асуудлын хүрээнд холбогдох аймаг, сумдын нутаг дэвсгэрийг хамарсан байр зүйн зургийг бэлтгэн хавсралтаар хүргүүлж ажлын хэсгийг мэдээллээр хангаж оролцов. Ажлын хэсэг дамжуулах хоолойн зурвас газрыг улсын тусгай хамгаалалтад авахтай холбоотой асуудлаар Засгийн газраас гаргах шийдвэрийн төслийг боловсруулах ажлын хэсэг ажиллаж байна. | | |
| 190 | 18 | 28 | IX.19. . . Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэхэд шаардлагатай үлдэгдэл санхүүжилтийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын барилгын ажлыг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ашиглалтад оруулахтай холбогдуулан барилга угсралтын ажлыг үргэлжлүүлж дуусгахад шаардлагатай үлдэгдэл санхүүжилтийн хуваарийг 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор нарийвчлан гаргахыг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал О.Батнасан нарт, хуваарийг баталж, санхүүжилтийн явцад хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт тус тус даалгав. | Төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэхэд зайлшгүй шаардлагатай хөрөнгийг санхүүжүүлэх хүрээнд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн зүгээс нийт 1.28 тэрбум төгрөгийн санхүүжилтийг төсөлд зарцуулсан байна. "Зүүнбаян төмөр зам" ХХК татан буулгасан тул Эрдэнэс Тавантолгой ХК болон Зүүнбаян төмөр зам ХХК хооронд 2022 оны 9 сард байгуулсан Тавантолгой Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хөрөнгө оруулалт санхүүжилтийн гэрээний дагуу санхүүжүүлэх боломж хязгаарлагдсан. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 191 | 19 | 29 | **2022 оны 2 дугаар сарын 23-ны өдөр 12 дугаар тэмдэглэл 2022-02-23 Дугаар 2022_12** X.4.2.5. Газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх гэрээний багцын тендерийн ажлын явц, төслийн нийт хөрөнгө оруулалтын зардал, бүтээгдэхүүний үнийн тооцоолол, өөрчлөлт цар тахлын үеийн нөхцөл байдал тулгамдаж буй асуудал, төслийн бүтээн байгуулалтад шаардлагатай бараа, материал, машин механизм, тээвэрлэлтийн асуудлаар холбогдох гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, Хөгжлийн банкны зээлийн хүүг бууруулах, үйлдвэрийн түүхий эдийн нөөц, хангамжийг нэмэгдүүлэх зэргийг судлан үзэж, холбогдох тооцоо, судалгаа хийн Ерөнхий сайдын 2020 оны 8 дугаар 21-ний өдрийн 32 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг (Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан)-т танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК (Д.Алтанцэцэг) нарт; | Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан Ерөнхий сайдын 2020 оны 32 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийг 2021 оны 122, 133 дугаар, 2022 оны 156 дугаар захирамжаар тус тус шинэчлэн байгуулсан. Ажлын хэсгийн дэд ахлагчаар УУХҮ-ийн сайд ажиллаж байгаа бөгөөд Шадар сайдын 2021 оны 87 дугаар тушаалаар Ажлын хэсгийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ажлын хэсэгт танилцуулж ажиллав. Төслийн явц, тулгамдаж буй асуудлаар 2022.09.02-ны өдөр Шадар сайдын ахалсан ажлын хэсэгт танилцуулсан. Мөн УУХҮС-ын 2022.08.03-ны өдрийн А/197 дугаар тушаалаар, төслийн санхүүжилт болон Хөгжлийн банкны санхүүжилтэд үүсээд буй асуудлыг шийдвэрлэх талаар санал боловсруулж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮ-ийн Дэд сайдаар ахлуулан ажилласан | 70% | |
| 192 | 20 | 30 | **2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл 2022-03-16 Дугаар 2022_16** XYIII.10. . "Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, хөгжлийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 01 тоот албан даалгаврын 5.1-д заасны дагуу аж үйлдвэржилтийн сэргэлтийн ерөнхий төлөвлөгөөний талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан аж үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний | "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд салбарын үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн төслүүд Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх хуулийн төслүүдийн хэрэгжилтийн явцыг нэгтгэн боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яаманд сар бүр тайлагнасан. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөвлөгөөг (үйлдвэр тус бүрээр эдийн засгийн үр өгөөжийг харуулсан) дахин нарийвчлан боловсруулан Засгийн газрын хуралдаанд 2022 оны 4 дүгээр сард багтаан танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт даалгав. | | | |
| 193 | 20 | 31 | XYIII.11. . "Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, хөгжлийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 01 тоот албан даалгаврын 4.8-д заасны дагуу эрчим хүчний салбарт цөмийн эрчим хүч ашиглах чиглэлээр баримтлах бодлогын талаар Эрчим хүчний сайд Н.Тавинбэх Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан цөмийн эрчим хүчний эх үүсвэрийг Монгол Улсад ашиглах суурь судалгааны ажлыг эхлүүлж, цаашид бодлогын ямар чиглэл баримтлах талаар саналаа боловсруулан танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цөмийн энергийн комиссын дарга Л.Энх-Амгалан, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгав. | "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд салбарын үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн төслүүд Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх хуулийн төслүүдийн хэрэгжилтийн явцыг нэгтгэн боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яаманд сар бүр тайлагнасан. | 70% | |
| 194 | 21 | 32 | **2022 оны 3 дугаар сарын 23-ны өдөр 17 дугаар тэмдэглэл 2022-03-23 Дугаар 2022_17** IX.2.3. Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх шаардлагын хүрээнд төрийн өмчит болон оролцоотой уул уурхайн салбарын аж ахуйн нэгжийн гадаад валютын орлогыг Монголбанканд төвлөрүүлэх талаар судлан танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав; | Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын 3-д "Хүчин төгөлдөр гэрээ, хэлцлүүдийн хүрээнд экспорт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах замаар 2022 оны 4 дүгээр улиралд багтаан "Эрдэнэс Тавантолгой" ХК 500.0 сая ам.доллар, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ 300.0 сая ам.доллар, "Монголросцветмет" ТӨҮГ 20.0 сая ам.доллар, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨҮГ 15.0 сая ам.доллароос багагүй орлогыг тус тус төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Энх-Амгалан), "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ (Г.Ёндон), "Монголросцветмет" ХХК (Б.Мөнхбат), "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК (А.Ариунболд)-нд тус тус үүрэг болгосугай" гэж тусгасан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Энэ хүрээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжүүдийн орлогын гүйцэтгэл дараах байдалтай байна. Үүнд:<br>- ЭТТ ТӨҮГ 500,000.00 мянган ам.доллар төвлөрүүлэхээс 585,813.08 мянган ам.доллар төвлөрүүлсэн нь **117.0%** гүйцэтгэлтэй.<br>- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 300,000.00 мянган ам.доллар төвлөрүүлэхээс 326,851.36 мянган ам.доллар төвлөрүүлсэн нь **108.95%** гүйцэтгэлтэй.<br>- Монголросцветмет ТӨҮГ 20,000.00 мянган ам.доллар төвлөрүүлэхээс 15,122.00 мянган ам.доллар төвлөрүүлсэн нь **75.61%** гүйцэтгэлтэй.<br>- Дархан төмөрлөгийн үйлдвэр ТӨХК 15,000.00 мянган ам.доллар төвлөрүүлэхээс 7,265.16 мянган ам.доллар төвлөрүүлсэн нь **48.43%** гүйцэтгэлтэй байна.<br>Мөн Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд Засгийн газрын 2022.03.31-ний өдрийн хуралдаанд "Эрдэнэс-Тавантолгой" ХК болон БНХАУ-ын Чалко Трэйдинг Хонгконг компани хооронд байгуулсан Нүүрс худалдах, худалдан авах гэрээний гол нөхцөлүүдийг сайжруулан 250 сая ам.долларын урьдчилгаа төлбөрийг авч Монголбанканд тушаах асуудлыг танилцуулж, шийдвэрлүүлсэн.<br>Оюутолгой ХХК 2022 оны 04 дүгээр сараас хойш гадаад валютын эх үүсвэрийг 100 хувь Монголбанкинд төвлөрүүлж байгаа бөгөөд энэ хугацаанд нийт 1.6 тэрбум ам.долларын эх үүсвэрийг Монголбанкинд төвлөрүүлсэн байна. | | |
| 195 | 21 | 33 | IX.3.3. Оюу толгойн уурхайн баяжмалын агуулгад байгаа алтны хэмжээг зохих аргачлал, журмын дагуу тооцож, Улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх боломжийг судлан санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Наранцогт нарт; | Оюу толгойн уурхайн баяжмалын агуулгад байгаа алтны хэмжээг зохих аргачлал, журмын дагуу тооцож, улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх боломжийг судалж байна. | 30% | |
| 196 | 21 | 34 | IX.4. . Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2022 оны 3 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд Баян-Өлгий аймагт томилолтоор ажилласан талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч | Баян-Өлгий аймгийн Ногоон нуур сумын нутаг дэвсгэрт орших "Асгат"-ын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах зарим арга хэмжээний талаар Засгийн газрын 2022.03.16-ны өдрийн хуралдаанд танилцуулж, хуралдааны 16 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав: 1. "Шинэ сэргэлтийн бодлого"-ын аж үйлдвэржилтийн сэргэлтийн хүрээнд "Асгат"-ын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд; | | | |
| 197 | 22 | 35 | **2022 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр 20 дугаар тэмдэглэл 2022-04-06 Дугаар 2022_20** XIII.. Дараахь арга хэмжээ авахыг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захиралд даалгав: 2.1. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн шинэчилсэн дүрмийг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх; 2.2. Шинэчилсэн дүрэмд нийцүүлэн нэгдлийн охин болон хараат компаниудын дүрэм, нэгдлийн хэмжээнд мөрдөх бодлого, журам, гэрээ зэрэг баримт бичгүүдийг шинэчлэх ажлыг хэрэгжүүлэх; 2.3. Шинэчилсэн дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулах. | Засгийн газрын 2022.04.06-ны өдрийн 147 дугаар тогтоолоор "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрмийг шинэчлэн баталсан. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Эрдэнэс Монгол ХХК-ийн шинэчилсэн зохион байгуулалтын бүтцийн талаар Засгийн газрын 2022.05.11-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн охин компани, төслийн нэгжүүдийг группын зохион байгуулалтад оруулах зорилгоор Зэс, металлын болон Нүүрс, эрчим хүчний группын ажиллах түр журмыг баталсан. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 54 дүгээр тушаалаар Үндэсний баялгийн сангийн хууль, эрх зүйн орчныг нарийвчлан судлах, Эрдэнэс Монгол нэгдлийн бүтэц, зохион байгуулалттай уялдуулах, уг компанийн охин, хараат компани болон харьяа үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах талаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгээс гарсан саналын дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2022.10.21-ний өдрийн ХЭГ/2497 дугаар албан бичгээр Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Монголросцветмет ТӨҮГ-ын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан санал авахаар тус яаманд ирүүлсэн бөгөөд тогтоолын төсөлд 2022.10.25-ны өдрийн 01/2789 дүгээр албан бичгээр санал хүргүүлсэн болно. | 100% | |
| 198 | 23 | 36 | **2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2022-04-08 Дугаар 2022_21** I.1. . Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай горимоор хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн "Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хуулийн төсөл батлагдмагц хуулийг хэрэгжүүлэх шуурхай арга хэмжээний | Намрын ургац хураалт, уринш боловсруулалтын ажлыг хугацаанд нь чанартай зохион байгуулахад шаардагдах дизель түлшний үнийг хаврын тариалалтын үеийн үнэтэй ижил түвшинд байхаар тооцож, зөрүүг аж ахуйн нэгжид олгох зохион байгуулалтын арга хэмжээ авах ажлын хэсэгт шаардлагатай тооцоо судалгаа, мэдээллээр хангаж ажилласан Монгол Улсын Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, Засгийн газрын 2022.04.20-ны өдрийн 160 дугаар тогтоолд Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж хоорондь байгуулах АИ-92 автобензиний нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор оролцогч талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тусгасан гэрээ байгуулахаар тусгагдсан. Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | талаарх саналаа Монголбанктай хамтран боловсруулж танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт; | 2022.05.12-ны өдрийн А/102 дугаар тушаалаар Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж хооронд байгуулах АИ-92 автобензиний нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах талаарх "Хариуцлагын гэрээ"-ний загвар баталсан. Уг батлагдсан загвар гэрээний дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь Газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөл бүхий "Шунхлай" ХХК, "Ойн биржˮ ХХК, "Синчи газ" ХХК ,"Тод петролиум" ХХК, Монсуль ХХК,"Магнайтрейд" ХХК, "Содмонгол групп" ХХК,"Энгүүнжим" ХХК,"М-Ойл групп" ХХК, "Нью энержи стар" ХХК, "Эн Пи петролиум "ХХК,"НИК" ХХК,"Гор газ" ХХК, "Ундарга-Увс" ХХК зэрэг 14 аж ахуйн нэгжтэй хариуцлагын гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. | | |
| 199 | 24 | 37 | **2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2022-04-20 Дугаар 2022_24** XIY.8. . Улсын газар зохион байгуулалтын еренхий төлөвлөгөөний 2021 оны хэрэгжилтийн тайлангийн талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авахыг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд заасны дагуу гол, мөрний урсац бүрэлдэх эх орчмын газартай давхцалтай ашигт малтмалын зөвшөөрөлтэй талбайнуудын давхцлыг арилгах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нарт; | Засгийн газрын 2015 оны 3 дугаар 30-ны өдрийн 120 дугаар тогтоолоор батлагдсан "Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам"-ын дагуу гэрээ байгуулсан 44 аж ахуйн нэгжийн 55 ашиглалтын тусгай зөвшөөрөл дээр 52 таван талт гэрээг байгуулсан. | 70% | |
| 200 | 24 | 38 | XIY.14.1. Цагаан суваргын зэс, молибдений төслийг эрчимжүүлэх арга хэмжээний талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4-т "Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтад гадаад ажилтан ажиллуулах тохиолдолд Засгийн газар ажлын байрны төлбөрөөс хөнгөлж, чөлөөлж болно" гэснийг | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Цагаан суваргын зэс, молибдений ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд тоног төхөөрөмжийн суурилуулалт, барилгын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай гадаадаас ажиллах хүч, мэргэжилтнийг авах талаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт; | үндэслэн "Монголын алт" (МАК) ХХК-ийн Цагаан суваргын уулын баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажилд 2023 онд нарийн мэргэжлийн 700 гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөс чөлөөлүүлэх хүсэлт ХНХЯ-нд 2022.10.27-ны өдрийн 03/2812 тоотоор уламжилсан. | | |
| 201 | 24 | 39 | XIY.14.2. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн асуудлыг судалж, санал танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт. | Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн чуулганаар баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Аж үйлдвэржилтийн сэргэлт зорилтыг эрчимжүүлэх хүрээнд дотоодын болон гадаадын зах зээлд борлуулсан, худалдсан, худалдахаар ачуулсан эрдэс бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хэрхэн ногдуулах асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн тушаалыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.01.24-ний өдрийн А/09 дүгээр тушаалаар батлуулж, ажлын хэсгийн хуралдааныг 3 удаа зохион байгуулсан. Нүүрс, төмрийн хүдэр, жоншны АМНАТ-ийн Олон Улсын туршлагын талаарх судалгааг Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (ERI)-ээр хийлгэсэн бол бусад ашигт малтмалын АМНАТ-ын судалгааг Уул уурхайн үндэсний ассоциацитай хамтран Олон Улсын PWC судалгааны байгууллагаар хийлгэсэн. Дээрх судалгаануудад үндэслэн гадаадын зах зээлд борлуулсан нүүрсний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Засгийн газрын 2011 оны 193 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Ашигт малтмалын хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох үндсэн зарчим, аргачлал"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 10-ны 305 дугаар тогтоолоор батлуулсан. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022.12.23-ны өдрийн 100 дугаар тушаалаар Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн талаар судлан үзэж холбогдох хууль, тогтоомжийг боловсронгуй болгох эсэх асуудлаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэгт тус яамны холбогдох албан тушаалтнууд ажиллаж байна. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 202 | 25 | 40 | **2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр 25 дугаар тэмдэглэл 2022-04-27 Дугаар 2022_25** ХХ.3.1. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны хайгуул, ашиглалтын бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайг хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын газрын нэгдмэл санд бүртгэх, газар ашиглах гэрчилгээ олгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгав; | Талбайн мэдээлэл Монгол Улсын газрын нэгдмэл санд бүртгэлгүй" гэсэн шалтгаанаар Капкорп Монголиа ХХК-ийг газрын тосны хайгуулын Онги V болон газрын тосны ашиглалтын Матад-ХХ талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад орон нутгийн зүгээс талбайд орж ажиллах боломж олгохгүй байна. Петро Матад ХХК нь Матад ХХ талбайд 2022 оноос эхлэн 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх газрын тосны ашиглалтын төслийн хүрээнд газар ашиглах зөвшөөрөл авах хүсэлтийг 2021.11.08-ны өдрийн 104/21, 2022.01.05-ны өдрийн 002/022, 2022.03.14-ний өдрийн 028/022, 2022.05.17-ны өдрийн 078/022 дугаар албан бичгүүдээр Дорнод аймгийн Матад сумын Засаг даргад хүргүүлсэн боловч Матад сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас хүсэлтийг дэмжээгүй тухай хариу албан бичгийг 2022.06.07-ны өдрийн 1/167 дугаар албан бичгээр өгсөн. Иймд дээрх асуудалтай холбоотойгоор тус яамнаас Барилга, хот байгуулалтын яаманд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.03.03-ны өдөр 01/547 дугаар албан бичиг, 2022.07.08-ны өдөр 01/1990 дугаар албан бичгээр тус тус хандсан хэдий ч Барилга, хот байгуулалтын яам тус асуудлыг өнөөдрийг хүртэл шийдвэрлээгүй байна. Хариу ирүүлээгүй болно. | 30% | |
| 203 | 25 | 41 | ХХ.5. . "Тавантолгой түлш" ХХК-ийн өнөөгийн байдал, 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлэх ажлын талаар Эрчим хүчний сайд Н.Тавинбэх Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 200,000 тонн сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлэхэд шаардагдах санхүүжилтийг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн шийдвэрлэхийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт; | 200,000 тонн сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг төсвийн тодотголд тусган Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 05 сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор компанийн төсөвт тусган батлуулсан. "Эрдэнэс Тавантолгой" ХК-иас "Тавантолгой Түлш" ХХК болон "Эрдэнэс Тавантолгой" ХК хооронд байгуулсан гэрээний хүрээнд 2022 онд нийт 122,694 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 204 | 25 | 42 | XX.5.5. Зүүн бүсийн үйлдвэрийн талбайд байгаль орчинд ээлтэй, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бүрэн автомат сайжруулсан шахмал түлшний шинэ үйлдвэр барих тооцоо, судалгаа үндэслэн барилга угсралтын ажлыг эхлүүлэхийг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, "Тавантолгой түлш" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Даваацэрэн нарт, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт; | Зүүн бүсийн үйлдвэрлэлийн талбайд байгаль орчинд ээлтэй орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бүрэн автомат сайжруулсан шахмал түлшний шинэ үйлдвэр барих тооцоо судалгааг Эрдэнэс Тавантолгой ХК-д Тавантолгой түлш ХХК-иас ирүүлээгүй байна. | 30% | |
| 205 | 25 | 43 | XX.5.6. Сайжруулсан шахмал түлшний чанарыг сайжруулах, компанийн эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, ашигтай ажиллуулах зорилгоор хагас коксын үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж батлуулах, холбогдох судалгааг үндэслэн үйлдвэр барих санхүүжилтийг шийдвэрлэхийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), гүйцэтгэх захирал Б.Ганхуяг, үйлдвэрийг ашиглалтад оруулах ажлыг шуурхай зохион байгуулахыг "Тавантолгой түлш" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Даваацэрэн нарт. | Хагас коксын үйлдвэрийг ТЭЗҮ болон зураг төсөв боловсруулах ажлын зардлыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн төсвийн тодотголд тусган Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022.05.25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлуулсан байна. Улмаар Багануурын уурхайг түшиглэн хагас коксон шахмал түлш үйлдвэрлэх техник, эдийн засгийн үндэслэлийг төслийг боловсруулан шинжээчдийн хэсгийг байгуулахаар тус яаманд ирүүлсэн | 70% | |
| 206 | 26 | 44 | **2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28** XYI.6. Гашуунсухайт хилийн боомтод дэвшилтэт технологийн (төмөр зам, авто зам, автомат удирдлагатай тээвэр, жолоочгүй тээвэр, дүүжин тээвэр бүхий) тээвэр, логистикийн Тавантолгой нэгдсэн терминалыг иж бүрдлийн хамт байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг | Тавантолгой нэгдсэн терминалын асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Өмнөговь аймагт 2022.05.26-ны өдөр ажиллах үеэр танилцуулсан. Гашуунсухайт өртөөнд төмөр замын тээврээр ирсэн ачааг авто машинд шилжүүлэх ачих, өргөн царигийн вагоноос ачааг нарийн царигийн вагонд шилжүүлэн ачих зориулалт бүхий шилжүүлэн ачих терминалын төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж дууссан. Засгийн газрын 2022.10.27-ны өдрийн хуралдаанаар Эрдэнэс Тавантолгой ХК-д 6 сарын хугацаанд "Онцгой дэглэм тогтоох тухай" шийдвэрийг гаргасан байна | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | боловсруулан, шаардагдах санхүүжилтийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран шийдвэрлэж, тэдгээрийн оролцоог хангаж ажиллахыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт; | | | |
| 207 | 26 | 45 | XYI.7. Гашуунсухайт хилийн боомтод тээвэр, логистикийн Тавантолгой нэгдсэн терминалыг барьж байгуулахад шаардагдах газрын хэмжээ, тусгай хэрэгцээнд авах талбайн байршил, эргэлтийн цэгүүдийн солбицлыг нарийвчлан тогтоож, Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн), "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт; | Гашуунсухайт хилийн боомтод тээвэр, логистикийн Тавантолгой нэгдсэн терминалыг барьж байгуулахад шаардагдах газрын хэмжээ, тусгай хэрэгцээнд авах асуудал нь манай яамны эрхлэх асуудалд хамаарахгүй тул биелэлт гаргах боломжгүй байна | /-/ | |
| 208 | 26 | 46 | XX.3.1.2. Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 467 км авто замын чиг (трасс)-ийн давхцлын асуудлыг судалж, шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; | Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 467 км авто замын чиг (трасс)-ийн давхцалын асуудлаар тус яамнаас 2022.04.28-ны өдрийн 03/1215 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яамнаас тодруулга хүссэн. Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2022.05.17-ны өдрийн 03/2238 дугаар албан бичгээр тус яаманд хариу ирүүлсэн бөгөөд уг албан бичигт концессын гэрээ эзэмшигч "Тахилт хайрхан транс" ХХК нь "...замын трасс нь тусгай зөвшөөрөлтэй давхацсан эсэх, давхацсан хэсгийн чиглэлийг өөрчлөхөд хүрвэл ямар хэмжээний нэмэлт хөрөнгө шаардлагатай болох, эдгээр нь замын ашиглалтын зардалд хэрхэн нөлөөлөх гэх мэт асуудал"-ыг судалж байгаа талаар дурдсан болно. Одоогоор тус яаманд Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 467 км авто замын чиг (трасс)-тай давхцалтай аж ахуйн нэгжүүдээс давхцлын асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлт ирүүлээгүй байна. | 70% | |
| 209 | 26 | 47 | XX.3.1.2. Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 467 км авто замын чиг (трасс)-ийн давхцлын асуудлыг судалж, шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; | Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 467 км авто замын чиг (трасс)-ийн давхцалын асуудлаар тус яамнаас 2022.04.28-ны өдрийн 03/1215 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яамнаас тодруулга хүссэн. Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2022.05.17-ны өдрийн 03/2238 дугаар албан бичгээр тус яаманд хариу ирүүлсэн бөгөөд уг албан бичигт концессын гэрээ эзэмшигч "Тахилт хайрхан транс" ХХК нь "...замын трасс нь тусгай зөвшөөрөлтэй давхацсан эсэх, давхацсан | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэсгийн чиглэлийг өөрчлөхөд хүрвэл ямар хэмжээний нэмэлт хөрөнгө шаардлагатай болох, эдгээр нь замын ашиглалтын зардалд хэрхэн нөлөөлөх гэх мэт асуудал"-ыг судалж байгаа талаар дурдсан болно. Одоогоор тус яаманд Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 467 км авто замын чиг (трасс)-тай давхцалтай аж ахуйн нэгжүүдээс давхцлын асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлт ирүүлээгүй байна. | | |
| 210 | 27 | 48 | XX.3.1.8. Эрдэнэтийн гангийн үйлдвэр байгуулах төсөл (Барилгын арматурын үйлдвэрийн төсөл)-ийн гүйцэтгэлийг эрчимжүүлэх болон Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан зээлийн өр төлбөрийг шийдвэрлэх талаар санал боловсруулж танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Б.Жавхлан нарт; | "Бэрэн групп" ХХК-ийн 2014 оноос Орхон аймагт хэрэгжүүлж байгаа 200 мян.тн/жил хүчин чадалтай ган бүтээгдэхүүний үйлдвэрийн төслийн хэрэгжилт 75 орчим хувьтай байна. Тус компани нь Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2014 онд 22.7 сая ам.доллар, 2018 онд 4.5 сая ам.доллар, нийт 27.2 сая ам.долларын зээлийн санхүүжилт авсан ба үйлдвэр ашиглалтад орж үйл ажиллагаа эхлүүлээгүйн улмаас уг зээл эргэн төлөгдөөгүй байна. Цаашид үйлдвэрийг ашиглалтад оруулахад шаардагдах 30.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэмж олгох хүсэлтийг тус компаниас Хөгжлийн банк болон УУХҮЯ-нд гаргасан ба УУХҮЯ болон Хөгжлийн банкны холбогдох удирдлагууд удаа дараагийн уулзалтуудыг зохион байгуулж, боломжит хувилбарыг судалсан. 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдөр Хөгжлийн банкны Бизнес, хөгжил хариуцсан дэд захирал З.Батырбек тус компанийн өр, зээлийн асуудлын талаар УУХҮЯ-ны ХҮБГ-ын дарга Д.Даваадоржид танилцуулсан. Мөн энэ асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлэх тухай ХҮБГ-ын даргын 2022.08.16-ны өдрийн 07/2216 дугаар албан бичгийг Хөгжлийн банкинд хүргүүлсэн. "Бэрэн групп" ХХК түүний хамаарал бүхий компаниудын тус банкнаас авсан зээл, өрийн асуудлыг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх хүсэлтийг Хөгжлийн Банкнаас 2022 оны 08 дугаар сард хүргүүлсэн. Төслийн бүтээн байгуулалтын ажил хуулийн байгууллагын шийдвэр эцэслэн гартал зогсонги байдалд байна. | 70% | |
| 211 | 27 | 49 | XX.3.1.9. Хөгжлийн төслүүдийн гүйцэтгэл, Ерөнхий сайдын 2022 оны 1 дүгээр албан даалгаврын биелэлтийг арга хэмжээ тус бүрээр гаргаж, яамдын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгжээр баталгаажуулан 2022 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн дотор Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд; | Шинэ сэргэлтийн бодлогын баримт бичигт Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээ, нийт 13 төслүүдийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж 2022 оны жилийн эцсийн байдлаар 54.06 хувьтай үнэлэгдэв. Хяналт-Шинжилгээ, үнэлгээний тайланг 2022.12.30-ний өдрийн 03/3460 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. | 100% | |
| 212 | 27 | 50 | XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын | 1. Хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Цахим гарын үсгийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний хурууны хээг таниулах үйлчилгээг халсан. 2.Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг tender.gov.mn дээр цахимаар зохион байгуулах ажлын хүрээнд аж ахуйн нэгжүүд сонгон шалгаруулалтад оролцохдоо тоон гарын үсэг | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов. | ашиглахаар байршуулсан. 3. Хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тайланг хүлээн авч, хянах, баталгаажуулах ажлыг цахимаар зохион байгуулах ажлын хүрээнд аж ахуйн нэгжүүд тус цахим системд тоон гарын үсгээр нэвтэрч төлөвлөгөө, тайлангаа баталгаажуулан ирүүлдэг болсон. 4. УУХҮЯ, АМГТГ-ын архив, албан хэрэг хөтлөлтийн ABLE системд тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлэх ажлын хүрээнд АМГТГ-ын 14 удирдах албан хаагчид тоон гарын үсгийн гэрчилгээ авч төрийн байгууллага хооронд цахимаар албан бичиг солилцох нөхцөлийг бүрдүүлсэн. 5. АМГТГ-ын 52 төрийн захиргааны албан албан хаагчид тоон гарын үсгийг холбогдох байгууллагуудаас олгуулж Геологи, уул уурхайн мэдээллийн системд нэвтэрч хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө,тайланг хянан баталгаажуулах, 6. Төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх ажлын хүрээнд Хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тайлан хүлээн авах, хянах Геологи, уул уурхайн мэдээллийн систем /ГУУМС/-д 2021 оноос эхлэн тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлж, 2022 онд 400-аад ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, 900-аад хайгуулын төлөвлөгөө, тайланг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд тоон гарын үсгээрээ баталгаажуулан цахимаар ирүүлж, АМХХ, УУХ-ийн 25 албан хаагч тоон гарын үсгээ ашиглан хянан баталгаажуулсан. 7. Төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн систем /ХУР/-д Уул уурхайн кадастрын компьютержсэн систем /УУККС/-г холбож Улсын бүртгэлийн ерөнхий газартай аж ахуйн нэгжийн мэдээлэл солилцоход АМГТГ-ын Кадастрын хэлтсийн 8 албан хаагч тоон гарын үсгийн гэрчилгээ авч ашиглаж байна. | | |
| 213 | 28 | 51 | **2022 оны 5 дугаар сарын 18-ний өдөр 29 дүгээр тэмдэглэл 2022-05-18 Дугаар 2022_29** XIY.4. . "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн үйл ажиллагаа болон газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай газрын тосны нөөцийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгав: "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн үйл ажиллагаа болон газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай газрын тосны нөөцийн талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах танилцуулгыг бэлтгэсэн. Монгол Улсын Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсгийн дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсний дараа ҮАБЗ-д тус мэдээллийг танилцуулахаар тогтсон. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд. | | | |
| 214 | 29 | 52 | **2022 оны 5 дугаар сарын 25-ны өдөр 30 дугаар тэмдэглэл 2022-05-25 Дугаар 2022_30** .4. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн төв оффисыг үйл ажиллагаа явуулж буй орон нутагт нь шилжүүлэн байршуулах талаар санал боловсруулж танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Эрдэнэс Монгол" XXK (О.Хулан) нарт даалгав. | Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн төв оффисыг үйл ажиллагаа явуулж буй орон нутагт нь шилжүүлэн байршуулах асуудлыг судалж байна Эрдэнэс Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022.10.26-ны өдрийн 385 дугаар тогтоолын 2, 3.1-т заасны дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн бүтцээс 14 нэгж /алба/-ийг татан буулгаж, нийт 53 ажилтныг үүрэгт ажлаас чөлөөлж орон тоог бууруулсан байна. | 70% | |
| 215 | 29 | 53 | XY.3. . "Чингис хаан" олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийн үйл ажиллагааны талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан "Чингис хаан" олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийн байгууламжид ОХУ-аас нийлүүлэх онгоцны түлшний импортын талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | Тагнуулын ерөнхий газрын хүсэлтийн дагуу МИАТ ТӨХК-ийн өмнөх жилүүдийн түлш шатахуун худалдан авалтын талаар болон холбогдох бусад тооцоо судалгаа, дэлгэрэнгүй мэдээллүүдийг бэлтгэн Зам тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. Зам тээврийн хөгжлийн яамнаас ҮАБЗ-д мэдээлэл хүргүүлэхээр тогтсон тул хяналтаас хасуулах саналтай. | 100% | |
| 216 | 30 | 54 | **2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл 2022-06-15 Дугаар 2022_33** XIII.1. . Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдлын талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахтай холбогдуулан | Засгийн газрын 2020 оны 105 дугаар тогтоолоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталж, бүтэц орон тооны хязгаарыг 78 байхаар тогтоосон. Тус яаманд 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар нийт 2 хөгжлийн бэрхшээлтэй албан хаагч ажиллаж байна. Энэ нь манай нийт албан хаагчдын 2.4 хувийг эзэлж байна. Ашигт малтмал газрын тосны газар нь 148 ажилтан албан хаагчтай бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй 1 ажилтан /0.7 хувь/, Үндэсний геологийн алба 35 ажилтан албан хаагчтай үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 1 ажилтан / 2.8 хувь/ тус тус ажиллаж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.8 дахь хэсгийг үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 06-ний өдрийн Б/32, 2022 оны 04 дүгээр сарын 07-ний | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хяналт тавих, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг зохих журмын дагуу дэмжиж ажиллах; 1.2. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх; 1.3. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, хамгаалах хүрээнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулж, хяналт тавьж ажиллах. | өдрийн Б/34, Б/35 тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг 3 мэргэжилтэнд гаргасан хүсэлтийн дагуу цахимаар ажиллуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих ажлын хүрээнд Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу 2022 оны 11 дүгээр сарын 01-ний байдлаар А4-1500, А5-3000 ширхэг албан бичгийн дугтуй захиалан, худалдан авалт хийж дэмжиж ажиллав. | | |
| 217 | 31 | 55 | **2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2022-06-22 Дугаар 2022_34** XII.1.2. "Монгол ган" цогцолбор I төслийн ажлыг эрчимжүүлэх чиглэлээр төслийн ТЭЗҮ, санхүүжилт, эрчим хүч, тээвэр логистик зэрэг дэд бүтцийн тулгамдсан асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 148 дугаар тогтоолоор Эдийн засаг, хөгжлийн яам /хуучнаар/ болон "Кьюо Эс Си" ХХК-ийн хооронд 2014 онд байгуулсан "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Концессын гэрээг цуцалсан. Уг тогтоолын дагуу ТӨБЗГ-аас Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг төрийн өмчит компанийн статустай болгож, бүтцийг баталж, удирдлагыг томилсон. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК нь "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Аж үйлдвэрийн сэргэлтийн хүрээнд "Шинэ сэргэлт-Монгол ган" хэлэлцүүлгийг 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан. Төслийн цахилгаан хангамжийн ТЭЗҮ, зураг төслийн ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хийлгэх, 2023 оны төсөвт суулгаж өгөх хүсэлтийг УУХҮ-ийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 01/2232 дугаар албан бичгээр Эрчим хүчний сайд Н.Тавинбэхэд, мөн өдрийн 01/2233 дугаар албан бичгээр Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт, 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/2288 дугаар албан бичгээр Сангийн сайд Б.Жавхланд тус тус хүргүүлсэн. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК нь "Монгол ган цогцолбор I" төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулж, Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжигдсэн. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | (Б.Цэнгэл), "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК (А.Ариунболд) нарт; | | | |
| 218 | 31 | 56 | XII.11. . "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан төмөр замын сүлжээг шинэчлэн сайжруулах, шинээр байгуулах болон төмөр замуудыг холбох төслийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дохиолол, холбооны тоног төхөөрөмжийн санхүүжилтийн асуудлыг шуурхай шийдвэрлэж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгав. | Төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэхэд зайлшгүй шаардлагатай хөрөнгийг санхүүжүүлэх хүрээнд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн зүгээс нийт 1.28 тэрбум төгрөгийн санхүүжилтийг төсөлд зарцуулсан байна. "Зүүнбаян төмөр зам" ХХК татан буулгасан тул Эрдэнэс Тавантолгой ХК болон Зүүнбаян төмөр зам ХХК хооронд 2022 оны 9 сард байгуулсан Тавантолгой Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хөрөнгө оруулалт санхүүжилтийн гэрээний дагуу санхүүжүүлэх боломж хязгаарлагдсан. | 100% | |
| 219 | 32 | 57 | **2022 оны 6 дугаар сарын 29-ний өдөр 35 дугаар тэмдэглэл 2022-06-29 Дугаар 2022_35** XXYII.8. . Монгол Улсад уурхайн хаалт, байгаль орчны дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн хүрээнд хэрэгжүүлж буй "Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв" жишиг төслийн бүтээн байгуулалтын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгав: 1. Монгол Улсад уурхайн хаалт, байгаль орчны нөхөн сэргээлтийн менежментийн жишиг болох, Бэрхийн уурхайд суурилсан "Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв" төслийн бүтээн байгуулалтыг төлөвлөсөн хугацаанд дуусгахад | Монгол Улсад уурхайн хаалт, байгаль орчны нөхөн сэргээлтийн менежментийн жишиг болох, Бэрхийн уурхайд суурилсан "Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв"-ийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөж байна | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төслийн нэгжийн үйл ажиллагааг эрчимжүүлж, санхүүжилтийн эх үүсвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн судалж шийдвэрлэх, жишиг нөхөн сэргээлтийн бүтээн байгуулалтын ажилд уул уурхайн салбарын төрийн өмчит томоохон компаниудын оролцоог хууль тогтоомжид нийцүүлэн хангуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт; | | | |
| 220 | 33 | 58 | **2022 оны 7 дугаар сарын 5-ны өдөр 36 дугаар тэмдэглэл 2022-07-05 Дугаар 2022_36** XX.6.1. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн явц болон газрын тос дамжуулах хоолойн төслийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Газрын тос дамжуулах хоолойн тос дамжуулах трассын дагуу инженер геологийн судалгаа хийх, дамжуулах хоолойн нарийвчилсан зураг, төсөл боловсруулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд; | Норинко компанитай байгуулсан гэрээний барилга угсралтын төлөвлөгөөний дагуу 2022.07.20-ны өдрөөс эхлэн тос дамжуулах хоолойн трассын дагуу байр зүйн зураглал, инженер геодези, хээрийн судалгааны ажлыг эхлүүлж нарийвчилсан солбицлын цэгүүдийг тодорхойлон хоолойн трассын тэнхлэгээс 2 тал руу тус бүр 100 метр (нийт 200 м) зурвас газарт аливаа газрын давхцлыг арилгасан. Дорноговь аймагт 1334.66 га, Дорнод аймагт 1386.2 га газрыг дамжуулах хоолойн хэрэгцээнд зориулан "Улсын тусгай хэрэгцээ"-нд авахыг тус аймгийн ИТХ-аар дэмжсэн шийдвэр гарсан. Сүхбаатар аймгийн ИТХ-ын 12-р сарын хурлаар тус аймагт хамаарах дамжуулах хоолойн газрын асуудлыг хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. Сүхбаатар аймгийн Сүхбаатар сум, Халзан сум, Дорноговь аймгийн Дэлгэрэх сум, Дорнод аймгийн Матад сумын ИТХ-ын шийдвэрээр халаах-өргөх станцуудын хэрэгцээнд газар олгохыг дэмжсэн шийдвэр гарсан. Газрыг гэрчилгээжүүлэхээр газар эзэмших хүсэлт, дагалдах баримт бичгийн бүрдэлийг хангаж тус сумдын Засаг дарга болон газрын албанд хүргүүлээд байна. Барилга угсралтын үеийн түр кемпүүдийн барилгын ажлыг эхүүлээд барилга угсралтын ажил -35%, түр замын ажил -15%, Геодезийн цэг тэмдэгт суулгах ажил -100%, байр зүйн зураглалын судалгааны ажил -100%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил -60%, геотехникийн судалгааны ажил -80%, дээжлэлт шинжилгээ -80%. Канад улсын Ворлэй Инженеринг компани дамжуулах хоолойн Суурь Инженерчлэлийн Загвар (FEED) боловсруулах ажлыг 10-р сарын 15-ны өдрөөс эхлүүлээд ажил -25% байна. БОАЖЯ-аас байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт хийгдсэн. БОННҮ хийх ажил -90% хийгдэж байна. Засгийн газрын 2022.09.22-ны өдрийн хуралдааны 46 дугаар тэмдэглэл, 2022.10.05-ны өдрийн 362 дугаар тогтоолоор нүүрс урьдчилан борлуулах нөхцөлтэй гэрээнүүдийн хэрэгжилтийг 2022 оныг дуустал хойшлуулах шийдвэр гарсан нь хоолойн төслийн төлөвлөгөөт ажил удаашрах, Норинко компанитай байгуулсан гэрээний хэрэгжилт хойшлох нөхцөлд ороод | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | байна. Уг шийдвэрийн дагуу тос дамжуулах хоолойн төслийн санхүүжилт зогссонтой холбогдуулан нүүрс худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилтийг хангуулах талаарх холбогдох арга хэмжээ авч өгөх хүсэлтийг 2022.11.17-ны өдрийн 01/3035 тоотоор ЗГ-ын ХЭГ, ЭТТ ХК-ийн ТУЗ-д тус тус хүргүүлсэн. | | |
| 221 | 33 | 59 | XX.6.2. Газрын тос боловсруулах үйлдвэрт ажиллах нарийн мэргэжлийн инженер, техникийн ажилчдыг сургаж бэлтгэхэд шаардагдах эх үүсвэрийн асуудлыг судалж танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; | ШУТИС, МУИС-иудтай хамтран сургалтын төлөвлөгөөг боловсруулж ШУТИС-ийн "Хөтөлбөрийн дэд хороо", "Хөтөлбөрийн ерөнхий хороо"-гоор хэлэлцүүлэн Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлд оруулсан. Мөн "Газрын тосны инженерчлэл" бакалаврын хөтөлбөрт БШУ-ны сайдын 2022.05.09-ний өдрийн А/160-р тушаалаар 072407 тоот индекс авсан. Тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний сургалтын сангийн хөрөнгөөс шийдвэрлэхээр ажиллаж байна | 70% | |
| 222 | 34 | 60 | **2022 оны 8 дугаар сарын 3-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2022-08-03 Дугаар 2022_39** XYIII.3.1.5. Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 467 км авто замын бүтээн байгуулалтын талбайтай давхцал бүхий газрын асуудлыг 2022 оны 8 дугаар сард багтаан шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт; | Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 467 км авто замын чиг (трасс)-ийн давхцалын асуудлаар тус яамнаас 2022.04.28-ны өдрийн 03/1215 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яамнаас тодруулга хүссэн. Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2022.05.17-ны өдрийн 03/2238 дугаар албан бичгээр тус яаманд хариу ирүүлсэн бөгөөд уг албан бичигт концессын гэрээ эзэмшигч "Тахилт хайрхан транс" ХХК нь "...замын трасс нь тусгай зөвшөөрөлтэй давхацсан эсэх, давхацсан хэсгийн чиглэлийг өөрчлөхөд хүрвэл ямар хэмжээний нэмэлт хөрөнгө шаардлагатай болох, эдгээр нь замын ашиглалтын зардалд хэрхэн нөлөөлөх гэх мэт асуудал"-ыг судалж байгаа талаар дурдсан болно. Одоогоор тус яаманд Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 467 км авто замын чиг (трасс)-тай давхцалтай аж ахуйн нэгжүүдээс давхцалын асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлт ирүүлээгүй байна. | 70% | |
| 223 | 34 | 61 | XYIII.3.11. Хөгжлийн төслүүдийн хэрэгжих байршил, төслийн нийт төсөвт өртөг, санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд, техник, эдийн засгийн үндэслэл, ажлын зураг, газар, байгаль орчны үнэлгээ, дэд бүтэц, төслийн хүрээнд барьж байгуулах барилга байгууламж, бий болгох бүтээгдэхүүн, үйлчилгээ, зах зээлийн төлөв байдал болон холбогдох судалгаа, шинжилгээний мэдээлэл бүхий танилцуулгыг англи хэл дээр бэлтгэн 2022 оны 8 дугаар сард багтаан Гадаад харилцааны яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд тус тус | УУХҮ-ийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 01/2820 дугаар албан бичгээр "Шинэ сэргэлтийн бодлого"-д салбарын хүрээнд тусгагдсан төслүүдийн талаарх мэдээллийг, хэрэгжилтийн хамт боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хүргүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүдэд; | | | |
| 224 | 34 | 62 | XYIII.3.2.7. Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийн бүтцийг нарийвчлан тогтоож зохиомол хомсдол, далимдуулсан үнийн хөөрөгдлөөс сэргийлэх, бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт, тээвэр, логистикийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах ажлыг харьяа салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх, холбогдох байгууллагуудтай нягт хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд, инфляцын шалтгаан, нөхцөлийг судалж, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийг бууруулахад чиглэсэн тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох салбарын төлөөллийг оролцуулан яаралтай байгуулж ажиллуулахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Засгийн газрын холбогдох гишүүдэд; | Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Засгийн газрын 160 дугаар тогтоолын дагуу АИ-92 автобензиний нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөл бүхий 14 аж ахуйн нэгжтэй АИ-92 автобензиний нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах талаарх "Хариуцлагын гэрээ" байгуулсан. Хариуцлагын гэрээ байгуулсан нэр бүхий 14 аж ахуйн нэгжүүдээс АИ-92 автобензиний тухайн сарын гадаад захиалга, импорт, үлдэгдэл, нөөц, үнийн мэдээ, тайланг 7 хоног бүрийн мягмар гарагт тогтмол үлдэгдэл, үнийн мэдээллийг авч, яамны цахим мэдээлэлд байршуулан, хяналт тавин ажиллаж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас шатахууны үнийн өсөлтийг саарууулах зорилгоор газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч ОХУ-ын Роснефть компанитай хэлцэл хийж, 2022 оны 4,5,6 дугаар саруудад нийлүүлэх 120 мянган тонн Аи-92 автобензинийн хил үнийг тонн тутамд 840 ам.доллароор худалдан авах хэлцэл хийж, Аи-92 автобензинийн жижиглэн борлуулалтын үнийг 2,390 төг/л болгон тогтворжуулсан. 2022 оны 07 дугаар сард ОХУ-ын Роснефть компанитай дахин хэлцэл хийсний үр дүнд энэ оны 12 дугаар сарыг дуустал Аи-92 автобензинийн үнийг тонн тутамд 830 ам.доллароор худалдан авах талаар тохиролцоонд хүрсэн. Түүнчлэн гадаад зах зээл дээрх газрын тосны үнийн бууралт, Роснефть компанитай хийсэн хэлцлийн дүнд 2023 оны 1 дүгээр сараас дизель түлшийг зах зээлийн үнээс 10 хувь хямд үнээр авах, Аи 92 автобензинийг тонн тутамд 815 ам.доллараар худалдан авахаар тус тус тохиролцоод байна. | 70% | |
| 225 | 35 | 63 | **2022 оны 8 дугаар сарын 10-ны өдөр 40 дүгээр тэмдэглэл 2022-08-10 Дугаар 2022_40** XIII.9. . Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн өнөөгийн нөхцөл байдал, тусгай зөвшөөрлийг олгох цахим технологид суурилсан сонгон шалгаруулалтын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн өнөөгийн нөхцөл байдал, тусгай зөвшөөрлийг олгох | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашид анхаарах зүйлс, шинээр авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын танилцуулгыг 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдөр танилцуулсан. УАБЗ-ийн 2022.11.25-ны өдрийн 03 дугаар зөвлөмж албажин УУХҮЯ-д ирсэн. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | цахим технологид суурилсан сонгон шалгаруулалтын талаарх саналыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | | | |
| 226 | 36 | 64 | **2022 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл 2022-08-17 Дугаар 2022_41** YIII.1.. Үргац хураалтын бэлтгэл ажил, тариалангийн бүс нутгийн дизель түлшний үнэ, хангамж, үнийн өсөлтөөс сэргийлэх талаар авах арга хэмжээний саналыг боловсруулан Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж, Засгийн газрын дараагийн хуралдаанд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт тус тус даалгав; | Намрын ургац хураалт, уринш боловсруулалтын ажлыг хугацаанд нь чанартай зохион байгуулахад шаардагдах дизель түлшний үнийг хаврын тариалалтын үеийн үнэтэй ижил түвшинд байхаар тооцож, зөрүүг аж ахуйн нэгжид олгох зохион байгуулалтын арга хэмжээ авах ажлын хэсэгт шаардлагатай тооцоо судалгаа, мэдээлэлээр хангаж ажилласан | 100% | |
| 227 | 37 | 65 | **2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42** YIII.2. 2. "Геологийн судалгаа-шинжилгээний төв"-ийн захирал, ерөнхий инженер, ерөнхий геологийн ажлын байрыг нээлттэй сонгон шалгаруулж томилох арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Үндэсний геологийн алба (О.Чулуун), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.10.28-ны өдрийн А/274 дүгээр тушаалаар "Геологийн судалгаа-шинжилгээний төв"-ийн захирал, ерөнхий инженер, ерөнхий геологийн ажлын байрыг нээлттэй сонгон шалгаруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. "Геологийн судалгаа-шинжилгээний төв"-ийн захирлын албан тушаалд 5 нэр дэвшигчдийн материалыг хүлээн авсан. Ерөнхий инженер, ерөнхий геологийн ажлын байрыг тусад нь нээлттэй сонгон шалгаруулж байна. "Геологийн судалгаа-шинжилгээний төв"-ийн захирлаар Д.Мөнхбаатар 2023.01.13-ны өдөр томилогдож, тамгаа хүлээн авсан. | 70% | |
| 228 | 37 | 66 | XY.2.4. Газрын тосны боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын зорилгоор Хөгжлийн банкнаас авсан зээлийн зарцуулалт, зээлийг чанаргүй болохоос сэргийлж цаашид авах арга хэмжээний талаар Засгийн газрын дараагийн хуралдаанд танилцуулахыг | УУХҮС-ын 2022.08.03-ны өдрийн А/197 дугаар тушаалаар, төслийн санхүүжилт болон Хөгжлийн банкны санхүүжилтэд үүсээд буй асуудлыг шийдвэрлэх талаар санал боловсруулж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Дэд сайдаар ахлуулан байгуулсан ба Ажлын хэсэг ажиллаж байна | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Б.Жавхланд. | | | |
| 229 | 38 | 67 | **2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр 46 дугаар тэмдэглэл 2022-09-22 Дугаар 2022_46** Х.10. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ)-ийг тооцож байгаа асуудлыг дахин нягтлан үзэх, уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдээс тавьж буй асуудлыг судлан үзэж, холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт; | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022.12.23-ны өдрийн 100 дугаар тушаалаар Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн талаар судлан үзэж холбогдох хууль, тогтоомжийг боловсронгуй болгох эсэх асуудлаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэгт тус яамны холбогдох албан тушаалтнууд ажиллаж байна. | 70% | |
| 230 | 38 | 68 | Х.12. Гадаадын ажиллагчдад тавих дотоод хяналтыг сайжруулах, гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний квотыг өөрчлөх санал боловсруулж танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр)-т; | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасны дагуу Гадаадаас ажиллах хүчний 2023 оны хувь хэмжээг тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төсөлд салбарын квотыг дахин нэмэгдүүлж, "уул уурхай, олборлолт" хэсгийн 6000 гэснийг 8000 хүргэх саналыг ХНХС-д 2022 оны 10 сарын 10-ны өдрийн 01/2673 тоотоор хүргүүлсэн. | 70% | |
| 231 | 38 | 69 | Х.4.1. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 103 дугаар тогтоолын 1 дэх заалтын 3-т заасан Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтэд хөндлөнгийн аудит хийлгэх ажлыг эрчимжүүлж, ажлын явцыг 2022 оны 10 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг "Эрдэнэс Оюу Толгой" ХХК (Н.Цэрэнбат)-д; | Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтэд хөндлөнгийн аудит хийлгэх Ажлын даалгаварыг Оюутолгой ХХК-ийн тусгай хорооны хурлаар баталсан. | 30% | |
| 232 | 38 | 70 | Х.7.1. Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-аас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтийг нүүрсээр барагдуулах (оффтэйк) нөхцөлтэй болон төлбөрийг | -Оффтэйк гэрээнүүдийн нийлүүлэлтийг Эрдэнэс Тавантолгой ХК-н ачилтын өдрийн квот болох 360 тээврийн хэрэгслийн 15% буюу 54 тээврийн хэрэгслээс хэтрэхгүй байхаар ачилтын хэмжээг бууруулан ажиллаж байна. -Их хэмжээний урьдчилгаа төлбөр авсан гэрээнүүдийн Худалдан авагч нартай дахин хэлцэл хийснээр нийт ачилтын 50%-иас багагүй дүнг бэлэн төлөлтөөр нэмж төлөх, үлдсэнийг өмнө нь төлсөн урьдчилгаа төлбөрөөс суутгах зарчмаар 2020 он | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | урьдчилан авч ашигласан гэрээнүүдийн хэрэгжилтийг 2022 он дуустал хойшлуулах арга хэмжээ авах, богино хугацаанд гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх хувилбараар нүүрсний борлуулалт, нийлүүлэлтийг зохион байгуулж ажиллахыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар)-д, тус үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт даалгав; | дуустал зохион байгуулсан. -Уулын ажлын хөлсийг нүүрсээр барагдуулах гэрээнүүдийн ачилтыг бүрэн зогсоосон. | | |
| 233 | 39 | 71 | **2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр 48 дугаар тэмдэглэл 2022-10-05 Дугаар 2022_48** XII.1.2. Дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав: 2.1. Эрхлэх асуудлын хүрээнд стандарт, техникийн зохицуулалтын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; 2.2. "Үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 235 дугаар тогтоолын хэрэгжилтийг дүгнэж, салбарын шаардлагатай стандарт, техникийн зохицуулалтыг 2022 онд багтаан боловсруулж, батлуулахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд; | Уул уурхайн салбарт мөрдөгдөж байгаа стандарт, техникийн зохицуулалтын баримт бичгүүдийг судалж байна. | 30% | |
| 233 | 39 | 72 | XII.3. . 1. Засгийн газраас 2020-2024 онд санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн хүрээнд: 1.1. "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль | Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны А/93 дугаар тушаалаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулж, ажлын хэсэг тус хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоол болон Засгийн газрын 2020 оны 66 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын төлөвлөгөө"-нд тусгагдсан хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж, 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт; | боловсруулж, 2022.01.05-ны өдөр Улсын Их хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн барьсан.Улсын Их хурал хуулийн төслийг 2022.12.23-ны өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцэж, баталсан.<br>Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.10.27-ны өдрийн А/273 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан.<br>Ажлын хэсэг хуулийн төсөл болон үзэл баримтлалын төслийг боловсруулаад байна.<br>Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж, хуулийн төсөлд яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамнаас 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг ЗГХЭГ-аар дамжуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бүрдлийг ханган хүргүүлсэн. Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу 2022.11.01-ний өдөр хуулийн төсөл, дагалдах хууль болон холбогдох бусад бичиг баримтуудыг буцаахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт албан бичиг төлөвлөн хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" 192 дугаар захирамжаар Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Улмаар тус Ажлын хэсгийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн сайд ажиллах болсон тул холбогдох материалуудыг 2022 оын 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/3297 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайдад шилжүүлсэн. | | |
| 234 | 40 | 73 | **2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл** | Агаарын хөлгийн шатахууны үнийг бууруулах зорилтын хүрээнд Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7.2 заалтад нэмэлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын Эдийн засгийн байнгын | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **2022-10-10**<br>**Дугаар 2022_49**<br>III.1. Агаарын хөлгийн шатахууны үнийг бууруулах, шатахууны улсын нөөц бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт даалгав. | хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулсан. "Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүний 30-аас дээш хувийг дангаараа нийлүүлж байгаа гадаадын хуулийн этгээд дотоодын зах зээлд өөрийн хөрөнгө оруулалт бүхий хуулийн этгээд болон өөрийн харъяалал, хяналтад байдаг нэгжээрээ дамжуулан бүтээгдэхүүнээ борлуулахыг хориглоно” гэсэн заалтыг “дамжуулан” гэсний дараа “агаарын хөлгийн түлшнээс бусад” гэж нэмсүгэй гэж өөрчлөн УИХ-ын нэгдсэн чуулганы 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. | | |
| 235 | 40 | 74 | XII.5.2. Байгууллагын мэдээллийн системийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын үүлэн системд байршуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагад даалгав. | 1. УУХҮЯ, АМГТГ-ын байгууллагын мэдээллийн системүүдийг “Үндэсний дата төв” /ҮДТ/-д байршуулахаар ажиллаж байгаа ба ҮДТ-өөс шаардлагад нийцсэн сервер, бусад тоног төхөөрөмжийг суурилуулах шаардлагыг тавьсан ба асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. 2. Үүний хүрээнд ҮДТ-ийн мэргэжилтнүүдтэй уулзахаар 2022 оны 12 дугаар сард хүсэлт хүргүүлсэн. ABLE бичиг хэрэг хөтлөлтийн системийг ҮДТ-ийн клауд үүлэн систем дээр холбон байршуулсан. | 30% | |
| 236 | 41 | 75 | **2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 50 дугаар тэмдэглэл**<br>**2022-10-19**<br>**Дугаар 2022_50**<br>ҮI.2. Засгийн газрын 2011 оны 349 дүгээр тогтоолын дагуу автобензин, дизель түлшний улсын нөөц бүрдүүлсэн ажлын явц, түүний зарцуулалт, цаашид авах арга хэмжээний талаарх саналаа 11 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал) нарт даалгав. | Тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу холбогдох танилцуулга, цаашид авах арга хэмжээний талаарх саналыг нэгтгэн боловсруулж, УУХҮ-ийн сайдын 2022.12.16-ны өдрийн 01/3312 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын хуралдаанд танилцуулсан | 100% | |
| 237 | 41 | 76 | ҮI.3. Онгоцны шатахууны хангамжийг сайжруулах, улсын нөөц бүрдүүлэх саналыг нэгтгэж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт даалгав. | Онгоцны түлшний хангамжийг сайжруулах ажлыг зохион байгуулах үүргийн хүрээнд Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7.2 заалтад нэмэлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулсан. "Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүний 30-аас дээш хувийг дангаараа нийлүүлж байгаа гадаадын хуулийн этгээд дотоодын зах зээлд өөрийн хөрөнгө оруулалт бүхий хуулийн этгээд болон өөрийн харъяалал, хяналтад байдаг нэгжээрээ дамжуулан бүтээгдэхүүнээ борлуулахыг хориглоно” гэсэн | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | заалтыг "дамжуулан" гэсний дараа "агаарын хөлгийн түлшнээс бусад" гэж нэмсүгэй гэж өөрчлөн УИХ-ын нэгдсэн чуулганы 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. | | |
| 238 | 41 | 77 | YI.3. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг хадгалах стандартад нийцсэн агуулах, сав барьж байгуулах санхүүжилтийн эх үүсвэрийн асуудлыг судалж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт даалгав. | Тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу холбогдох танилцуулга, цаашид авах арга хэмжээний талаарх саналыг нэгтгэн боловсруулж, УУХҮ-ийн сайдын 2022.12.16-ны өдрийн 01/3312 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. | 100% | |
| 239 | 42 | 78 | **2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр 52 дугаар тэмдэглэл 2022-10-26 Дугаар 2022_52** Х.1. . Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт хэрэгжүүлж байгаа газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хэрэгжилтийн явцын талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авахыг дор дурдсан албан тушаалтанд даалгав: 1. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн Анхдагч процесс, Дагалдах байгууламжууд (EPC-2)-ын болон Үйлдвэрийн цахилгаан станцын ажил (EPC-3)-ын сонгон шалгаруулалтад шаардлага хангасан тендерийн санал ирүүлсэн оролцогчтой холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулах арга хэмжээ авахыг захиалагч "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг; | "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК, "Megha Engineering & Infrastructure Limited" компани хооронд 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр гэрээ байгуулсан. Лицензгүй технологийн байгууламжийн ажил /EPC-2/ , Цахилгаан станцын барилгын /EPC-3/ ерөнхий гүйцэтгэгч "Мега Инженеринг Инфраструкчр" нь барилгын ажлын өмнөх инженер геологийн судалгаа, геодезын хэмжилтийн ажлыг хийж байгаа бөгөөд ажлын зураг төсөл инженерчлэлийн ажил хийгдэж байна. | 70% | |
| 240 | 42 | 79 | Х.1. . Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангахад шаардагдах газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх, газрын | Х.1. . Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангахад шаардагдах газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх, газрын тосны нөөц шинээр тогтоох боломжтой талбайн талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тосны нөөц шинээр тогтоох боломжтой талбайн талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт; | Ж.Ганбаатарт; Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлаар танилцуулга, мэдээлэл бэлтгэн 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 25 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. Уг тэмдэглэлд газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны хайгуул, ашиглалтын бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайг хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын газрын нэгдмэл санд бүртгэх, газар ашиглах гэрчилгээ олгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд дэмжиж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасан. Цаашид газрын тосны хайгуулын талбайнуудад нөөц тогтоох боломжтой Галба-11, Тариач-15, Баянтүмэн-17, Хөх нуур-18, Давст-31, Ар булаг-29 зэрэг талбайн мэдээллийг 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн Засгийн газрын ээлжит бус цахим хуралдаанд танилцуулж ажилласан болно. | | |
| 241 | 43 | 80 | **2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2022-11-09 Дугаар 2022_54** Х.8.5. Уул уурхайн биржийн тогтолцооны цахим системийг бүрдүүлэх зорилгоор уул уурхайн бүтээгдэхүүнийг цахимаар нээлттэй арилжих харилцааг зохицуулах түр журмыг 2022 онд багтаан боловсруулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт; | Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам"-ыг боловсруулж бусад яамд болон холбогдох бусад байгууллагаас санал авахаар 2022.12.01-ний өдөр 01/3180 дугаар албан бичгийг хүргүүлээд байна. Тус албан бичигтэй холбогдуулан яам болон холбогдох бусад байгууллагаас ирсэн албан бичгүүдийг нэгтэн, журмын төсөлд тусган Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 466 дугаар тогтоолоор журам батлагдсан. | 100% | |
| 242 | 43 | 81 | Х.8.7. Төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ашигт малтмалыг худалдах, экспортлох, тээвэрлэх гэрээ, гэрээний нөхцөлийг судалж, дүнг 2022 онд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар нарт; | Эдийн засаг, хөгжлийн яамны нууц хамгаалах ажилтанд 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 171 гэрээ, Монголросцетвет ТӨҮГ-ын 18 гэрээ, 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 27 гэрээ, Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийн 6 гэрээ, нийт 222 гэрээг зохих журмын дагуу хүргүүлсэн. | 70% | |
| 243 | 43 | 82 | Х.8.11. "Монголросцветмет" ТӨҮГ-ын туршилтын журмаар олборлосон цайрын хүдрийн төрөл, тоо, хэмжээг бүртгэж экспортод гаргахад шаардлагатай зөвшөөрлийг | "Монголросцветмет" ТӨҮГ-ын туршилтын журмаар олборлосон цайрын хүдрийн төрөл, тоо хэмжээг бүртгэж, экспортод гаргахад шаардлагатай зөвшөөрлийг холбогдох журмын дагуу олгуулах асуудлаар "Монголросцветмет" ТӨҮГ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас дэмжлэг хүссэн албан тоотыг ирүүлсэн. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | холбогдох журмын дагуу олгохыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж)-т; | "Монголросцветмет" ТӨҮГ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт, УУХҮЯ-наас "Монголросцветмет" ТӨҮГ-ийг цайрын баяжмал экспортлохыг дэмжиж, худалдан борлуулах ажиллагааг Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын дагуу зохион байгуулах үүрэг өгсөн албан тоотын төслийг боловсруулаад байна. | | |
| 244 | 43 | 83 | Х.8.12. Төв аймгийн Заамар сумын нутаг дэвсгэрт "Монголросцветмет" ТӨҮГ-ын ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй холбоотойгоор байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг яаралтай судлан үзэж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх арга хэмжээ авахыг Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, "Монголросцветмет" ТӨҮГ (Б.Мөнхбат)-т; | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудалд хамааралгүй тул үнэлэх боломжгүй. | /-/ | |
| 245 | 43 | 84 | Х.8.14. Уул уурхайн олборлолт, тээвэрлэлтийн хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай дизель түлшний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байлгах талаар арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт; | Оросын холбооны улсын роснефть компанитай хэлцэл хийж 11,12 сард нийлүүлэх дизель түлшийг худалдан авах тогтвортой нийлүүлэх талаар тохирсон. Мөн БНХАУ-н Петрочайна интернэйшнл компаний Хөх хотын ГТБҮ-ээс нэмэлтээр шаардлагатай 21000 тн дизель түлшийг худалдан авахаар тохиролцож 11,12 дугаар сард Монгол улсад импортлосон. | 100% | |
| 246 | 43 | 85 | Х.11.2. "Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем"-ийг байгууллагын үйл ажиллагаанд уялдуулан зохион байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллахыг зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтныг харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч нарт; | Монгол Улсын Засгийн газраас Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгаж, чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх болсонтой холбогдуулан Засгийн газрын 2020 оны "Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" 105 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, удирдлагаар хянуулж байна. | /-/ | |
| 247 | 44 | 86 | **2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58** ХХI.1.2. Гадаад валютын нөөц бүрдүүлэх чиглэлээр төрийн өмчит аж ахуйн нэгжүүд санаачилгатай ажиллах, валютын гарч буй урсгалыг бууруулах зорилгоор шаардлагагүй худалдан авах ажиллагаа болон гадаад томилолтыг хориглох, төсвийн | Засгийн газрын 2022 оны хуралдааны 58 дугаар тэмдэглэлийн дагуу төрийн өмчит аж ахуйн нэгжүүд баяр, ёслолын арга хэмжээ болон гадаад томилолтыг зохион байгуулаагүй. Эрдэнэс Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022.10.26-ны өдрийн 385 дугаар тогтоолын 2, 3.1-д хэсэгт заасны дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн бүтцээс 14 нэгж /алба/-ийг татан буулгаж, нийт 53 ажилтныг үүрэгт ажлаас чөлөөлж орон тоог бууруулсан. Эрдэнэс Тавантолгой ХК нь Засгийн газрын шийдвэрийн дагуу 2022 онд төлөвлөсөн нийт 37 тендер шалгаруулалтыг зогсоосон ба Худалдан авалтын төлөвлөгөөнд тусгасан төсөл арга хэмжээг ач холбогдлоор нь ангилан, 2023 оны төсөвт суулган худалдан авалт хийх боломжтой | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хөрөнгөөр шинэ жилийн баяр тэмдэглэхгүй байх, орон тоог бууруулах, урсгал зардлыг хэмнэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, тэдгээрийг томилох эрх бүхий этгээдэд; | төслийн худалдан авалтыг зохион байгуулахгүйгээр шийдвэрлэсэн. 2022 оны төсвийн жилд шаардлагагүй худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд гадаад томилолтыг хязгаарлаж, тэвчиж болгох урсгал зардлыг хэмнэх ажилласан. | | |
| 248 | 44 | 87 | XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов; | - Дотоод албан бичиг хөтлөлтөд ABLE системийг ашиглаж байна. ЦХХХЯ-аас хэрэгжүүлж буй Төрийн байгууллагуудын албан бичиг солилцооны дундын систем (DocX)-д холбогдох туршилтын ажилд оролцож туршилт хийгдэж байна. - АМГТГ нь цахим бичиг баримт солилцох үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 2022 онд архив, албан хэрэг хөтлөлтийн АБЛЕ программыг хөгжүүлэгч АБЛЕ софт ХХК болон Үндэсний дата төв УҮГ-тай хамтран ажиллаж АБЛЕ программаа төрийн албан бичиг солилцооны дундын систем docs.gov.mn-д холбуулж удирдах 15 албан хаагчид тоон гарын үсгийн гэрчилгээг холбогдох байгууллагуудаас авсан. УУХҮЯ, АМГТГ-ын дотоод архив, албан хэрэг хөтлөлтийн ABLE системд тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлэх ажлын хүрээнд удирдах албан хаагчид тоон гарын үсгийн гэрчилгээ авч цахимаар албан бичиг солилцох нөхцөлийг бүрдүүлсэн | 70% | |
| 249 | 45 | 88 | **2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 60 дугаар тэмдэглэл 2022-12-21 Дугаар 2022_62** XYI.1. . "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хөгжлийн төслүүдийн хэрэгжилтийн явцын талаар Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хөгжлийн төслүүдийн судалгаа, тооцооллыг хийж, эдийн засгийн болон нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлэх, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтаас хасах шаардлагатай төслийн саналаа тодорхой үндэслэл, судалгаатай боловсруулж Эдийн | "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хөгжлийн төслүүдийн хэрэгжилтийн явцын талаар Эдийн засаг, хөгжлийн яаманд сар бүр хэрэгжилтийн хувийг илгээж байна. Мөн УУХҮЯ-нд харьяалагдаж буй 13 төсөл, хөтөлбөрүүдийг ач холбогдолоор эрэмблэн Эдийн засаг, хөгжлийн яамны удирдлагуудтай зөвшилцөж Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэр төсөл буюу "Бэрэн групп" ХХК-ийн хэрэгжүүлэх гангийн үйлдвэрийг хасаж, "Эрдэнэс таван толгой" ХК-ийн далд уурхайн төслийн хэрэжих хугацааг сунгахаар тогтов. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | засаг, хөгжлийн яаманд хүргүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгав. | | | |
| | | | 1.3. Засгийн газрын албан даалгавар | | | |
| 251 | 1 | 1 | **Бүтээн байгуулалтын төсөл, бодлогын зарим арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2021-09-15 Дугаар 2021_01**<br>12.1. 12.Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд: 12.1.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан хэлэлцүүлэх; | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж, хуулийн төсөлд яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамнаас 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг ЗГХЭГ-аар дамжуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бүрдлийг ханган хүргүүлсэн. Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу 2022.11.01-ний өдөр хуулийн төсөл, дагалдах хууль болон холбогдох бусад бичиг баримтуудыг буцаахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт албан бичиг төлөвлөн хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" 192 дугаар захирамжаар Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Ажлын хэсгийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн сайд ажиллах болсон тул холбогдох материалуудыг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/3297 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайдад шилжүүлсэн. | 100% | |
| 252 | 1 | 2 | 12.3. 12.3.Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн бүтээн байгуулалтад байнгын хяналт тавьж, газрын түүхий тос дамжуулах хоолойн барилга угсралтын ажлыг шуурхай эхлүүлэх; | Дорноговь аймагт 1334.66 га, Дорнод аймагт 1386.2 га газрыг дамжуулах хоолойн хэрэгцээнд зориулан "Улсын тусгай хэрэгцээ"-нд авахыг тус аймгийн ИТХ-аар дэмжсэн шийдвэр гарсан. Сүхбаатар аймгийн ИТХ-ын 12-р сарын хурлаар тус аймагт хамаарах дамжуулах хоолойн газрын асуудлыг хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. Сүхбаатар аймгийн Сүхбаатар сум, Халзан сум, Дорноговь аймгийн Дэлгэрэх сум, Дорнод аймгийн Матад сумын ИТХ-ын шийдвэрээр халаах-өргөх станцуудын хэрэгцээнд газар олгохыг дэмжсэн шийдвэр гарсан. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Газрыг гэрчилгээжүүлэхээр газар эзэмших хүсэлт, дагалдах баримт бичгийн бүрдлийг хангаж тус сумдын Засаг дарга болон газрын албанд хүргүүлээд байна. Барилга угсралтын үеийн түр кемпүүдийн барилгын ажлыг эхлүүлээд барилга угсралтын ажил -35%, түр замын ажил -15%, Геодезийн цэг тэмдэгт суулгах ажил -100%, байр зүйн зураглалын судалгааны ажил -100%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил -60%, геотехникийн судалгааны ажил -80%, дээжлэлт шинжилгээ -80%. Тосон-Уул 19, Тамсаг XXI талбайн нэгдсэн байгууламжаас 17,5 л ба 16,7л дээж авч тосны дээж авсан. Тус дээжийг БНХАУ-ын Шанхай хот дахь Intertek компанийн лабораторид илгээсэн, хариу хүлээгдэж байна. Канад улын Ворлэй Инженеринг компани дамжуулах хоолойн Суурь Инженерчлэлийн Загвар (FEED) боловсруулах ажлыг 10-р сарын 15-ны өдрөөс эхлүүлээд ажил -25% байна. БОАЖЯ-аас байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт хийгдсэн. БОННҮ хийх ажил -90% хийгдэж байна. | | |
| 253 | 1 | 3 | 12.4. 12.4.Зэс хайлуулах үйлдвэр барих төслийн ТЭЗҮ, холбогдох бусад тооцоо, судалгаа, эх үүсвэрийн төсөөлөл, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж хэлэлцүүлэх; | "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах" төслийн хэрэгжилтийн явц, цаашид авах арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг бэлтгэн УУХҮ-ийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01/127 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон боловч удаа дараа хойшлогдсон. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дүгээр "Албан даалгавар"-аар даалгасны дагуу "Эрдэнэт, Оюутолгой зэрэг ордыг иж бүрэн ашиглаж, зэсийн боловсруулалтыг нэмэгдүүлэх төслүүдийн талаар" Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар УУХҮ-ийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 01/1590 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын "China ENFI Engineering" компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Тус ТЭЗҮ-д тооцсоноор төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 762,255.12 ам доллар байх бөгөөд үүний 30%-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгөөр, 70%-ийг зээлээр санхүүжүүлэхээр тусгасан. Батлагдсан ТЭЗҮ-ээр үйлдвэр нь жилд 560 мянган тонн зэсийн баяжмал боловсруулж 125.5 мян.тн катодын зэс, 72 кг алт, 38.2 мян.тн мөнгө, 181.9 мян.тн элементийн хүхэр, 11.8 мян.тн хүхрийн хүчил үйлдвэрлэж, жилд дунджаар 1,113.65 сая ам.долларын борлуулалтын орлого олж, 1,040.34 сая ам.долларын зардал гарган, 56.8 сая ам.долларын цэвэр ашигтай ажиллана. Улсын төсөвт татвар, хураамж хэлбэрээр жил бүр 18.5 сая ам.долларыг төвлөрүүлнэ. Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 7.7 жил байна. Тус ТЭЗҮ-д үндэслэсэн | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, үйлдвэрийн зураг төслийн ажил хийгдэж байна. | | |
| 254 | 1 | 4 | 12.6. 12.6.Хар төмөрлөгийн (кокс, ширэм, шууд ангижруулсан төмөр) үйлдвэрлэлийг Дархан-Уул, Орхон, Дорноговь аймагт хөгжүүлэх асуудлыг судлан ТЭЗҮ, холбогдох бусад тооцоо, судалгаа, эх үүсвэрийн төсөөлөл, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх; | 2022 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд УУХҮСайд Г.Ёндон "Болдтөмөр Ерөө гол" ХХК-ийн Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт хэрэгжүүлж байгаа "Алтанширээт аж үйлдвэрийн парк" байгуулах төслийн ажлын явц, тулгамдаж байгаа асуудлаар танилцуулга, Засгийн газрын тэмдэглэлийн төсөл боловсруулж танилцуулсан. ЭЗХЯ-аас 2022 оны 3 дугаар сард гаргасан хуваарийн дагуу Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хар төмөрлөгийн чиглэлээр тусгагдсан Дархан-Уул аймагт хэрэгжүүлж байгаа "Монгол ган цогцолбор I" төслийг 2022 оны 03 дугаар сарын 23-нд, Орхон аймагт хэрэгжүүлж байгаа Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийн төслийг 2022 оны 05 дугаар сарын 04-нд Засгийн газрын хуралдаанд танилцуулах хуваарийн дагуу төслүүдийн явц, тулгамдаж байгаа асуудлын талаар танилцуулга бэлтгэж, холбогдох шийдвэрийн төсөл бэлтгэсэн болович уг төслүүдийг Засгийн газрын хуралдаанд танилцуулах шаардлагагүй болсон талаар ЭЗХЯ-наас мэдэгдсэн. | 70% | |
| 255 | 2 | 5 | **Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, хөгжлийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2022-01-11 Дугаар 2022_1**<br>5.Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд:<br>5.1.Аж үйлдвэржилтийн сэргэлтийн ерөнхий төлөвлөгөөг 2022 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах;<br>5.2.Тавантолгой болон бусад нүүрсний ордын усан хангамжийн асуудлыг судлан үзэж, хэрхэн шийдвэрлэх саналаа, говийг усжуулах төслийн хамт 2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулах;<br>5.3.Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх талаар 2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулах;<br>5.4.Газрын тос боловсруулах үйлдвэр, | 5.2 "Тавантолгойн ордыг түшиглэн баригдах төслүүдийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбарыг тодорхойлж шийдвэрлүүлэхтэй холбогдуулан Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэр болон кокс, эрчим хүчний үйлдвэрт шаардлагатай ус хангамжийг шийдвэрлэх боломжит хувилбарыг боловсруулан Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулга (presentation) бэлтгэн 2022.01.26-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, ЗГ-ын 2022.01.26-ны өдрийн 06 дугаар тэмдэглэл гарсан.<br>5.3 Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх талаар танилцуулга бэлтгэж, Засгийн газрын 2022.01.26-ны өдрийн ээлжит хуралдаанд танилцуулж, хуралдааны 6 дугаар тэмдэглэлийг гаргуулсан.<br>Тавантолгой нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах ус хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг усаар хангах "Загийн усны хоолой"-н газрын доорх усны ордоос шугам, хоолой татах ажлын зураг төслийг боловсруулж, БХБЯ-ны харъяа Барилгын хөгжлийн төвийн шинжээчдийн магадлалаар баталгаажуулсан. Загийн усны хоолойн газрын доорх усны ордоос ус татах шугам хоолойн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр "ЧММ" ХХК, "Эс Энд Эй Трейд" ХХК, "Набсан" ХХК-тай гэрээ байгуулан, барилга угсралтын ажил явагдаж байна. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Гүний худгийн ажил 77%, Ус цуглуулах шугамын барилга угсралт 48%, Усан сангийн барилга угсралт 81%, Ус дамжуулах гол шугамын барилга угсралт 60%, Цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил 81%-тай тус тус | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | дамжуулах хоолой барих төслийн бүтээн байгуулалтын ажлыг 2024 онд багтаан дуусгах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах;<br>5.5.Эрдэнэт, Оюутолгой болон зэсийн бусад ордуудыг иж бүрнээр нь ашиглаж, зэс боловсруулалтыг нэмэгдүүлэх, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийн талаар 2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдөрт багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулах;<br>5.6.Эрдэнэт үйлдвэрийн зэс боловсруулах үйлдвэрийн төсөлд хөрөнгө оруулалт татан хувилбарт санал боловсруулж, 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулах;<br>5.7.Цагаан суваргын зэсийн ордын ашиглалтыг дэмжих талаар хувилбарт санал боловсруулж, 2022 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулах;<br>5.8.Үндэсний баялгийн сангийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж, 2022 оны 1 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;<br>5.9.Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл анхдагч хуулийн төслийг боловсруулж, 2022 оны 01 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;<br>5.10.Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, 2022 оны 03 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх. | гэрээний дагуу гүйцэтгэгдэж байна. Нийт ажлын гүйцэтгэл 69.7%-тай байна.<br>5.4 Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн Технологийн бус барилга байгууламжийн ажил /EPC-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл **2022.12.16**-ны өдрийн байдлаар 77.0%-тай байна. Лицензгүй технологийн байгууламжийн ажил /EPC-2/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.6.06-ны өдөр зарласан ба 2022.09.19-ны өдөр тендер хүлээж авсан. Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /EPC-3/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.05.04-ний өдөр зарласан ба 2022.07.04-ний өдөр тендер хүлээн авсан. EPC-2, EPC-3 багц ажлын тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн БНЭУ-ын "Megha Engineering & Infrastructure Limited" (Мега инженеринг инфрастракчер лимитед) компанитай Инженерчлэл, худалдан авалт, барилгын угсралтын гэрээ байгуулах асуудлыг Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК, "Megha Engineering & Infrastructure Limited" компани хооронд 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр гэрээ байгуулсан. Лицензгүй технологийн байгууламжийн ажил /EPC-2/ , Цахилгаан стацын барилгын /EPC-3/ ерөнхий гүйцэтгэгч "Мега Инженеринг Инфрастракчр" нь барилгын ажлын өмнөх инженер геологийн судалгаа, геодезын хэмжилийн ажлыг хийж байгаа бөгөөд ажлын зураг төсөл инженерчлэлийн ажил хийгдэж байна. Лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /EPC-4/-ын лиценз эзэмшигчдийг шалгаруулсан, Устөрөгчийн байгууламжийн лиценз эзэмшигч Итали улсын Кинетикс текноложи компанитай, Хүхэр ялгах байгууламжийн лиценз эзэмшигч Франц улсын Аксенс компани, Бензин боловсруулах, Гидрокрекинг, Дизелийн гидроцэвэрлэгээ, Дизелийн гидроцэвэрлэгээ, Шингэрүүлсэн шатдаг хий ялгах байгууламжуудын лиценз эзэмшигч АНУ-ын ЮүӨүПи Хонивэлл компанитай тус тус гэрээг байгуулсан. Лицензтэй технологийн байгууламжийн Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгох тендерийн баримт бичиг боловсруулж байна.<br>5.5 Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дүгээр "Албан даалгавар"-аар даалгасны дагуу "Эрдэнэт, Оюутолгой зэрэг ордыг иж бүрэн ашиглаж, зэсийн боловсруулалтыг нэмэгдүүлэх төслүүдийн талаар" Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар УУХҮ-ийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 01/1590 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>5.6 Эрдэнэт үйлдвэрийн зэс боловсруулах үйлдвэрийн төсөлд хөрөнгө оруулалт татах хувилбарыг боловсруулахаар ажиллаж байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын "China ENFI Engineering" компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Тус ТЭЗҮ-д тооцсоноор төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 762,255.12 ам доллар байх бөгөөд үүний 30%-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгөөр, 70%-ийг зээлээр санхүүжүүлэхээр тусгасан.<br>5.7. Цагаан суваргын зэс, молибдений төслийг эрчимжүүлэх арга хэмжээний талаар танилцуулга бэлтгэж, Засгийн газрын 2022.04.20-ны өдрийн ээлжит хуралдаанд танилцуулж, хуралдааны 24 дүгээр тэмдэглэлийг гаргуулсан.<br>Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж, хуулийн төсөлд яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамнаас 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг ЗГХЭГ-аар дамжуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бүрдлийг ханган хүргүүлсэн. Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу 2022.11.01-ний өдөр хуулийн төсөл, дагалдах хууль болон холбогдох бусад бичиг баримтуудыг буцаахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт албан бичиг төлөвлөн хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" 192 дугаар захирамжаар Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Улмаар тус Ажлын хэсгийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн сайд ажиллах болсон тул холбогдох материалуудыг 2022 оын 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/3297 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайдад шилжүүлсэн. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 256 | 3 | 6 | **Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай**<br>**2022-07-05**<br>**Дугаар 2022_6**<br>1. 1.1. ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харъяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах; 1.2.""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах; | Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан "Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх" богино хугацааны сургалтыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Харьяа агентлаг Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн албан гэсэн 3 байгууллагын хүрээнд Удирдлагын академитай хамтран 100 албан хаагчийг оролцуулан 2022 оны 09 дүгээр сарын 16-17 ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан. | 100% | |
| 257 | 4 | 7 | **Сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлэх, өвөлжилтийн бэлтгэл хангах тухай**<br>**2022-07-28**<br>**Дугаар 2022_8**<br>2. 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах хүрээнд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг ашиглалтад орох хүртэл сайжруулсан шахмал түлшний түүхий эд /мидлинг/-ийг холбогдох стандартын дагуу тээврийн хэрэгсэлд ачиж буулгах, тээвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд, тээвэрлэлтийг авто замаар саадгүй, шуурхай зохион байгуулах арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ (Б.Гүрсоронзон), Зам, тээврийн хөгжлийн төв (Х.Пүрэвжаргал), Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддорж, Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат, Төв аймгийн Засаг | Сайжруулсан шахмал түлшний түүхий эд /мидлинг/-ийг холбогдох стандартын дагуу тээврийн хэрэгсэлд ачиж буулгах, тээвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж байна. Таван толгой түлш ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний түүхий эдийн (мидлинг) нөөц 2022 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар дундын агуулахад 5.9 мян.тн, баруун бүсийн үйлдвэрт 7.3 мян.тн, зүүн бүсийн үйлдвэрт 135.9 мян.тн, нийт 149.1 мян.тн тус тус байгаа бөгөөд барьцалдуулагч бодис 3.9 мян.тн нөөцтэй байна. Мөн сайжруулсан шахмал түлшний нөөц нийслэлийн 6 дүүрэгт байрлах агуулах болон үйлдвэрийн агуулахад нийт 80,607 тн байна | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | дарга Д.Мөнхбаатар, Цагдаагийн ерөнхий газар (Ж.Болд) нарт; | | | |
| 258 | 5 | 8 | **Сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлэх, өвөлжилтийн бэлтгэл хангах тухай**<br>**2022-07-28**<br>**Дугаар 2022_8**<br>3. Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг холбох бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, "Монголын төмөр зам" ТӨХК (П.Ганхүү), "Тавантолгой төмөр зам" ХХК (Н.Удаанжаргал) нарт, Тавантолгой уурхайн бүсэд байгаль орчинд ээлтэй ачилт, буулгалтын иж бүрэн байгууламж барих ажлыг шуурхай зохион байгуулахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, "Эрдэнэс Тавантолгой" ХК (Б.Ганхуяг), "Тавантолгой түлш" ХХК (Ц.Даваацэрэн) нарт; | Тавантолгой-Зүүнбаян болон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын төслийг санхүүжүүлэх зорилгоор "Эрдэнэс Тавантолгой" ХК болон "Тавантолгой төмөр зам" ХХК ЭТТ-2022/13 дугаартай санхүүжилтийн гэрээг байгуулсан бөгөөд төслийн бүтээн байгуулалтад 2022 онд нийт 218 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төслийн бүтээн байгуулалтын явц 98%-ийн гүйцэтгэлтэй явж байгаа бөгөөд техникийн комисс болон улсын комисс ажиллуулж, ашиглалтад оруулахаар ажиллаж байна. "Тавантолгой төмөр зам" ХХК нь "Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв" төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг 2021 оны 11 дүгээр сард Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр танилцуулсан. Тус техник, эдийн засгийн үндэслэлд төлөвлөснөөр төсөл нь бутлуур, конвейерийн систем, овоолго үүсгэгч, овоолгоос тэжээгч, ачилтын бункер зэрэг дамжлага бүхий бүрэн автоматчилагдсан, цогц системээр дамжуулан жилд нийт 20.0 сая тонн нүүрсийг төмөр замд ачих хүчин чадалтай байхаар тусгагдсан. Төслийн бүтээн байгуулалтын ажлыг 2022.04.22-нд эхлүүлсэн бөгөөд 2022.12.25-ны өдрийн байдлаар төслийн нийт гүйцэтгэл 55.8 хувьтай байна. "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн зүгээс төслийн бүтээн байгуулалтын ажлыг 2023 оны 4-р улиралд бүрэн дуусгаж, "Эрдэнэс Тавантолгой" ХК-д хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. | 100% | |
| | 113 | 258 | | **НИЙТ ДҮН: 85.33 хувь** | | |

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ